

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-64

| | |
|--|-------|
| 1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох | 4-64 |
| 2.Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох | 65-79 |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын болон Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан
2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 42 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 32 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг;
Чөлөөтэй: С.Лүндэг, З.Мэндсайхан, Н.Наранбаатар, Г.Очирбат,
М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга,
Б.Найдалаа, А.Ундраа, Ж.Чинбүрэн, Б.Тулга, Д.Үүрийнтуяа.

Нэг.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил”-ийн зохицуулагч Ж.Түвшинсанаа, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх Байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл”-ийн зохицуулагч Ж.Түвшинтөгс, “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зохицуулагч Л.Баяртулга, “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан төсөл”-ийн зохицуулагч Б.Отгонбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн танилцуулав.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар 13 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Ж.Батжаргал, Г.Ганбаатар, Ц.Идэрбат, М.Ганхүлэг, Д.Батлут, С.Ганбаатар, Д.Энхтуяа, Д.Бум-Очир, Д.Жаргалсайхан, Ж.Золжаргал, М.Бадамсүрэн, Т.Аубакир, Д.Пүрэвдаваа, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын

дарга Ц.Болорчулуун, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил”-ийн зохицуулагч Ж.Түвшинсанаа, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх Байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл”-ийн зохицуулагч Ж.Түвшинтөгс, “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зохицуулагч Л.Баяртулга, “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан төсөл”-ийн зохицуулагч Б.Отгонбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ц.Идэрбат, С.Замира, О.Амгаланбаатар, М.Бадамсүрэн, Д.Батлут, Д.Жаргалсайхан, С.Ганбаатар нар үг хэлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэнгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, мөн газрын Ус ашиглалт, технологийн хэлтсийн дарга Х.Мягмаржав, Төрийн захиргааны хэлтсийн дарга Д.Сайханжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Л.Мөнхбаясгалан, М.Ганхүлэг, М.Бадамсүрэн, Т.Аубакир нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, М.Ганхүлэг, С.Ганбаатар нар үг хэлэв.

Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулгын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 30 минут үргэлжилж, ирвэл зохих 42 гишүүнээс 27 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 32 минут.

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдөр амар амгаланг айлтгая. Аж үйлдвэржилтийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн байна, Дамбын Батлут гишүүн ирсэн байна, Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна, Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна, Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн байна, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Доржзодвын Энхтуяа гишүүн ирсэн байна. Гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52,4 хувьтай бүрдсэн тул Аж үйлдвэржилтийн болон БОХХАА-н байнгын хорооны хуралдаан 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье. Аж үйлдвэржилтийн болон БОХХАА-н байнгын хорооны хамтарсан хуралдааны хэлэлцэх асуудал танилцуулъя. Хэлэлцэх асуудал. 1.Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл тусламжийг хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох. 2-т Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох. Энэ өнөөдөр 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаан учраас Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Ганбаатар гишүүн бид 2 энэ хуралдааныг ээлжилж явуулна.

***Нэг.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл,
тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн
хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох***

Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсэг бүгд орсон уу? Ажлын хэсэг танилцуулъя. ХХААХҮЯ Жадамбын Энхбаяр ХХААХҮ-ийн сайд одоо Засгийн

хамтарсан хуралд байж байгаа юм байна. Эхлээд танилцчихаад ирээд асуултад хариулна гэсэн. Т.Жамбалцэрэн ХХААХҮЯ-ны ТНБД, Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Түвшинсанаа хөдөө аж ахуйн, Хөдөөгийн хөгжил төслийн зохицуулагч, Түвшинтөгс Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн зохицуулагч, Л.Баяртулга Мал аж ахуй, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн зохицуулагч, Б.Отгонбаяр Хүнсний ногоон үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан төслийн зохицуулагч, Э.Анар Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Гадаадын хамтын ажиллагааны хэлтсийн дарга.

Сайдын мэдээллийг Төрийн нарийн танилцуулж байх уу даа? ХХААХҮ-ийн салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх ХХААХҮ-ийн сайдын мэдээллийг хэн танилцуулах вэ? Төрийн нарийн Жамбалцэрэн танилцуулах юм байна. 4 номер уу, 3 номерт сууж байна уу? 4 Номер.

Т.Жамбалцэрэн: ХХААХҮЯ-ны ТНБД Жамбалцэрэн. Аж үйлдвэржилтийн бодлогын болон БОХХАА-н байнгын хороодын гишүүд, дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан зээлийн гэрээгээр 2000-24 онд ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд олон улсын 3 төсөл, 7 төсөл хэрэгжиж байна. 3 нь энэ 24 оны оноор дууссан. 4 төсөл нь одоо хэрэгжиж байна. Өнөөдрийн төслийн агуулгын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд, хэрэгжиж дууссан төсөл хөтөлбөрүүд, цаашид хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл гэсэн энэ агуулгын хүрээнд танилцуулах мэдээлэл өгнө.

Дэлхийн банкны санхүүжилттэй Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл одоо хэрэгжиж байгаа. Мөн Экспортыг дэмжих төсөл хэрэгжиж байгаад мөн 2024 онд энэ төсөл дууссан байгаа. АХБ-ны санхүүжилттэй 3 төсөл байгаа. Үүнээс Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалан төсөл одоо хэрэгжиж байгаа. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилтийн төсөл ХХААХҮ-ийн салбар дээр хэрэгжиж байгаад энэ 2024 оноор дуусгавар болгоод дууссан байгаа. Дараагийн 2 дахь шатын төслийг хэрэгжүүлэхээр гадаад салбарын яамнаас мөн Засгийн газар, Сангийн яамтайгаа хамтраад ажиллаж байгаа. Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах техник туслалцааны төслийг хэрэгжүүлээд мөн 2024 онд дууссан байгаа. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка байгууллагын эх үүсвэртэй жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төслийг ХХААХҮЯ-н дээр хэрэгжүүлж байгаа. Мөн Хөдөөг хөгжүүлэх олон улсын НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэдэх Хөдөөг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилттэй зах зээл, бэлчээрийн удирдлагын төслийг хэрэгжүүлж дууссан. Мөн дараагийн үе шатыг хэрэгжүүлэхээр ингээд ажиллаж байгаа юм.

Дэлхийн банкны санхүүжилттэй Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хувьд нийт санхүүжилт нь 30 сая долларын ийм санхүүжилт 2024-өөс, 25-аас, 2020-2025 оны хооронд хэрэгжиж байгаа. Төслийн гол зорилго нь энэ малын эрүүл мэнд, үр ашиг, бүтээмж болон төсөл хэрэгжих газрууд дахь нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах үндсэн зорилготой. Бүрэлдэхүүн хэсгийн хувьд 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэг нь малын эрүүл мэндийн үйлчилгээ, 2

дахь бүрэлдэхүүн хэсэг нь нэмүү өртгийн сүлжээ, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, 3-д нь төслийн хэрэгжилтийг дэмжих, 4-д нь болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ авах гэсэн ийм 4 бүрэлдэхүүн хэсэгтэй. 12 аймгийн 80 сумд хэрэгжиж байгаа ийм төсөл байгаа.

Төслийн үр дүнгийн үзүүлэлтүүд 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хувьд малын өвчинтэй тэмцэх, тандалт судалгааны нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх үндсэн зорилготой. Энэ хүрээндээ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдан гарсантай холбоотой дагаж гарч байгаа хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, баримт бичгүүдийг боловсруулах ажлууд хийгдсэн. Энэ дотроо бог малын өвчинтэй тэмцэх стратегийг боловсруулах, шүлхий өвчинтэй тэмцэх стратегийг боловсруулах гээд ОИЕ-гоос тавьдаг олон улсын хорио цээрийн нөхцөл шаардлагатай малын өвчнүүд дээр энэ стратегийг боловсруулж ажилласан байгаа.

Мөн шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тарилга вакциныг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан үр дүнтэй. Мөн энэ 21 аймгийн мал эмнэлгийн газруудыг чадавхжуулах чиглэлийн ажлууд, мал эмнэлгийн хяналтын цэгүүдийг чадавхжуулах ажлууд хийгдсэн. Тандалт судалгааны арга зүй боловсруулах тодорхой ажлуудыг хийсэн үр дүнгийн үзүүлэлттэй байгаа. Энэ дээр мал эмнэлгийн оношилгооны чадавхыг сайжруулах чиглэлээр 3 аймгийн бүсийн оношилгооны лабораторийг чадавхжуулсан. Дээр нь Био комбинатын өргөтгөл шинэчлэл буюу 1973 онд байгуулагдсан Монгол Унгарын хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн Био комбинат ТӨК байгаа. 1973 оноос хойш энд технологийн шинэчлэл огт хийгдээгүй байсан. Төслийн хөрөнгөөр Био комбинатын вирусийн вакцин үйлдвэрлэлийн лабораторид шугаман эсийн технологийг нэвтрүүлсэн. Үндсэндээ сүүлийн 50 жилд Био комбинатын өргөтгөл шинэчлэлт дээр хийсэн хамгийн үр дүнтэй томоохон ажил болж өгсөн гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй байх.

Бүрэлдэхүүн 2 дугаар хэсгийн хүрээнд Шинэлэг шийдэл хөтөлбөр, Тэжээлийн зангилаа төвийн үйлдвэрлэлүүдийг бүсчилж байгуулж байгаа. Энэ хүрээндээ Ховд аймгийн Жаргалант сумд Завхан аймгийн Тэс сумд, Төв аймгийн Эрдэнэсант, Төв аймгийн Борнуур, Улаанбаатар хот гэсэн энэ 5 бүсэд тэжээлийн зангилаа төвүүдийг байгуулж байгаа. Энэ нь болзошгүй эрсдэл, гамшгийн эрсдэлийг бууруулахад энэ эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд тэжээлийн нөөц баазыг бүсчилсэн хөгжил байгуулсан байгаа. Төслийн хөгжлийн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтүүдийг дэлгэц дээр харуулж байна. Ялангуяа 1900, 2024 оны 12 сарын эцсийн байдлаар энэ дүнгүүдийг бид авч үзсэн. Тухайлбал малын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр бид малын гоц халдварт урд өвчин гарсан тохиолдолд 10 хувь бууруулна гэдэг зорилтыг дэвшүүлсэн. Өнгөрсөн төсөл хэрэгжиж байгаа хугацаанд бруцеллөз өвчин 0,6 хувьтай, шүлхий өвчин 2,5-тай, бог малын мялзан өвчний дэгдэлт 4,6 хувьтай энэ түвшинд нь тогтмол барьж ажиллаж байгаа.

Нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарцыг өсөн нэмэгдүүлэх, ялангуяа мах сүүний чиглэлийн бог, бод мал дээр ажилласан байгаа. Мөн бог малын амьдын жингийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр сүүний гарцыг нэмэгдүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүний инфляцын цэвэршүүлсэн үнийн өсөлтийг нэмэгдүүлэх энэ тодорхой зорилтуудыг дэвшүүлж ажилласан. Энэ дэлгэц дээр зорилтот

түвшин, суурь түвшнүүдийг ингээд тавьж өгсөн байгаа. Төсөл маань 25 оны 12 сараар дуусна. Өнөөдрийн байдлаар төслийн хэрэгжилт 68 хувьтай үргэлжлээд явж байгаа. Төслийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнгүүдийн үзүүлэлт гээд зорилтуудаар салгаж авч үзвэл малын эрүүл мэндийн үйлчилгээ дээр 7 арга хэмжээ, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх чиглэл дээр 8 арга хэмжээ, төслийн хэрэгжилтийг дэмжлэг үзүүлэх хэсэг дээр 3 арга хэмжээ, болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ авах арга хэмжээ дээр 5 арга хэмжээг төлөвлөж зорилтот түвшнүүдийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг танилцуулж байна.

Үр дүнгийн үзүүлэлтүүдийн хувьд 2021 оноос энэ төслийн өөрийнх нь хэрэгжсэн хугацааг ковидын үетэй давхацсан учраас төслийн хэрэгжилт дээр тодорхой хэрэгжилт удааширсан асуудлууд байгаа. Дээр нь энэ 20, 21 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал дээр нэлээн хүндрэлүүд гарсантай холбоотой 4 дүгээр бүрэлдэхүүн хэсгийг идэвхжүүлж, 180 мянган малчин өрхөд дэмжлэг мөнгөн дэмжлэг үзүүлсэн. Зудын хариу арга хэмжээ авах зорилгоор 45 мянган, 45,5 мянган малчинд тэжээлийн дэмжлэг үзүүлсэн энэ арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үндсэндээ 30 сая долларын арга хэмжээний 18 сая доллар нь энэ болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний үйл ажиллагаанд зарцуулагдсан ийм дүнтэй байгаа.

ХХААХҮ-ийн салбар дээр хэрэгжсэн дараагийн нэг төсөл Экспортыг дэмжих төсөл хэрэгжээд өнгөрсөн онд дууссан байгаа. Нийтдээ санхүүжилтийнх нь хэмжээ нь 20 сая ам.долларын санхүүжилттэй. Өмнө нь Сангийн яам, Монголбанкны хэлэлцээртэй хэрэгжиж байгаад 2021 онд ХХААХҮ-ийн сайдын сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгдэж ирсэн ийм төсөл байгаа. Төслийн үндсэн зорилго нь энэ уул уурхай бус салбарын ЖДҮ-лэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх, мөн Ковид 19 цар тахлын үр нөлөөг бууруулахад дэмжлэг үзүүлнэ гэсэн ийм зорилготой хэрэгжиж байсан төсөл. Мөн 4 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй.

Энэ дотроо экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, экспортын өрсөлдөх чадвар зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагыг сайжруулах, төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх гэсэн ийм 4 үзүүлэлттэй хэрэгжсэн. Төслийн хэрэгжилтийн гүйцэтгэл нь 95,6 хувьтай дүгнэгдсэн. Тайланг Үндэсний аудит болон Дэлхийн банк, Олон улсын хөгжлийн ассоциаци тайлангуудыг холбогдох тайлангуудыг хүргүүлж дуусгасан байгаа. Энэ хүрээндээ бид 6 шалгуур үзүүлэлтүүдээр төслийн үр дүнг тооцож гаргасан. Зорилтот түвшнийх нь дүнгээр. Энэ дотроо төслийн үр шим хүртэгчдийн экспортын өсөлтийн хувь хэмжээ, төслийн дэмжлэгтэйгээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын баталгаажуулалт авсан ААН, жижиг, дунд бизнес эрхлэгчдийнх нь тоогоор, мөн энэ экспортын даатгал шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, зах зээлд нэвтрэхтэй холбоотой зөвшөөрлүүд олгоход нь хөнгөвчлөх, цар тахлыг даван туулахад ЖДҮ-лэгчдэд дэмжлэг үзүүлэх, төслөөс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудад хамрагдаж экспортолж эхэлсэн компаниудын тоо хэмжээгээр энэ шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож өгсөн.

Шалгуур үзүүлэлтүүдийнх нь дүнгээр аваад үзвэл төслийн үр шим экспортын өсөлтийг хувь хэмжээг 25 хувийн зорилтод хүргэнэ гэсэн. Энэ 25 хувийнхаа зорилтод хүрсэн. Энэ нь зөвхөн төсөлд хамрагдсан ААН-ийнхээ

хүрээнд авсан дүн байгаа. Мөн төслийн дэмжлэгтэй олон улсын хүлээн зөвшөөрч чанарын баталгаажуулалт авсан компаниудын тоо 25 хувьд хүргэх. Энэ Дэлхийн банкнаас тавьдаг энэ байгаль орчин, жендер, нийгмийн үнэлгээний зорилтууд дээр нь бас тулгуурлаж, үр дүнгийн зорилтууддаа хүрсэн гэж үзэж байгаа. Энэ зорилтуудаас тодорхой түвшинд хүрээгүй зорилтууд байгаа. Тэр дотор энэ экспортын даатгалын асуудлууд, кластеруудыг үр дүнтэй хөгжүүлэх гэсэн энэ 2 заалт тодорхой үр дүнд хүрээгүй ийм үзүүлэлтүүд байгаа. Энэ үзүүлэлтүүд нь төслийн үр дүнг 100 хувь хүргэх зорилтоос хойш нь татсан байгаа юм.

ХХААХҮЯ-ан дээр одоо хэрэгжиж байгаа нэг төсөл энэ Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуйн төсөл байгаа. АХБ-ны эх үүсвэртэй зээлийн төсөл. Нийтдээ 42 сая долларын санхүүжилттэй, 2025-аас 2026 оны 12 сар хүртэл хэрэгжих ийм төсөл. 11 аймгийн 19 сум, Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа. Гол зорилго нь энэ уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, маркетингийн үр ашгийг дээшлүүлэх замаар өрхийн жижиг хүнсний ногооны үйлдвэрлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой. 3 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. 1 дүгээрт нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, үр ашигтай усжуулалтын систем бий болж, менежментийн тогтолцоог сайжруулах, байгаль орчны хувьд тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоог сайжруулах, мэргэжил арга зүйн институт, удирдлагын чадавхыг болон уялдаа холбоог сайжруулах гэсэн ийм 3 бүрэлдэхүүн хэсэгтэй байгаа.

Төслийн хүрээнд өнөөдрийн байдлаар 10 услалтын системийн ажлыг гүйцэтгээд явж байгаа. Нийтдээ 6451 га-г усжуулах ийм төсөл хэрэгжиж байгаа. Нийтдээ төслийн үндсэн зорилт нь 8 мянган га-г бид усжуулалтын ажлыг хийнэ гэж үзэж байгаа. Энэ дотор Ховд аймгийн Алтай сумын 300 га, Завхан аймгийн Тэлмэн сумын Хүрмэн талын 500 га, Хэнтий аймгийн Хэрлэн сумын Дулааны талын 700 га, Говь-Алтай аймгийн Жаргалант сумын Цахирын 206 га, Говь-Алтай Халиун сумын Ёлтоны услалтын систем 320 га, Завхан аймгийн Улиастай сум Ногоон хашаа 64 га, Баян-Өлгий аймгийн Баяннуур суман дээр Цул-Улааны 161 га, Баян-Өлгий аймгийн Сагсай суманд Улаан дэлийн 400 га, Сэлэнгэ аймгийн Сант сум Ивэн голын 240 га, Төв аймгийн Батсүмбэр сумын Сөгнөгөрийн 140 га гэсэн эдгээр ажлын усжилтын системүүдийн барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлууд хийгдээд явж байгаа.

Энэ 10 усжилтын систем гүйцэтгэл нь 87%-тай. Гэрээний дүн нь 57,3 сая төгрөгийн тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн байгаа. 25 онд 5 аймгийн 10 сумыг шинээр усжилтын систем байгуулахаар төлөвлөсөн. Энэ дотроо Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Шаамар, Баруунбүрэн, Орхон, Жавхлант гэсэн 5 сум, Дархан-Уул аймгийн Орхон сум, Орхон аймгийн Жаргалант сум, Төв аймгийн Жаргалант, Борнуур, Хэнтий аймгийн Мөрөн сум гээд нийтдээ 4,5 мянган га талбайг усжуулалтын ажил, өргөтгөл шинэчлэлийн ажил, сэргээн засварлах ажлуудыг хийхээр ингэж төлөвлөж байгаа. Ингээд үзвэл нийт дүнгээрээ бид 8 мянган га-г усжуулах төлөвлөгөөтэй. Төслийн хүрээнд бид 11 мянган га талбайг усжуулах услалтын системийн өргөтгөлийн ажил болон шинээр болон өргөтгөлийн ажлуудыг сэргээн засварлах ажлуудыг хийх ингэж бололцоо бүрдэж байгаа юм.

Мөн энэ ХХААХҮЯ-н дээр Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл хэрэгжээд явж байгаа. Энэ төсөл маань нийтдээ сая 50 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа. 2016 оноос 2021 оны хооронд энэ зээлийн

хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хэрэгжсэн. 21 онд ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж ирсэн. Ингэхдээ зээлийн хөрөнгийн зарцуулалт бүрэн дууссан. Эргэн төлөлтөөс 18 тэрбум төгрөгийн зээлийг санхүүжүүлэх ийм өртөгтэй ХХААХҮ-ийн салбарт шилжиж ирсэн. Төслийн зорилго нь агро бизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих, ажлын байрыг бий болгох, улсын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах гэсэн ийм чиглэлтэй хэрэгжсэн төсөл.

Төслийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд 1 дүгээрт нь нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтын ийм 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэгтэй. Энэ нь арилжааны банкин дээр зээл хэлбэрээр төслүүдийг санхүүжүүлэх, арилжааны банк эрсдэлийг бүрэн үүрэх, төслийн санхүүжилтийнх нь хугацаа 7 жилийн хугацаатай, хүүгийн хэмжээ нь 8 хувийн хүүтэй ийм зээлүүдийг олгож эхэлсэн. Энэ хүрээндээ 50 орчим нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлнэ гэсэн ийм зорилтыг тавьсан. Мөн 50 орчим нэмүү өртгийн сүлжээ, хөрөнгө оруулалтын төсөлд урьдчилсан үнэлгээ хийж дуусгана гэсэн ийм зорилтыг тавьсан. Давхардсан тоогоор 800 гаруй ажилтан, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын 120 ажилтан, санхүү, байгаль орчны чиглэлээр тавьдаг заавал биелүүлэх шаардлагатай жендер, мониторингийн чиглэлээр сургасан байх ёстой гэсэн ийм төслийн үндсэн зорилго байсан. Үүнийг 58 төслийг санхүүжүүлсэн, 66 төсөлд үнэлгээ хийсэн, 3600 гаруй төсөлд хамрагдсан төслийн үр шим хүртэгч ажилтан, албан хаагчдыг сургасан гэсэн ийм, эмэгтэйчүүдийг сургасан гэсэн ийм дүнтэй байгаа.

2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хувьд малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжсэн. Энэ дотроо төслийн дэмжлэг авсан малчин фермерийн 120 хоршоодын үйлдвэрлэлийг 20 хувиас доошгүй хувиар нэмэгдүүлнэ гэсэн ийм зорилтыг тавьсан. Төслийн хүрээнд энэ зорилтыг давуулан биелүүлж, 20 хувиар өсгөсөн. Энэ хүрээндээ бид 132 хоршоо, ноосны 15 хоршооны үйлдвэрлэл, 13 зөгийн үйлдвэрлэлийн ААН-ийг дэмжиж, тодорхой ноосны үйлдвэрлэл дээр 66 хувь, зөгийн аж ахуй дээр 42,5 хувиар нэмэгдүүлж чадсан үр дүнтэй байгаа. 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд мөн давхардсан тоогоор 5500-аас доошгүй малчин, фермер, анхан шатын үйлдвэрлэгчид, орон нутгийн засаг захиргааны төлөөллийг сургалтад хамруулах зорилтыг тавьсан. Үүний 40 хувь нь 40-өөс доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Төслийн нийт үр дүнгээр бид 8200 хүнийг сургасан. Үүний 53,6 хувь нь эмэгтэйчүүд байсан гэсэн үр дүнгийн үзүүлэлтээр төслөө дуусгасан байгаа.

ААН-үүдийн маркетинг, техникийн хүчин чадал, чадамжийг сайжруулах зорилтын хүрээнд тодорхой зорилт дэвшүүлсэн. Энэ дотроо ААН-ийн маркетинг, техникийн чиглэлээр сургах зорилт дэвшүүлсэн. 350 хүнийг сургана гэсэн бол зорилтод түвшний хүрээнд бид 2800 хүнийг сургана гэсэн зорилт тавьснаас 2400 хүнийг сургаж, 66 хувьд нь эмэгтэйчүүдийг хамруулсан ийм үзүүлэлттэй. Ноос ноолуур, арьс ширний салбарын ААН-үүд зориулсан техникийн удирдамж гарын авралыг боловсруулах чиглэлээр нийт 8 гарын авлагыг боловсруулсан. Энэ дотор ноос арьс, ширний чиглэлийн гарын авлагуудыг илүүтэй боловсруулсан дүнтэй байгаа. Чацарганын салбарын зорилтот зах зээлийн судалгааг хийж дуусгасан. Энэ төслийн хийсэн судалгааны үр дүн дээр олон улсын стандарт, кодексийн стандартыг боловсруулах ажил үргэлжлээд хийгдээд явж байна. Махны салбарын зорилтот зах зээлийн судалгааг хийх чиглэлээр Ойрх Дорнодын улсуудын мах, зах зээлийн судалгаануудыг хийсэн. Эхнээсээ судалгааны үр дүн дээр тулгуурлаад

Ойрх Дорнодын орнуудад мах, махан бүтээгдэхүүн экспортлох ажлууд хийгдээд явж байгаа ийм үр дүнтэй байгаа.

Монгол бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэх ажил төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг байсан. Энэ хүрээндээ бид ялангуяа ноолуурын салбар дээр Монголын Хаан ширхэгт гэрчлэх тэмдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх баталгаажуулалтыг бий болгож, 3 компанид зөвшөөрлийг өгч, гадаад зах зээлд Монголын ноолууран бүтээгдэхүүн Хаан ширхэгтээр баталгаажсан гэсэн ийм стандарттайгаар гараад явж байгаа гэдгийг хэлье. Зөөгийн 2 компани дээр хамтын ажиллагааны хүрээнд тодорхой гэрээ хийж, олон улсын чанарын баталгаажуулалтад хамруулсан үр дүнтэй байгаа.

ХХААХҮЯ-ан дээр АХБ-ны санхүүжилттэй Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл хэрэгжсэн. Нийтдээ 3,5 сая долларын техник туслалцааны хөрөнгө, энэ дотроо АХБ болон Японы Засгийн газрын ядуурлыг бууруулах сангийн санхүүжилттэй хэрэгжсэн байгаа. Төсөл маань 4 аймгийн 4 сумд хэрэгжсэн. Төв аймгийн Борнуур сум, Дархан-Уул аймгийн Хонгор сум, Увс аймгийн Улаангом сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сумдууд. Төслийн гол зорилго нь хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хүнсний ногоо тариалагч иргэн, хоршоог дэмжих, хүнсний ногооны үйлдвэрлэлийн ажлыг механикжуулах, механикжсан зоорь, 4 улирлын хүлэмж барих, барьж байгуулах ажлыг хийж гүйцэтгэж, дотоодын үйлдвэрлэл хүнсний ногооны тариалалтыг дэмжих, ажилгүйдэл ядуурлыг бууруулах үндсэн зорилготой байсан.

Ялангуяа энэ манай Увс аймгийн Улаангом сум, Төв аймгийн Борнуур сум, Дархан-Уул аймгийн Орхон сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сумдууд маань өөрөө манай газар тариалангийн салбар тэр дотроо хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг гол хийдэг сумдууд байгаа. Эдгээр сумдуудаа чадавхжуулах чиглэлээр энэ төслийн маань үр дүнгүүд тулгуурлаж ажилласан. Үндсэндээ 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. Хоршоо хэлбэрээр ажиллах ногоочдын бүлгүүдийг байгуулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй тогтвортой ногооны аж ахуй эрхлэх технологи, туршлага нэвтрүүлэх, ногоочин өрхүүдийн зах зээлд хүрэх боломжийг нь нэмэгдүүлэх, борлуулалтад нь дэмжлэг үзүүлэх ийм бүрэлдэхүүн зорилтыг дэвшүүлж ажилласан.

Энэ хүрээндээ төслийн хэрэгжиж байгаа 4 сумын 39 бүлгээс хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийн чиглэлээр 2 хоршоо, хүнсний ногооны үйлдвэрлэлийн чиглэлээр 3 хоршоо, хүнсний ногооны боловсруулалт, савлагаа, борлуулалтын чиглэлээр 1 хоршоо, хүлэмжийн хүнсний ногооны үйлдвэрлэлийн чиглэлээр 1 хоршоо нийтдээ 7 хоршоог байгуулж, холбогдох дэмжлэгүүдийг үзүүлсэн. Төслийн хоршоодод газар тариалан эрхлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламжуудыг төсөл хэрэгжүүлсэн хугацаанд төсөлд хамрагдсан иргэн, ААН, хоршоодод хүлээлгэн өгсөн. Энэ Улаанбаатар хотод Хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит компанид 800м² дэвшилтэт технологийн хүлэмжийг барьж байгуулж, хүлээлгэж өгсөн үр дүнтэй байгаа. Ногоочин өрхүүдэд зах зээлд хүрэх боломжийг нь нэмэгдүүлэх, борлуулалтын дэмжлэгийг үзүүлэх чиглэлээр хүнсний ногооны үр, хүнсний ногооны борлуулах 6 цэгийг байгуулж, хоршоодод олгож, үйл ажиллагааг нь дэмжиж байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: Дууссан уу, нэмж хариулах юм уу? Нэмж танилцуулъя мэдээллийг.

Т.Жамбалцэрэн: Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл хэрэгжиж дууссан төслийн үр дүнг танилцууллаа.

ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараагийн нэг хэрэгжиж байгаа төсөл Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл байгаа. Санхүүжүүлэгч байгууллага нь Японы олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллага. Үндсэндээ 3 шатны төсөл хэрэгжсэн. 1 дүгээр үе шат нь 2006-аас 2010 оны хооронд, 2 дугаар үе шат нь 2011-ээс 2015 оны хооронд, 3 дугаар үе шат нь 2016 оноос хэрэгжээд явж байгаа. 18 оноос 3 дугаар үе шат нь хэрэгжээд явж байгаа. Төслийн үндсэн зорилго нь ядуурлыг бууруулж, тогтвортой хөгжлийг дэмжих, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хувийн хэвшлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, төсөлд оролцогч банкнууд болон ЖДҮ-лэл, бизнес эрхлэгчийг чадавхжуулах гэсэн ийм үндсэн зорилготой цэвэр зээлийн төсөл байгаа. 6 арилжааны банкаар дамжиж хэрэгжсэн.

Зээлийн нөхцөл нь 10 жилийн хугацаатай, эхний 3 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгддөг. 800 хүртэл сая төгрөгийн санхүүжилтийг олгодог зээл. Улсын хэмжээнд хэрэгжсэн ийм төсөл байгаа. 1 дүгээр үе шат нь 2006-аас 2010 онд хэрэгжсэн гэж хэлсэн. Нөхцөл бол улсын төлөх дүн бол 40 жилийн хугацаатай, ААН, иргэд 10 жилийн хугацаатай авч байгаа зээл. 1 дүгээр шатдаа 25 сая долларыг зарцуулсан. 2 дугаар үе шатад 2011 оноос 18 онд 62 сая долларыг зарцуулсан. 18-аас 24 оны хугацаанд эхний 2 үе шатын санхүүжсэн эргэн төлөлтийн дүнгээр нь дараагийн энэ 3 дугаар үе шатын төслийн зээлийг санхүүжүүлсэн үр дүнтэй байгаа. Мөн 21 онд ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж ирсэн. Өмнөх үе шатууд нь Сангийн яаман дээр хэрэгжиж байгаад шилжиж ирсэн ийм төсөл байгаа.

1 дүгээр үе шатдаа нийтдээ 30,6 тэрбум төгрөгийн зээлийг 103 ААН-үүдэд олгосон. 2 дугаар үе шатад 74,7 тэрбум төгрөгийн зээлийг 222 ААН-д олгосон байгаа. Зээлд хамрагдаж байгаа ААН-үүд нь Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулиар заасан ЖДҮ-лэлийн хуулийн үйлчлэх хүрээний хязгаарт багтаж байгаа ААН-үүд хамрагддаг ийм төсөл. 3 дугаар үе шатад 121 тэрбум төгрөгийг 249 ААН-д энэ зээлийг олгосон ийм дүнтэй байгаа. Төслийн нийт үр дүнгээр нь аваад үзвэл нийтдээ 27486 ажлын байрыг бий болгосон ийм төслийн үр дүнтэй байгаа. Ялангуяа энэ хот суурин газар, хөдөө орон нутагт жижиг, дунд бизнесийг дэмжихэд хөгжүүлэхэд гол ач холбогдолтой байсан. Тэр дотроо байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлд тодорхой санхүүжилтүүдийг олгож ирсэн. Ажлын байрыг хадгалах, шинээр бий болгоход бол хамгийн үр дүнтэй хэрэгжсэн төслүүдийн нэг гэж ингэж үздэг.

Мөн импортыг орлуулах чиглэлээр нэмүү өртөг шингэсэн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан. Экспортыг дэмжих, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл хөгжүүлэхэд тодорхой үр дүнд хүрсэн. Дэвшилтэт технологи нэвтрүүлэх ашиглахад чухал үр дүн үзүүлсэн гэсэн ийм төслийн хаалтын үр дүнгүүд байгаа. 25 онд нийтдээ 14, 18 тэрбум төгрөгийн эх үүсвэр бидэнд эргэн төлөлтөөс хуримтлагдаж байгаа. Энэ онд энэ эх үүсвэрийг

жигжиг, дунд үйлдвэр, ААН-үүдэд энэ зээлийг олгоод 25 онд энэ төсөл маань дуусаж байгаа. Хамгийн манай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар, арилжааны банк, банк санхүүгийн зах зээл дээр хамгийн үр дүнтэй хэрэгжсэн төслүүдийн тоонд орж байгаа учраас бид дараагийн үе шатуудыг эхлүүлэх чиглэлээр ажиллаж байгаа. Нийтдээ 382 тэрбум төгрөгийн төслийн санхүүжилтийг энэ 3 үе шатыг хэрэгжүүлэхэд олгосон байгаад байгаа. Энэ дотроо 1026 дэд төслүүдийг санхүүжүүлсэн 21 аймаг, Улаанбаатар хотын хэмжээнд. 15 мянган ажлын байрыг шинээр байгуулсан гэж хэлсэн.

Төслийн нийт дүнгээр нь аваад үзэхээр ААН-үүдийн борлуулалтын орлогыг 30 хувиар нэмэгдүүлсэн, байгаль орчныг хамгаалах чиглэлээр 118 дэд төсөл санхүүжилт хийгдсэн ийм байгаа. Энэ ялангуяа энэ нөгөө утааг бууруулах, жигжиг, дунд, төвлөрлийг сааруулах чиглэлээр нэлээдгүй үр дүнтэй хэрэгжсэн байгаа. Нийт төслийн хэмжээнд нэг зээлийн 5 хувь нь эрсдэлтэй гэсэн ийм хаалтын дүн гарсан. Эрсдэлтэй гэдэг маань өөрөө арилжааны банкаар дамжиж явж байгаа учраас эрсдэлийг цэвэр арилжааны банкнууд үүрч, эргэн төлөлтийг бий болгож байгаа. Төслийнхөө анхны зорилтыг 4-өөс 5 дахин нэмэгдүүлсэн үр дүнтэй төслийн нэг байгаа юм. Тэгээд төслийн үр дүнг Японы Засгийн газар, Монгол Улсын Засгийн газарт тайлангуудыг бүрэн хүргүүлж ажилласан.

Хэрэгжүүлсэн салбар дүнгүүд нь боловсруулах үйлдвэрлэл дээр 60 хувь, үйлчилгээний салбар дээр 19 хувь, байгаль орчныг бууруулах дээр 17 хувьтай газар, тариалан мал аж ахуй дээр эрчимжсэн аж ахуй, фермерийн аж ахуй дээр 4 хувьтай хэрэгжүүлсэн. 3 дугаар үе шатад хамрагдсан аймаг, нийслэлээр нь дүнгүүдийг энд тавьсан байгаа 419 төсөлд 128,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан дүнтэй байгаа.

Өнгөрсөн онд дууссан, хэрэгжиж дууссан дараагийн нэг төсөл энэ НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэдэх Хөдөөг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилттэй Зах зээл, бэлчээрийн удирдлагын төсөл хэрэгжиж дууссан. Нийтдээ 10,5 сая ам.долларын зээлийн хэлэлцээртэй төсөл. 1 дүгээр үе шат нь 2012-оос 17 онд хэрэгжиж дууссан. 18-аас 23 онд 9,6 сая ам.долларын санхүүжилттэй хэрэгжсэн. 1 дүгээр үе шат нь 5 аймагт хэрэгжсэн, 2 дугаар үе шат нь 6 аймагт хэрэгжсэн. Энэ төслийн давуу тал нь хамтын санхүүжилтийн хэлбэр дээр хийгдсэн. 2 дугаар шатын төслийг тухайн хэрэгжиж байгаа аймгуудтай 50, 50 хувийн санхүүжилттэй, төслөөс 50 хувийг санхүүжүүлэх, орон нутгаас 50 хувийг нь санхүүжүүлэх хэлбэрээр хэрэгжүүлснээрээ нэлээн тийм онцлог давуу талтай, хүрэх үр дүнгүүд нь сайн үр дүнд хүрсэн ийм төсөл хэрэгжээд дууссан байгаа. Мөн энэ манай Засгийн газар дээр хэрэгжсэн төслүүдийн үр дүнгээр энэ сайн хэрэгжсэн төсөлд хамаарагдаж, дараагийн үе шатыг нь хэрэгжүүлэхээр ингээд ажиллаж байгаа. Зорилтот түвшний үзүүлэлтүүдийг нь энэ дээр харуулж байна. Ялангуяа зорилтот түвшнүүдийг 2-оос 3 дахин давуулан биелүүлсэн ийм үр дүнтэй байгаа.

Дараа нь шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хэд хэдэн төслүүд байгаа. Ялангуяа энэ АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилтийн төслийг хэрэгжүүлэхээр зээлийн хэлэлцээрүүд нь хийгдэж байна. Их Хурлаар соёрхон баталчихсан явж байгаа. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн дараагийн үе шатыг Ногоон өрсөлдөх чадвартай хөдөө аж ахуй төслийн дизайныг боловсруулах, энэ дотроо Био комбинатын өргөтгөл шинэчлэлийг хийх чиглэлээр төслийн дизайныг боловсруулаад ажиллаж байна. Сая хэлсэн энэ НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэдэх

Хөдөөг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр хэрэгжсэн Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилтийн төслийн дараагийн үе шатыг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Хөдөөг хөгжүүлэх олон улсын сангаас эцсийн хариу эцэслэгдээд ирэх юм бол Улсын Их Хурлаар соёрхон батлаад, дараагийн үе шатыг нь хэрэгжүүлэхээр ингээд явж байгаа. Мөн түрүүн хэлсэн Жайкагийн 2 үе шаттай зээлийн дараагийн үе шатыг хэрэгжүүлэх чиглэлээр яриа хэлэлцээрийн түвшинд явж байгаа гэдгийг бас хэлье.

ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа болон үр дүнтэй хэрэгжсэн төслүүдийн үр дүнг товч танилцууллаа.

Б.Бейсен: ХХААХҮ-ийн салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар ХХААХҮ-ийн сайдын мэдээллийг танилцуулсан ТНБД Жамбалцэрэнд баярлалаа. 2 Байнгын хороо хамтарч хуралдаж байгаа учраас сайдаа дуудаарай. Бас энэ асуултад хариулах ёстой 1 дүгээрт.

2 дугаарт хуулийн юутай холбоотой нэг тайлбар хийгээдэхье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116.1-д хуульд заасны дагуу эсхүл Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар ЗГ-ын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцсан тайлагнадаг байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно гэж заасан байгаа. 2 дахь тайлбар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116.3-д Байнгын хороо энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж Улсын Их Хурлаас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно гэсний дагуу ингээд хэлэлцэж байгаа.

Нөгөө талаар манай Байнгын хорооны гишүүдээс хүсэлт гарсан. Түрүүн 2 удаа энэ мэдээллээ хошлуулсан сайд. 1 удаа удирдах ажилтны зөвлөгөөн гэсэн, дараа бас энэ хойшлогдсон. Энэ удаад тайлбар хийнэ сайд дуудаарай. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрс өгнө үү? Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ирцээрээ гарчихсан байна. Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Байгалийн гамшиг онцгой байдлын үед хариу арга хэмжээ авахад гээд танай энэ Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл дээр 13 сая ам.доллар төсөвлөгдөөд 25 хүртэл хэрэгжээд явж байгаа юм байна. Энэ байгалийн гамшиг онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах гэдэг дээр яг ямар, ямар ажлууд ордгийг нь та хэд тоочоод хэлээд өгөөч. Энд ер нь өвөлжилтийн бэлтгэл ажил ордог уу? Малчдад ер нь өвөлжилтдөө ингэж бэлтгэе гэсэн байдлаар тус дэм үзүүлэх тиймэрхүү ажлууд явдаг уу? Эсвэл аливаа нэг байгалийн гамшиг явагдсаны дараа зуд турхан болдог ч юм уу тэрний дараа дэмжлэг байдлаар үйл ажиллагаанууд явдаг уу? Энэ нэг асуулт байна.

2-т нь мөн л энэ нөгөө аймгийн сонголт, сумдын сонголт байна л даа. 12 аймгийн 80 сум. Тэгээд ер нь баруун, төв, тэгээд зүүн аймгийн хэдэн сумд л байна шүү дээ, бас бүгдээрээ биш юм. Энэ сонголт яг яаж хийгдээд байдаг юм бэ, нэмж болох уу?

Б.Бейсен: 4 номерт микрофон өгье.

Т.Жамбалцэрэн: Уянга гишүүний асуултад хариулъя. Өвөлжилтийн бэлтгэлийг хангах чиглэлээр жил болгон ЗГ дээр өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ЗГ-ын тогтоол гараад явдаг. Энэ дээр аймаг, сум, малчин, иргэн, ААН тодорхой түвшинд өвөлжилтийн бэлтгэлээ хангах ажлыг зохион байгуулдаг. Төслийн энэ 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг зайлшгүй гамшгийн хэмжээнд асуудал үүссэн тохиолдолд идэвхжүүлэх ийм агуулгатай төслийн үндсэн зорилт орж тусгагдсан. Ялангуяа 2020 оны өвөл, 21 оны хавар болсон байгалийн гамшиг зудын үед малчин өрхийг дэмжих чиглэлээр 180 мянган малчин өрхөд нэг удаад буюу 100 мянган төгрөгийн дэмжлэгийг 21 онд үзүүлсэн. 20 онд зудад хамгийн өндөр нэрвэгдсэн бүс нутгийн аймгуудад 45,5 мянган малчин өрхөд тэжээлийн дэмжлэгийг үзүүлсэн байгаа. Тухайн төслийг төслийн дизайныг боловсруулах үед буюу төслийн үндсэн зорилтот агуулга хэсгийн хүрээнд малын эрүүл мэндийг хамгаалах энэ чиглэлээр тодорхой судалгаануудыг, малын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс нутгуудыг тохиожих чиглэлээр төслийн багийнхан төслийн дизайнаа боловсруулах судалгааны ажлыг хийдэг.

Эргээд төслийн дизайнаа боловсруулаад, ЗГ дээр хэлэлцүүлээд, Улсын Их Хурлаар соёрхон батлаад ингээд хэрэгждэг төсөл байгаа. Энэ төсөл маань 25 оны 12 сард дуусах байгаа. Тийм учраас одоо бол энэ төсөл дээр бүрэлдэхүүн хэсэг дээр аймаг орон нутгийг нэмэх бололцоо байхгүй. 12 аймгийн 80 сумдаа төслүүд маань хэрэгжээд явна. Энэ зудын эрсдэлийг бууруулах, малын тэжээлийн бэлтгэл нөөц хангамжийг бүрдүүлэх чиглэлээр түрүүн танилцуулгад хэлсэн. Тэжээлийн 4 НУВ-ыг бид бүсчилсэн хэлбэрээр тусгаж өгсөн. Төслийн маань эхнээсээ дэмжлэг авсан ААН-үүдийнх нь үйл ажиллагаа жигдрээд, тухайн бүс нутгууддаа өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлд нь тодорхой хувь нэмэр оруулаад явж байгаа.

Б.Бейсен: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Ер нь цааш цаашдаа ингээд энэ төсөл дуусаж байгаа юм байна. Цаашдаа дахиад нэг ийм зээлийн санхүүжилтийн төслийн хөтөлбөр дээр магадгүй яам суугаад эхэлж л байгаа байх. Түүн дээрээ энэ малчдыг бэлэн байдал хангуулах дээр нь их ажилламаар юм шиг. Бид бүгдээрээ л адилхан Монгол хүмүүс юм чинь энэ бэлэн байдал дээрээ яагаад хангахгүй байгаа дээр нь дүн шинжилгээ хийгээд, тэрэнд нь туслах чиглэлээр ажиллавал. Тэгэхгүй бол зуд болох давтамж нь ойртоно гээд түрүүхэн үдээс өмнө болсон Байнгын хороон дээр яригдсан. Энэ үед тэгээд энэ асуудал нь ойлгомжтой байгаа үед болсныхоо дараа ийм тусламж ирчихдэг юм гэсэн ойлголтыг малчдад суулгах нь буруу байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр яам бодлогын түвшинд анхаарч ажиллавал. Тэгээд дараа дараагийн энэ парламентад ажиллаж байх хугацаанд энэ аймгуудыг бүс бүсээс нь жигд хамруулдаг байвал зүгээр байна. Ор тас бүүр хамгийн асуудалтай газрууд нь хүртэл байхгүй. Дундговь бол нэлээн л өнгөрсөн зун хэцүүдсэн өвөл хэцүүдсэн санагдаад байх юм. Тэгэхээр энэ дээр анхаарч ажиллахыг хүсье.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар 13 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

С.Ганбаатар: Хариулт байгаа юу? Энэ чинь гишүүд улсын төсөв батална, бас зээл тусламжийн асуудлыг Их Хурлаар баталдаг. Энэ Их Хурлаар баталж байгаа энэ мөнгө хаашаа аль аймагт, юунд явах вэ гэдэг асуудал дээр гуйх биш, мөнгөний, ард түмний өмнөөс шийдвэр гаргаж байгаа хүмүүст энэ дээр хариулт байгаа юу? Бид энэ аймгуудыг яаж оролцуулах вэ гэдэг дээр оролцоо байгаа юу Улсын Их Хуралд? 4 номерын микрофоныг нээж өгье.

Т.Жамбалцэрэн: Одоо хэрэгжиж байгаа төслүүд дээр үндсэн нөгөө төслийн бүрэлдэхүүн хэсэг Их Хурлаар соёрхон баталчихсан зээлийн хэлэлцээр дээр тусгагдаагүй ажлуудыг бол одоо нэмж тусгах боломж байхгүй. Шинээр төслийн дизайн боловсруулаад, шинээр эхлүүлэх төслүүд дээр аймаг орон нутгийн сонголтууд дээр, тэр урьдчилан сэргийлэх чиглэлийн, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлийн агуулгуудыг тусгаад явах бололцоонууд бүрэн байгаа.

Манай дээр хэрэгжиж байгаа энэ яг хэрэгжилт нь явж байгаа 4 төслийн 2 нь аймаг орон нутаг хязгаарлахгүй улсын хэмжээнд хэрэгжих төслүүд. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь цэвэр арилжааны банкин дээрээ суурилж явж байгаа ийм зээлийн төслүүд байгаа.

С.Ганбаатар: Гишүүдэд зүгээр анхааруулж хэлэхэд хурал даргалж байгаагийн хувьд хэлэхэд бид чинь ганц сургууль, цэцэрлэг батлах гэж бөөн юм болоод л ТЭЗҮ, үр дүн, тэгээд л улаан шугам гээд л болдог. 47 сая доллар, 53 сая доллар, олон зуун сая доллар ярьж байхад энийг чинь дараа нь Монголын ард түмэн хүүтэй төлдөг. Монголын ард түмэн Улсын Их Хурлын гишүүдийг сонгодог, сайд сонгодоггүй юм шүү. Энхбаяр сайд орж ирэх үү үгүй юу? Энэ чинь 2 Байнгын хороо хуралдаж байна 1 дүгээрт. 2 дугаарт тэр ЗГ-ын өргөтгөсөн хурал хийж байгаа гэдгийг би ойлгож байна. Тэгэхдээ чөлөө аваад энд орж ирээч. Та нар хариултаа өгөх ёстой шүү дээ. Хурдан дуудаарай. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амгаланг дахин айлтгая. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа зээл тусламжийн хэрэгжилтийн үр дүнгийн талаар л ярьцгааж байна л даа. Үгүй ээ энэ угаасаа уг нь Их Хурал 2 удаа ярьдаг эд л дээ. Зээлийн ерөнхий хэлэлцээр орж ирж нэг дэмжигддэг холбогдох Байнгын хороодоороо. 2 дугаарт зээлийн гэрээ соёрхон батлах тухай асуудал яригддаг. Энэ дээр угаасаа зээлийн зорилго, хүрээ, зарцуулах хөрөнгө бүх юм тодорхой болдог. Хэрэгжиж яваа төслүүд дээр тухайн үеийн төрийн эрх барих дээд байгууллага нь шийдлээ гаргачихсан. Зүгээр хэрэгжилт үр дүн яг юу наалдаж үлдэв гэдэг талаасаа бид илүү анхаарлаа хандуулах ёстой. Харин цаашид хэрэгжүүлэх төслүүдийн асуудал дээр тодорхой байр сууриуд илэрхийлэгдэх бололцоо боломжууд бий л гэж би энэ талаас нь харж байна нэг.

Ер нь хөдөө аж ахуйн салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, зээл тусламжууд бодитой үр дүнгүүдээ шууд өгдөг. Хамгийн авах юм нь энэ. Тийм учраас энэ Хүнсний хангамж, аюулгүй байдал ч гэдэг юм уу, Цагаан алт хөтөлбөр ч гэдэг юм уу, Шинэ хоршоо ч гэдэг юм уу, Уур амьсгалын өөрчлөлт байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлээс хөдөө аж ахуйн салбарынхаа эрсдэлийг бууруулах, сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх чиглэл дээр энэ төслүүд тодорхой үр дүнгүүдээ өгсөн. Харин бид хэд энэ сайн, сайн төслийн өгөөжүүдийг цааш нь үндэсний хэмжээний бодлого болгож, үндэсний стандартууд болгож, хэрэгжүүлж ажиллах тал дээрээ л илүү сайн анхаарч, ер нь дотоодынхоо нөөц боломжийг дайчилж, хөрөнгө санхүүгийн нөөцийг чиглүүлнэ гэвэл энэ сайн

явчихсан, үр дүнд хүрсэн, эргээд энэ эдийн засгийн идэвхжил, хүн амынх нь хүнсний хангамж, аюулгүй байдалд том нөлөө үзүүлж байгаа энэ чиглэлүүд рүүгээ чиглүүлж явах талаас нь анхаарах ёстой. Би энэ талаас нь л энэ зүйлүүдийг хараад байдаг юм гэж.

Тэгээд одоо би 2, 3 зүйл хэлмээр байна л даа. Тэр усалгаатай газар тариалангийн хүрээнд 8 мянган га-д хүргэж, 7, 8 сумын асуудал яригдаад байгаа юм. Тэр дотор тов тодорхой өмнө нь ашиглагдаж байсан, бас үр дүнгээ өгч явсан талбайнууд байгаад байгаа. Жишээ нь Борнуурын 920 га, Жаргалантын 240 ч билүү дээ. Эд нарын засвар, шинэчлэлийн ажлыг шуурхай хийж чадах юм энэ хэмжээ.../минут дуусав/

С.Ганбаатар: Батжаргал гишүүнд нэмэлт 1 минутыг өгье.

Ж.Батжаргал: Нэмэгдүүлэх бололцоо, боломж бүрдэх юм. Энэ рүү би ХААЯ-ыг түлхүү анхаарч, төслийн хэрэгжилтийг шуурхайлаасай гэж. 2 дахь зүйл тэр Био-гийн вакцин үйлдвэрлэлт, био бэлдмэл үйлдвэрлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр тэр та хэдийн шинэ төсөл хэрэгжүүлэх гээд төслийн судалгаа тооцоолол хийгээд байгаа юмаа нэг шуурхай хийчихмээр байна. Энэ бидэнд үнэхээрийн хэрэгтэй байгаад байгаа зүйл гэж. 3 дахь зүйл дэргэдэх хүрээлэнгүүдээ амь оруулна гээд л ярьдаг юм. Тэр Дарханы Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн хүрээнд хүнсний ногооны үр үржүүлэг, төмсний үр үржүүлгийн асуудал дээр өнгөрсөн жилүүдэд яригдаад тов тодорхой тооцоолол судалгаатай гараад ирчихсэн юмнууд байгаад байдаг. Үүнийг хангахад энэ гадаадын зээл тусламжийн хөрөнгөөс тодорхой чиглүүлмээр байгаа юм. Тэр булцуу үржүүлгийн асуудал энэ тэр лүү ер нь жоохон хөрөнгө чиглүүлж байж хэдүүлээ үр дүнгээ хүртэх ёстой. Тийм учраас би энэ хөдөө аж ахуйн.../минут дуусав/

С.Ганбаатар: Батжаргал гишүүн асуулаа. Хариулт, үр дүн хэрэгжилт, 4 номер.

Т.Жамбалцэрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Түрүүн танилцуулга дээр хэлсэн төслийн маань зорилт өөрөө.../үг тасрав/

С.Ганбаатар: Энхбаяр сайд ирж байна уу, үгүй юу?

Т.Жамбалцэрэн: Ирж байгаа.

С.Ганбаатар: Хэлээрэй та нар.

Т.Жамбалцэрэн: 11 мянган, 8 мянган га гэж зорилт тавьсан. Тэгээд бид 11 мянган га болгоод ажиллалчих бололцоо байна гэж ингэж үзэж байгаа. Эхлээд хэрэгжээд явж байгаа 10 төсөл байгаа. Одоо 25 онд хэрэгжүүлэх дээр Төв аймгийн Жаргалантын Улаантолгой дээр бид 860 га, Борнуурын услалтын системийг сэргээн засварлах чиглэл дээр 970 га-гийн ажлыг эхлүүлээд явж байгаа. Тэгэхээр энэ ажил маань энэ төслийн хүрээнд хэрэгжээд явна, энэ онд ажил нь эхэлнэ гэж ингэж тооцож болно.

Био комбинат ТӨК-ийн өргөтгөл шинэчлэлийн ажил нэлээн тийм урт хугацаанд явсан. Унгарын ЗГ-ын дэмжлэгтэй хэрэгжинэ гэж яваад зээлийн

хэлэлцээр хийгээд, Их Хурлаар соёрхон батлаад, харамсалтай нь Унгарын ЗГ өөрөө бид энэ төслөө хэрэгжүүлэх бололцоогүй гээд хойш нь татсан. Энэ өргөтгөл шинэчлэлийнхээ ажлаа бид энэ малын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэгтээ хамруулж, эхний технологийн шинэчлэлийг хийх чиглэлээр эсийн өсвөрийнхөө шугамыг шинэчлээд автомат шугамтай болгосон. Өмнө нь бид юу гэдэг юм бэлэн малын засаа, малын элэг, дэлүү дээрээс эсийнхээ өсвөрийн авч, нөгөө уламжлалт технологиор үйлдвэрлэдэг байсан. Үндсэндээ 50 жил, 50 гаруй жил ерөөсөө огт технологийн шинэчлэл хийгдээгүй байсан. Тэгээд энэ онд бид 397,1 мянган долларын хөрөнгө оруулалт хийж энэ технологийн шинэчлэлийг хийж, тэгээд энэ эсийн өсвөрийн шугам маань Биокомбинатын үйлдвэрлэлийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх ийм ач холбогдолтой болсон. Дагуулаад бид автомат шугамын ажлыг Хүнсний хөтөлбөрийн зээлийн хөрөнгөөр шинэчлээд, Био комбинатын өргөтгөл шинэчлэл явж байгаа. Цаашдаа бид био комбинатын өргөтгөл шинэчлэлийг бүтэн хийх чиглэлээр энэ дараагийн төслийн дизайныг боловсруулаад, зураг төслийн ажлын энэ малын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл дээр тусгаад ингээд ажиллаад явж байгаа.

Үр тарианы чиглэл дээр Ургамал хамгааллын хүрээлэнтэй холбоотой ажлууд хийгдээд явж байгаа. Энэ усалгаатай газар тариалангийн төслийн хүрээнд төсөлд хамрагдаж байгаа энэ аймаг, сумдууд, энд хамрагдаж байгаа ААН-үүдийг чадавхжуулах чиглэлийн үйл ажиллагаанууд тусгагдсан. Төмсний бичил булцуу үржүүлэх чиглэлээр төсөв мөнгө тавигдсан. Технологийн шинэчлэл хийгдэхээр тоног төхөөрөмжүүдийн дэмжлэг нь энэ онд хийгдээд явна. Тэгэхээр энэ дээр тодорхой хувиар нэмэгдээд явна. Гол нь төмснийхөө үрийн шинэчлэл дээр бид нэлээн тийм анхаарах зайлшгүй шаардлага байгаа.

С.Ганбаатар: Сая гишүүн их тодорхой асуусан хяналт гэж асуусан. Энэ төслүүд дээр Улсын Их Хурлын гишүүд зарим нь анх удаа ч сонсож байгаа байх. Хэн хяналт тавьдаг вэ, хэрэгжилт нь ямар ч хулгай зэлгийгүй хэрэгжиж байгаа гэдэг дээр хэн хяналт тавьдаг вэ? ТУЗ-ийн гишүүдийнх нь нэрийг нь та нар хэлээч? Дөрөвхөн төсөл шүү дээ, тодорхой хэлээд өг дөө.

Т.Жамбалцэрэн: Төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Төслийн удирдах хороо хяналт тавьдаг, салбарын яам хяналт тавьдаг, санхүүжүүлэгч АХБ, Дэлхийн банк тавьдаг, Үндэсний аудитын газар хяналт тавьж, хяналт шалгалт хийж Улсын Их Хурал дээр тайлагнадаг байгаа.

С.Ганбаатар: Би энэ сонсгол энэ мэдээллийг авахаас өмнө аудитын дүгнэлт мөн яаман дээр байгаа хөндлөнгийн шалгалт хяналт тавьсан байгууллагуудын дүгнэлт материалуудыг өгөөрэй гэж хэлсэн. Энэ материал дөнгөж өчигдөр 8 цаг 30 минутад ирсэн. Та нар луу энэ бичиг явахад бараг сар болж байна уу? Болорчулуун даргаа, энэ хэн ТНБД-аа. Энэ гишүүдийг та хүндлэх ёстой шүү дээ. Энэ чинь гишүүд энэ мөнгөний араас Монголын ард түмнийг төлөөлж хяналт тавьж байгаа юм шүү дээ. Тэгэхээр миний саяын асуултад хариул даа. Аудитын дүгнэлтүүдийг хэзээ өгөх вэ? Яаман дээр байдаг хяналт шалгалтын аудит тэр дүгнэлт хийдэг улсууд нь юу хийсэн бэ? ТУЗ-ийн гишүүдийн тэр ТУЗ гэж явах уу, Удирдах хороо гэнэ үү, тэр гишүүдийнхээ нэр ус бүгдийг нь тодорхой болгож өгөөч, бид араас нь нэхэж асууж явах ёстой. Маш олон сая долларын төсөл хэрэгжээд мал аж ахуй, хөдөө аж ахуй сэт хийтэл босчихсон л гэж би ойлгоод байгаа шүү

дээ. Наад илтгэлийг чинь харахаар. Тэгтэл амьдрал дээр очихоор шал өөр байна л даа. Энэ дүгнэлтүүдээ бид хэзээ авч болох вэ? 4 номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Төслийн нэмэлт удирдах хорооны бүрэлдэхүүнтэй холбоотой, аудитын дүгнэлттэй холбоотой материалуудыг нэмэлтээр ирүүлье даргаа. Ялангуяа манай дээр байгаа аудитын дүгнэлт нь 23 оны жилийн эцсээр хийсэн аудитын дүгнэлтүүд байгаад байгаа юм. 24 оны эхний хагас жилээр хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтүүд байгаад байгаа. Одоо энэ төслүүд дээр Үндэсний аудитын газартай гэрээ хийсэн, сонгон шалгаруулалтад орсон аудитын байгууллагууд хяналт шалгалт хийгдээд явж байгаа. 3 сар гэхэд аудитын дүгнэлтүүд бүрэн дуусна. Энэ ирсний дараа ч гэсэн дахиад шинэчлээд тайлангуудыг бас ирүүлье даргаа.

С.Ганбаатар: Ганбаатар гишүүн асуулт асууя. Гонгорын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Гомбын шүү. Өнгөрсөн хугацааны олон улсын зээл тусламж, хөрөнгөөр буцалтгүй тусламж хөрөнгөөр хийгдсэн юутай танилцлаа. Сайнтай, муутай сав дүүрэн гэдэг шиг янз бүрийн л байгаа юм байна. Сайн хэрэгжсэн төслүүд ч байгаа л юм байна. Ингээд энэ төслүүдийг ингээд харахад тэр Дэлхийн банкны 30 сая доллар, АХБ-ны 46,2, Хөдөө аж ахуйн хөгжлийн нэмэлт санхүүжилт 50, АХБ-ны 57 аравны маш олон сая долларын төслүүд хэрэгждэг юм байна шүү дээ. Тухайн үед нь мэдээж тэр холбогдох улсууд нь дэмжээд хэрэгжээд явж байгаа юм байгаа биз.

Эндээс зүгээр нэг сонирхолтой зүйл нь энд ерөөсөө говийн бүсэд яагаад хэрэгждэггүй юм бэ? Ганцхан худаг дээр Дорноговь орж ирсэн харагдана. Дундговийн ганц юу харагдаж байна, бусад бүх аймаг. Та нар энэ би сая юугаар нь жагсаагаад үзчихлээ л дээ. Тэр эхний Дэлхийн банкны 30 сая долларын төсөл чинь 12 аймаг, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Төв, Хэнтий, Сүхбаатар гээд. АХБ-ны тэр 46,9 сая доллар чинь 9 аймаг, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Хэнтий, Ховд, Төв, Увс, Сэлэнгэ гээд. Хамгийн их мөнгө улсын төсөвт төвлөрүүлдэг манай говийн бүсийн аймгууд, Өмнөговь, Дорноговь, Дундговь хаана байна вэ энд? Даргаа дагаад төсөл нь хэрэгжээд байдаг юм уу, аль эсвэл улс төрчдөө, улс төрчийнх нь хөөцөлдлөгөө дутаад байдаг юм уу? Яг энэ дээр нэг хариулаад өгөөч та нар. Ерөөсөө огт байхгүй байна шүү дээ. Ийм олон төсөл хөдөө аж ахуйн төслүүд хэрэгжихэд говийн бүс дээр огт байхгүй байна гэдэг чинь эмгэнэлтэй биш үү.

Нөгөө талдаа өнгөрсөн жил үнэхээрийн хүнд өвөл болсон. Зүүн аймгууд, говийн бүсэд. Малчид малгүй болсон. Намар ядаж байхад годрон өвчин гараад баруун урд талынх нь сум нь арай гайгүй байсан бас өчнөөн мянган ямааг нь нядлаад хаячихсан. Хөдөө амьдарч байгаа ард иргэдийн малчдын амьдрал үнэхээрийн хүнд болсон. Гадаа нь нэг хуучин портер, Хятад мотоцикл 2 л үлдсэн байгаа юм. Нөгөө зээлийнх нь гэрээний нэг жилийнх нь сунгасан гэрээ нь одоо энэ 3 сараас дахиад үйлчилж эхэлнэ. Зээлээ төлөх ч юмгүй. 50, 60-хан бог мал үлдсэнийгээ 5, 6 айл нийлүүлээд нэг нь малладаг, бусад нь төв рүү амьдрал ахуй хөөгөөд, эхнэр нь нэг жимбий, хоол хийгээд, нөхөр нь таксинд яваад нэг иймэрхүү л амьдралтай болсон. Ялангуяа тэр Японы ядуурлыг бууруулах Японы сангийн тусламжийн гэрээ гэж байдаг юм байна шүү дээ. Тэгээд одоо иймэрхүү зүйлүүдээ яг энэ малгүй болсон бүс нутаг зүүн аймаг болоод говийн бүс нутаг руу дараагийнхаа төсөл дээр анхаараарай гэж хүсэхээр байна.

2 дахь гол зүйл нь ерөөсөө ХААЯ-наас байх энэ тусгаарлагдсан бүс, тусгаарлагдсан мал аж ахуй гэж Монгол орон даяараа нийтдээ малын өвчин ихээхэн гардаг учраас энэ тусгаарлагдсан аж ахуйнуудыг ихээр байгуулж экспортыг дэмжье гэж байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад.../минут дуусав/

С.Ганбаатар: Гомбын Ганбаатар гишүүнд 1 минут нэмж өгье.

Г.Ганбаатар: Үүнтэй холбогдуулаад энэ дулаан энэ говийн бүсэд хурга бордох аж ахуйнууд ялангуяа бага өсвөр насны мал бордох аж ахуйнууд говийн бүсэд хамгийн их юутай гардаг юм байна шүү дээ өндөр, дээрээс нь өвөлдөө нэг үндсэндээ 45 хоног л жоохон хүйтэрч байна. Бусад үед дулаахан байна. Тийм учраас энэ чиглэлийн дараагийн төслүүд дээрээ төслийнхөө дизайныг боловсруулахдаа үүнийг анхаарах боломж бий юу?

Уул уурхай дагаад маш их катеринг, махны үйлчилгээнүүд мах нийлүүлэлт их байгаа говийн бүсэд. Түүнтэй уялдуулаад энэ бордох аж ахуйнуудыг дулаан газар яамнаас бодлогоор зохицуулж, нэг талдаа ядуурлыг малгүй болсон иргэдийг малжуулах, ядуурлыг бууруулах, нөгөө талдаа энэ явж байгаа бодлого чиглэлтэйгээ уялдуулах боломж бий юу гэсэн ийм асуулт байна.

С.Ганбаатар: 4 номерын микрофоныг нээж өгье. Хариулт авъя. Нэр усаа хэлээд явчхаарай протоколд тусгагдаж байгаа шүү.

Т.Жамбалцэрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. ХХААХҮЯ-ны ТНБД Жамбалцэрэн. Энэ аймаг, сумын сонголттой холбоотойгоор энэ төслийн дизайныг боловсруулж байгаа судалгааны баг, санхүүжүүлэх байгууллага энэ ажилладаг. Энэ дээр нь ХХААХҮЯ холбогдох хамтран хэрэгжүүлж байгаа яам байгууллагууд саналаа өгөөд, тэгээд ЗГ-аар хэлэлцээд Их Хурал дээр хэлэлцдэг. Тэгээд Их Хурал дээр хэлэлцэх ерөнхий хэлэлцээр хийгээд, зээлийн хэлэлцээрийг соёрхон батлаад явах үе дээр нэлээн аймаг, сумын сонголт болж өөрчлөлтүүд гардаг. Яг салбарын яамны зүгээс судалгаа хийлгэчихсэн, хийсэн байгууллагуудын түвшинд л хийгээд явдаг.

Ялангуяа энэ усалгаатай газар тариалан төсөл дээр ялангуяа манай энэ мал аж ахуй, газар тариалангийн салбар өөрөө технологийн шинэчлэлүүд, энэ томоохон өргөтгөл шинэчлэлийн ажлууд хийхэд улсын төсвөөс огт зардлууд тавигдахгүй яваад байгаа. Зөвхөн татаас, урамшуулал, хүүгийн хөнгөлөлтүүд дээр л ингээд яваад байдаг. Тэгээд эдгээр сонгосон бүс нутгуудад энэ услалтын системийг шинээр болон сэргээн засварлах энэ асуудлууд нь илүү боломжтой гээд АХБ-аас өөрөө судалгаа хийгдчихсэн. Дээр нь эдгээр энэ шинэчилж байгаа, сэргээн засварлаж байгаа энэ объектууд нь дандаа төрийн өмчийн бүртгэлтэй байх ёстой гэсэн шаардлагуудыг тавьчихдаг. Тэгээд энэ агуулгынхаа хүрээнд сонголтүүд нь хийгээд яваад байдаг.

Тэр мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл дээр ч гэсэн яг үндэс нь энэ нөгөө малын эрүүл мэндийн чиглэлээр, эрүүл бүс байгуулах чиглэлээр, тэжээлийн зангилаа төвүүд байгуулах чиглэлээр эдгээр аймгууд нь сонгогдсон асуудлууд байгаа. Эдгээр шинэлэг шийдэл хөтөлбөр, бүтээлч түншлэлийн хөтөлбөрүүд гээд оролцож байгаа төсөлд хамрагдаж байгаа иргэн, ААН-үүд дээр энэ малын үүлдэр угсааг сайжруулах, малын эдийн засгийн

эргэлтийг нэмэгдүүлэх, тодорхой судалгааны төслүүд явагдаж байгаа эд дээр гарсан сайн үр дүнгүүдийг бид дараа дараагийн төслүүд дээрээ бүс байршлуудаар нь заагаад хийгээд явах бололцоо байгаа.

Дараагийн хэрэгжүүлэхээр зорьж байгаа гээд байгаа тэр ХАА-г хөгжүүлэх олон улсын сангийн төсөл, АХБ-ны санхүүжилттэй зээлийн арилжааны банкаар дамжаад явж байгаа төслүүд дээр бүс, аймаг харгалзахгүйгээр бүрэн хамрагдаад явах бололцоонууд нь байгаад байгаа. Одоо бид төлөвлөлт хийхдээ ч гэсэн энэ нөгөө бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалтай холбоотой төлөвлөлтүүдийг хийж оруулах, говийн бүсэд илүү дулааны баланс өндөртэй, хамгаалагдсан хөрсний тариалалт гэдэг юм уу, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх газар тариалангийн салбар дээр нь хийгээд явах бололцоонууд байгаад байгаа. Бид нөгөө хөгжлийнхөө үе шатын гэдэг юм уу, алгасаж хийж чадахгүй, тэгээд ямар ч байсан нэг хоцрохгүй түвшинд араас нь нөхөөд л яваад байгаагийн хэлбэр л байна. Тийм учраас гишүүний саналыг дараа дараагийн төслүүддээ анхаарч үзье. Баярлалаа.

С.Ганбаатар: Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Баярлалаа. Энэ танилцуулга бол Байгаль орчны яамтайгаа цуг зэрэгцээд хийгдэх байсан. Хөдөө аж ахуйн салбарын энэ төсөл хөтөлбөртэй холбоотой асуудал дээр зөвхөн бидэнд танилцуулга ирснээр 2020-оос 2024 онд нийт төслийн танилцуулгыг л та бүхэн хийж байна л даа. Байгаль орчин, уур амьсгалын яам бол 1992 оноос хойш тухайн салбарт хийгдсэн төслийн талаар танилцуулга хийсэн. Тэгэхээр би та нараас ер нь энэ хөдөө аж ахуйн салбарт 1992 оноос хойш 33 жил өнгөрч байгаа юм. Хэчнээн төсөл хөтөлбөр хэрэгжсэн юм бэ, хэдэн төгрөгийн санхүүжилттэй явсан юм бэ гэдэг? Тэгээд энэний эргэн төлөлтийн асуудлаар ер нь яам нэгдсэн дүн байна уу 1 дэх асуулт?

2-т энэ нэг төсөл хөтөлбөрүүдтэй ингээд танилцаад байхаар нэг ийм нийтлэг юм анзаарагдаад байх юм. Бидэнд мөнгө байна, танайд ийм төсөл хэрэгжүүлэе гэдэг. Танайх нэг багахан хувийг нь өгчих, манайх дийлэнхийг нь өгье гэдэг. Тэгээд манайхан тэгвэл та хэд мөнгөтэй бол хэрэгжүүлээч гэдэг нэг ийм юм Байгаль орчны яаман дээр 92 оноос хойш нэвт явсан юм байна гэж Одонтуяа дарга ний нуугүй бүгдийг нь ил гаргасан. Энэ ХААЯ-ан дээр хэрэгжсэн төслүүд та бүхний сая энэ танилцуулж байгаа төслүүд та бүхэн гаргаж ирээд санал тавиад санхүүжүүлэгчүүд нь хийв үү эсвэл энэ гаднын санхүүжүүлэгч байгууллагууд танайд ийм төсөл хэрэгжүүлэе гэж оруулж ирэв үү гэдэг дээр би нэг хариулт авъя гэж ингэж бодож байна.

Энэ Батжаргал гишүүн бас яриад та бүхэн бас л сайн ярьсангүй. Яг энэ төслийн үр дүнд та бүхний танилцуулга яах вэ сайн байгаа л гэж байна. Яг хөндлөнгийн аудит хийсэн тийм зүйл байдаг уу? Хэрвээ байдаг бол тэрийг энд цуг өгөхгүй яасан юм бэ? Та нар 20-оос 24 он гэдэг ийм хязгаар тавьчихаад, тэрний өмнөх төслүүд дээр тэгвэл аудит огт хийгддэггүй байсан юм уу? 3 дахь асуулт нь энэ.

4 дэх нь яг бид яг тухайн салбар дээр энийгээ ингэж эрэмбэлмээр байна. 1 дүгээрт энийг бид хиймээр байна, харамсалтай нь мөнгө байхгүй байна. Энийг хийхийн тулд ийм санхүүжилтээр, энэ төсөв, төслөөр бид хиймээр байна гэсэн тийм эрэмбэлсэн юм байна уу? Ингээд л мал аж ахуйн мал эмнэлгийн хүртээмжийг 10 хувь нэмэгдүүлэх төсөл хэдэн сая доллар ч гэнэ үү ингээд явж л байна. Миний

бодлоор бол байгаа энэ мал эмнэлгийн салбар дээрээ наад вакцинаа л хурдан аваачаад өгчихвөл манайх хамгийн хурдан тарих бололцоотой дэд бүтэцтэй газар шүү дээ. Өвчин яагаад тардаг вэ вакцин байхгүй. Тэгэхээр вакцин хийдэг үйлдвэрээ та би Биокомбинатыг Их Хурлын гишүүн болсон цагаас хойш ярьж байгаа, 3 сайдын нүүр үзэж байна. Дандаа ингээд нэг хийж байна, судалж байна гэдэг нэг ийм нэг усан тайлбартай. Тэгэхээр би дахиад асууя эрэмбэлсэн тийм зүйл байна уу?

С.Ганбаатар: Маш тодорхой 4 асуулт асуулаа. 4 номерт ТНБД хариулъя.

Т.Жамбалцэрэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Аудитын тайлангууд байгаа. Аудитын тайлангуудыг нэмэлтээр Байнгын хорооны гишүүдэд дэлгэрүүлж хүргүүлъя. Био комбинатын өргөтгөл, шинэчлэлт дээр салбарын яам анхаарч байгаа. Үндсэндээ Био комбинатыг 90 оноос хойш бүтэц, чиг үүргийг нь 10 гаруй удаа өөрчлөөд УТҮГ, ТӨК, аж ахуйн тооцоотой хуулийн этгээд гээд олон хэлбэрээр яваад үндсэндээ бараг орхигдуулаад яваад ирчихсэн. Тэгээд улсын төсвөөс сүүлийн 50 жил 1 төгрөгийн ч хөрөнгө оруулалт хийгээгүй ийм явж ирсэн. Тэгээд сүүлийн 3 жил энэ Био комбинатын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулаад төрийн өмчид ХХК болгосон. Энэ хүрээнд засаглал, менежментийг нь сайжруулсан. Албан хаагчдынх нь ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх чиглэл дээр ахиц гаргаж байна.

2 технологийн шугамыг бид ашиглалтад оруулчихсан. 1 нь савлагааны автомат шугамыг бүрэн оруулсан, туршилтын савлагаанууд хийгдсэн. 25 онд нийлүүлэгдэх тарилга вакцинууд эдгээр технологийн шинэчлэлийн хүрээнд нийлүүлэгдэн хэрэглэгдээд явна. Хугацаандаа очдоггүй байсан шалтгаан нь түрүүний хэлсэн эсийн өсгөврийн шугам дээрээс бүтэн хамаардаг байсан. Уламжлалт технологиор хийдэг ийм вакцины үйлдвэр. Хаваржилтын нөхцөл байдал ямар байхаас шалтгаалаад малын засаа, элэг, дэлүү, тэр бүтээгдэхүүн дээрээс нь дээж авч тэндээсээ эсээ өсгөвөрлөж хийдэг байсан. Өнгөрсөн жил мал төллөлт оройтсон, зудын эрсдэлтэй байсан гээд түүхий эд, эсийн өсгөврийн шугамуудаа бид авч чадахгүй нөхцөл байдалд хүрсэн. Одоо энэ технологийн шинэчлэл хийсний үр дүнд бид тийм зовлонгүй болж байгаа. Тэгэхээр 25 онд нийлүүлэгдэх дотоодоос нийлүүлж байгаа тарилга вакцинууд хугацаандаа нийлүүлэгдэнэ.

Цаашдаа бид энэ ХХААХҮ-ийн салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр ТЭЗҮ-ийг нь боловсруулж байна. Бүтэн технологийн шинэчлэл хийх, импортоор авч байгаа олон улсын хорио цээртэй, гоц халдвартай вакциныг дотооддоо үйлдвэрлэх технологи дамжуулах ажлуудыг эхлүүлэхээр био тарилга вакцин үйлдвэрлэдэг олон улсын ААН-үүдтэй ажиллаж байгаа. Төслийн дараагийн үе шатад төслийнхөө дизайныг боловсруулаад, олон улсын байгууллагуудад санал тавиад, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллахаар төлөвлөж байгаа.

Төслийн үр дүнгүүд гээд тэгэхэд төслийн санаачилгаар салбарын яамнаас хэрэгжиж байгаа санаачилга гарсан төслүүд байна. Олон улсын байгууллагын энэ санхүүжүүлэгч байгууллагуудаас санаачилгатай төслүүд байна. Аль болох энэ хүрээнд өөрсдөд шаардлагатай байгаа, нэн хэрэгцээтэй байгаа үйл ажиллагаануудаа хамрахыг, хамруулахыг зорьдог. Гэсэн хэдий ч тухайн төслийн

олон улсын санхүүжүүлэгч байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу тодорхой хэсэгт нь та нар зээлийн хөрөнгөөр.../минут дуусав/

С.Ганбаатар: Хариултыг нь дуусгая. 4 минутад нэмж хариулъя, 4 дүгээр микрофонд.

Т.Жамбалцэрэн: Тодорхой хэсэгт нь техник туслалцааны эрхийг ав, тодорхой хэсэгт нь энгийн зээл ав гэдэг ангилал руу явуулчихдаг. Дээр нь санхүүжилтийн нөхцөл нь нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй, арилжааны гэх хэлбэрүүдээр хумигдаад байдаг. Тухайн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад төсвийн нөхцөл байдлаас шалтгаалаад нэгдсэн төсөв дээр нэмэгдээд тооцогдож байгаа учраас төсвийн санхүүжилтүүд нь хойшлох, урагшлах, хуваарь нь өөрчлөгдөх ийм асуудлууд байдаг.

Ялангуяа бид юу гэдэг юм төслийн хэрэгжүүлэх үе шатад төслийнхөө хураангуй дизайныг боловсруулаад, тодорхой зөвлөхүүдийг авч ажиллуулаад, техникийн хорооныхныг авч ажиллуулаад, тэгээд банкных нь санхүүжүүлж байгаа байгууллагууд нь өөрсдийнхөө үнэлгээг хийгээд ингээд явдаг. Тэгээд тодорхой үнэлгээнүүдийнхээ түвшинд эцсийн хувилбар дээрээ тохироод, тухайн банк, санхүүжүүлэгч байгууллагууд гэдэг юм уу, Удирдах хорооны шийдвэр нь гарч байж манай талд ирүүлдэг. Тэр шийдвэр гарсан дээр нь бид энэ ЗГ, Их Хурлын зээлийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Жамбалцэрэн дарга би тантай бодлогын юм яриад байдаг та надад нэг тийм детальный юм хариулаад байдаг. Би 1 дүгээрт хөдөө аж ахуйн салбарт өнгөрсөн энэ 30 хэдэн жилийн хугацаанд хэчнээн төсөл хөтөлбөр хэрэгжив, хэдэн төгрөгийн санхүүжилттэй байв, эргэн төлөлт нь юу байв гэдэг ийм тодорхой асуулт асуусан, та хариулсангүй.

2 дугаарт төсөл хэрэгжүүлэх энэ саналаа эхлээд тэдэн төслөөсөө хэд нь яамны санаачилгаар хийгээд, хэд нь санхүүжүүлэгчдийн санаачилгаар хийгээд байгаа юм бэ? Санхүүжүүлэе гэсэн болгоныг оруулж ирээд ингээд байх юм уу? Энэ чинь Монгол Улсын гадаад өр тэр хэрээрээ нэмэгдээд л байгаа шүү дээ. Та бас энд хариулсангүй.

Дараагийн юм бол байгаа тайлангаа та ирүүлээгүй тухай ярьж байна. Байгаа юм бол тэгээд тэрийгээ ирүүлэхгүй юу хийж байсан юм бэ? Өчигдөр 8:30-д танай юм ирсэн, 22:30-д, 20:30-д.

4 дүгээрт салбарын эрэмбэлсэн асуудлууд би танаас асуугаад байхад та ер.../минут дуусав/

С.Ганбаатар: Гишүүний асуултад тодруулж хариулъя. Ер нь яамнууд мөнгөний тухай ярих мөн дургүй юм. Энэ чинь бид наад мөнгийг чинь баталсан, дараа нь Монголын ард түмэн төлнө, тэгээд Монголын ард түмэн биднийг сонгосон юм байгаа юм шүү дээ хянаарай гэж, араас нь яваарай гэж. Тэгэхээр саяын асуултад их тодорхой хариулж өгнө үү. 4 дүгээр номерын микрофоныг нээж өгье.

Т.Жамбалцэрэн: Идэрбат гишүүний асуултад тодруулж хариулъя. Бодлогын хувьд салбарын яаман дээр эрэмбэлсэн төслүүд байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр, дунд хугацааны хөтөлбөр, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, салбар яамны төлөвлөгөө байгаа. Энэ дотроосоо бид бодлогын хувьд аль, аль ажлууд эхний ээлжид хийгдэх вэ, аль, аль ажлууд нь улсын төсөв дээр хөрөнгө оруулалттай байгаа вэ, аль салбар нь хөрөнгө оруулалтгүй байгаа вэ гэдэг дээр ажлуудаа эрэмбэлдэг. Энэ эрэмбийн хүрээнд л хийгдэж байгаа. Саяын мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл, усалгаатай газар тариалангийн төсөлд бид манай хөдөө аж ахуйн салбар байгаль цаг уур, хурмастаас бүрэн хамааралтай. Бид газар тариаланг байгаль цаг уураас хамааралтай биш, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд энэ усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлэх, мал эмнэлгийн бүтэц тогтолцоог бид 17 онд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиа батлаад, энэ.../минут дуусав/

С.Ганбаатар: Нэмэлт хариулт боломжийг 4 номерын микрофонд өгье. Хамгийн гол нь энэ 92, 3 оноос хойш хэдэн төгрөгийн төсөв, зээл, тэгээд үр дүн юу байгаа вэ?

Т.Жамбалцэрэн: Тийм байдлаар асуудлуудыг, төслүүдийг эрэмбэлж хэрэгжүүлж байгаа. Өнгөрсөн хугацаанд 92 оноос хойших төслүүдийн мэдээллийг ирүүлээгүй. Өнгөрсөн одоо ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ХХААЯ дээр хэрэгжиж байгаа төслүүд гэдэг агуулгаар ирүүлсэн учраас танилцуулгыг энэ хүрээнд хийж байгаа. 92 оноос хийсэн төсөл хөтөлбөрүүдийг нарийвчилж гаргаад, хуримтлагдсан өр авлагуудыг тооцоод мэдээллийг танд ирүүлье. Манай дээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, салбарын нийт өр авлагын хэм хэмжээ, олон улсын байгууллагуудтай хэрэгжүүлсэн төслийн өр авлагын хэмжээ тооцоонууд бүгд гараад, тэгээд тайлагнаад Улсын Их Хурал дээр Үндэсний аудитын байгууллага танилцуулаад явдаг. Үндэсний аудитын тайлан болон улсын.../минут дуусав/

С.Ганбаатар: Нэмж хариулах боломжийг 4 номерын микрофонд өгье.

Т.Жамбалцэрэн: Тухай бүрд нь ирүүлдэг. Тодорхой төслүүд хэрэгжсэн дүнтэй холбоотой, инфляцын түвшин, валютын ханшны зөрөөгөөс улбаатай хуримтлагдсан өр авлагууд нэлээдгүй байгаа. Ялангуяа Атрын 3 дугаар аянаас хойш хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд дээр гэдэг юм уу, бусад энэ нөгөө ЗГ-ын бонд, хөрөнгө оруулалттай гаргасан зээлүүдийн хүрээнд хуримтлагдсан өр авлагууд, ОУБ-ын санхүүжилттэй хэрэгжсэн өр авлагууд байгаа. Эдгээрийн одоо манай төсөв дээр барьж байгаа бодлого бол зээл авлаа гэхэд эргээд тухайн зээл авсан байгууллага, ААН-үүд нь эргэн төлөлтөө хариуцах ёстой гэдэг ийм агуулгатай явчхаж байгаа. Улсын төсөв гэдэг юм уу, зээл тусламжийн хөтөлбөрөөр ТӨК гэдэг юм уу, тухайн салбар дээр санхүүжүүлэлтүүдийг олгохгүй. Эргэн төлөлтийг нь тухайн салбарын ААН, тухайн тэр зээл авч байгаа ашиг шимийг нь хүртэж байгаа иргэн, ААН-үүд төлөлтийг эргэн төлнө шүү гэдэг энэ шаардлага тавьж байгаа учраас бид одоо Био комбинатаа илүү нөгөө зоригтой зээл авах чиглэлд нь оруулж ирэх, эргээд эргэн төлөлтийг нь өөрөө төлөх энэ чиглэл рүү нь нэг ёсны санхүүгийн сахилга батыг нь сайжруулж байгаа л хэлбэр болчихоод байгаа юм. Тэгэхгүй өмнөх зээлүүд дандаа төсвийн зээл маягтай яваад, улсын төсвөөс санхүүжиж чадаагүй төсөл, арга хэмжээнүүдээ хамруулж санхүүжилт хийж яваад, тэрнийх нь эргэн

төлөлт нь хуримтлагддаг ийм асуудлууд байгаа. Тэгээд энэ тооцоо судалгааг бас дэлгэрэнгүй байдлаар гаргаж танд хүргүүлье.

С.Ганбаатар: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Өдрийн мэндийг хүргэе. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа гаднын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн тухай чухал асуудлыг хэлэлцэж байна. Тэгээд гишүүд ч нэлээн тодорхой, их тийм зөв саналууд гаргаж байна. Үүнтэй холбогдолтой нэлээн сайжруулах зүйлүүд байна гэж хараад байна.

Үндсэндээ Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар бол өөрийн гэсэн онцлогтой. Дэлхийд нүүдлийн соёл иргэншил энэ байгаа байдлаа хадгалсан ер нь бараг хамгийн сүүлийн гэж хэлж болох ийм онцлогтой улс. Тийм учраас гаднын энэ төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа энэ санаачилга гаднынхны яг зөвлөж байгаа тэр санаачилгаар бус бидний хэрэгцээ шаардлагад нийцсэн ялангуяа манай ХХААЯ-ны энэ бодлого, хөтөлбөрт нийцсэн, бид өөрсдөө яг энэ уламжлалт мал аж ахуй, энэ ХАА-гаа яаж авч явах вэ гэдэг энэ бодлогыг маань дэмжихэд чиглэсэн энэ агуулга руу байгаасай гээд гэдэг маш тодорхой ийм зөв саналууд хэлээд байна л даа. Тэгэхээр энэ чиглэл рүү ер нь цаашдаа анхаарах тухай ерөнхий гишүүдийн энэ саналыг бид нэлээн анхаарах нь зөв. Ийм харагдаж байна.

2 дахь нь зээл тусламжийн энэ хөтөлбөрүүд заавал ч үгүй бүх аймгийг, манай аймаг орсонгүй, энэ бүс хамрагдсангүй гэдэг энэ агуулгаар бид харж болохгүй. Энэ тодорхой энэ туршилтын хэлбэрээр, жижиг хэлбэрээр, энэ гаднын хөрөнгө оруулалтаар тэр төслүүдийг хэрэгжүүлээд харин тэр төслүүд дээр гарч ирж байгаа энэ сайн үр дүнг нийтдээ энэ жишээ нь тэр хүлэмжийн төсөл, газар тариаланд хорших энэ төсөл 4 сумд хэрэгжсэн байлаа гэж бодоход одоо энэ төсөл хэрэгжээд дуусчихлаа, үргэлжлээд бусад сумдуудад хэрэгжүүлэхэд юуг нь авах юм, юуг нь авахгүй юм гэдгийг сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын түвшинд тодорхой энэ түвшинд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэл дээр нь яаж анхаарч байгаа вэ гэдэг энгийн ийм тодорхой дүгнэлтүүдийг ХААЯ-наас хүлээгээд байна. Энийг зөвхөн Их Хурлын гишүүд биш, олон нийт хүлээгээд байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлийн агуулгуудыг анхаараач гэдэг ийм 2 ерөнхий гол агуулгыг гишүүд хэлээд байх шиг байна. Тэгээд энэ маш зөв ийм саналууд байна гэдгийг би цохож хэлье.

Тэгээд тусгайлан энэ хөтөлбөрүүдтэй холбогдолтой нарийн асуух хэд хэдэн зүйл байна. Жайка байгууллагатай хамтарсан энэ төсөл бол маш сайн төсөл байгаа. Энэ төслийг цаашдаа үргэлжлүүлэх чиглэл дээр Байнгын хороо Их Хурлын гишүүдийн түвшинд яг гацаж байгаа тодорхой асуудал юмнуудаа та бүхэн маань хэлээсэй. Энэ төслийн хүрээнд мянга гаруй ААН-үүд зээлээ аваад ингээд амжилттай үргэлжилсэн ийм эерэг үр дүнтэй төсөл байгаа. Энэ талаар яг тодорхой нарийн мэдээлэл хэлээрэй.

Усалгаатай газар тариалангийн төслийг нэлээн удаж байна, яг ямар асуудлууд гацаад байна вэ? Тэр 700 га-гийн Хэнтий аймаг дээр хэрэгжиж байгаа төслийг би нэлээн сайн мэдэж байна. Намайг тойрогт ажиллах болгонд асууж байна. 2025 онд юу хийгдэх вэ, хэзээ дуусах вэ? Энэ өмчлөлийн асуудалтай холбогдолтой цаашаа авч явахтай холбогдолтой нарийвчилсан мэдээллийг та бүхэн өгөөч гэдэг энэ асуултыг.

С.Ганбаатар: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. 4 дүгээр номерын микрофоныг нээж өгье.

Т.Жамбалцэрэн: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Гишүүдийн хэлсэн саналуудын дагуу холбогдох арга хэмжээг салбарын яамны хувьд авч ажиллана. Хэрэгжиж байгаа энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах энэ 2 үе шаттай зээлийг үргэлжлүүлэх чиглэлээр 24 он, 23 онд 2 удаагийн хүсэлтийг тавьсан. Жайка ОУБ Японы тал Японы ЗГ дээр энэ төслийн үр дүнг танилцуулсан. Монголбанкны энэ Монгол Улсын энэ зээлжих зэрэглэл, энэ эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг цаашид үргэлжлүүлэх эсэх дээр ЗГ-ын албан ёсны байр суурь гарсны дараа шийднэ гэдэг ийм тайлбарыг Япон улсын Монголд суугаа ЭСЯ, Жайка ОУБ-аас бид нарт ирүүлсэн.

Өнгөрсөн жил Эдийн засаг, хөгжлийн сайдын хийх айлчлалын хүрээнд холбогдох хүсэлтийг хүргүүлсэн. Их Хурлын даргын айлчлалын үеэр ч гэсэн энэ хүсэлтийг тавьсан. Энэ маань харьцангуй нааштай байх шиг байна. Саяхан Монголд суугаа Элчин сайд Япон улсын Элчин сайд Монгол Улсын ЗГ-ын тэргүүнтэй уулзахдаа Монгол Улстай хийх зээлийн хэлэлцээр, нэн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг цаашид хэрэгжүүлээд өргөтгөөд явах бололцоо байгаа. Эхний ээлжид Хөшигийн хөндийн асуудлууд, барилга, дэд бүтцийн асуудлууд дээр санхүүжилт зээлийг олгоё. Дараагийн удаа энэ өмнө нь үр дүнтэй хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд дээр санхүүжүүлэх боломжтой гэдгээ албан ёсоор илэрхийлсэн байна лээ. Энэ хүрээндээ манай энэ байгаль орчныг хамгаалах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих 2 үе шаттай зээл нэлээн дараагийн үе шат хэрэгжээд явах бололцоо бүрдэж байгаа гэж ингэж үзэж байгаа. Бидний хувьд ч гэсэн холбогдох тооцоо судалгааг хийгээд явж байгаа. Төслийн үр дүн нэг ёсондоо Засгийн газар дээр дарамтгүй, өр байхгүй, чанаргүй зээл байхгүй гэдэг дээр хамгийн сайн үнэлэгдээд байгаа. Цэвэр арилжааны банкаар хэрэгжээд явж байгаа. Салбарын бодлого, үйл ажиллагаа нь салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдаад явдаг.

Арилжааны банк гэдэг юм уу, банк санхүүгийн зах зээл дээр байгаа хамгийн сайн нөхцөлтэй гэдгээрээ энэ салбарт оролцож байгаа иргэн, ААН-үүдийн нэлээн тийм эрэлттэй ийм төсөл байгаа. Тэгээд энэ хэрэгжээд явах бололцоо бүрдэж байгаа гэж ойлгож байгаа. Бидний хувьд ч гэсэн хугацаа алдахгүй энэ 25 ондоо хэрэгжих санхүүжилтээ гаргаад, энэ 25 ондоо багтаад дараагийн хэлэлцээрийг эхлүүлээд явах юм сан гэсэн ийм зорилттой ажиллаж байгаа. Усалгаатай газар тариалан дээр Болорчулуун дарга хариулъя.

С.Ганбаатар: 4 номерын микрофоныг үргэлжлүүлээд өгье.

Ц.Болорчулуун: ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Ганхүлэг гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж байгаа энэ 12 төсөл дотор Хэнтий аймгийн дулааны талын Хэрлэн суманд хэрэгжиж байгаа дулааны талын 700 га услалтын системийн ажил байгаа. Ер нь барилга захиалагчийн төв ерөнхий хяналтыг тавьж явж байгаа. Өнгөрсөн жилийн гүйцэтгэлээр 64 хувийн гүйцэтгэлтэй гэсэн 64 хувийн гүйцэтгэлтэй ажил явагдаж байгаа. 24 онд ажиллаагүй. Энэ нь юу вэ гэхээр тухайн гүйцэтгэгч компани ер нь нөхцөл үүссэн нөхцөл байдал нь Хэрлэн гол үерлэсэнтэй холбоотойгоор энэ ажил хийгдээгүй, зогсонги байдалтай байсан.

Цахилгааны асуудал 20 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Бид цахилгаан дээр нэмэлт гэрээнүүдийг нь байгуулаад, төлбөрийн асуудлыг шийдээд явж байгаа. Тэгэхдээ өнгөрсөн жилийн гүйцэтгэл яваагүйтэй холбоотой тухайн гүйцэтгэгч компани дээр гэрээний дагуу алданги тооцож ингэж явж байгаа. Тэгэхээр одоо бол 2025 онд энэ ажлыг бүрэн дуусгана гэсэн байдлаар.../минут дуусав/

С.Ганбаатар: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Өмчлөлийн асуудал цаашдаа үйл ажиллагааг нь үр дүнтэй аваад зохион байгуулаад явах тал дээр нь ерөнхийдөө ямар байр суурьтай байгаа вэ? 2025 ондоо гэдэг нь болохоор энэ жилийн ургацын үед ашиглахгүйгээр ирэх намрыг та хэлж байна уу? Энэ жил ер нь үйл ажиллагаа явуулж эхлэхтэй холбогдолтой. Мөн яг цаашдаа үйл ажиллагаагаа явуулахад ямар байдлаар ер нь зохион байгуулах юм бэ? Тариаланчид яаж ажиллах вэ гэдэг асуултыг нэлээн асуугаад байна л даа.

С.Ганбаатар: 5 номерын микрофонд Болорчулуун дарга хариулъя.

Ц.Болорчулуун: Нэмэлт хариултыг өгье. Тэгэхээр ер нь энэ услалтын системийн ер нь хэрэгжиж байгаа төслүүдийг нь цаашид авч явах өмчлөлийн асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр бид ХХААХҮ-ийн сайд бол аймгийн Засаг дарга нартай гэрээ байгуулаад, тухайн өмчлөгч нь сумын ЗДТГ байна гэдэг ерөнхий шийдэлд хүрсэн. Ингээд сум, тухайн сумд үйл ажиллагаа эрхэлж байгаа ногоочдын бүлэг, хоршоодод энийг урт хугацаатай зээлийн гэрээгээр олгоё гэдэг ийм байдлаар өмчлөлийнхөө асуудлыг шийдээд явж байгаа. Энэ өмчлөлийн асуудалтай холбоотойгоор энэ хэлэлцүүлгийг ийм нөхцөлтэй зээл байгаа, ийм хугацаатай байгаа гэдэг тал дээр орон нутаг бол хэд хэдэн удаагийн хэлэлцүүлгийг хийсэн. Ингээд ерөнхийдөө эцсийн байдлаар зөвшилцөлд хүрээд, энэ орон нутагт нь өмчлөлийг нь өгөөд, ингээд урт хугацаатай зээлийн гэрээгээр гэрээ байгуулаад, хоршоод бүлэг, ногоочдын бүлэгт нь өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах ийм байдлаар явъя гэсэн нь эцсийн шийдэлд хүрсэн байж байгаа.

С.Ганбаатар: Хариулт авлаа. Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Өдрийн мэнд хүргэе. Энэ сангуудтай зээл тусламжтай холбоотой асуудлыг ер нь авч үзэх нь хамгийн чухал байлаа. Тэгээд энэ санаачилгыг гаргасан Байнгын хорооны дарга Ганбаатар даргад гишүүнд баярлалаа гэдгээ илэрхийлье. Өнөөдөр ХААЯ-нд хэрэгжиж байгаа төслүүдийн талаар ярьж байна. Тэгэхээр энэ төсөл гэдэг зүйл дээр гаднын зээл тусламжаар улсын төсвөөс гадна асар их мөнгөөр хэрэгжүүлж байгаа зүйлүүд байна. Тэгэхдээ энэ төслийн үр дүн ер нь ямар байгаа юм бэ гэдэг дээр нэлээн сайн анхаармаар харагдаад байгаа юм.

Та бүхнээс тодорхой асуулт асууя. Малын эрүүл мэндтэй холбоотой асуудал 12 аймгийн 80 сум хамрагдаж энэ төсөл хэрэгжиж 5 сая ам.доллар зарцуулсан байна. Тэгээд тайлан дээрээ 98,45 хувийн гүйцэтгэлтэй, өвчний тандалт, хүнсний аюулгүй байдал сайжруулахад хамгийн чухал үр дүн гаргасан гэж гүйцэтгэл нь тийм байна. Тэгээд үр дүн нь яг адилхан байгаа юм уу? Энэ дээр надад нэг тайлбар өгөөч.

2 дугаарт нь Хөдөө аж ахуйн хөгжлийн сангаас зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил гээд төсөл хэрэгжүүлсэн байна л даа. 9 аймгийн 156 сумд хэрэгжсэн. 25 мянган өрхөд хүрнэ гэж зорилго зорилт дэвшүүлсэн, 58 мянган өрхөд төслийн үйл ажиллагаанаас ямар нэгэн байдлаар үр шим хүртсэн гэж. Үр дүн гарч, энэ өөрөө тэгээд тогтвортой байгаа юу? Манайд ингээд төсөл хэрэгждэг, үр дүн гарсан гэж тооцдог. Тэгээд тэр нь тогтвортой цаашдаа үргэлжлээд улам сайжраад яваад байгаа юу? Энэ тал дээр та бүхэнд тооцоо судалгаа, эргэн тандалт хийсэн зүйлүүд байдаг юм уу? Бид ер нь цаашлаад ингээд төсөл хэрэгжлээ, дуусчихлаа, цаашлаад өргөжүүлж авч явах процессоо яаж явдаг юм бэ? Манайд ХААЯ-ны хувьд шүү дээ. Энэ дээр улсын төсвөөс анхаардаг юм уу, эсвэл тухайн хувь хүн, ААН-үүдийн оролцоотойгоор яваад байх ёстой юм уу? Энэ өөрсдөө энэ төслийн үр дүнгээр гарсан үр дүн нь хадгалагдаж байгаа юу, цаашлаад дахиад нэмэлт үр дүнгүүд гарч байгаа юу гэдэг дээр хариулт өгөөч.

2 дугаарт нь зээл тусламжаар аваад орон нутагт хэрэгцээтэй зүйлийг санхүүжүүлэх гээд л байх шиг байгаа юм. Тэгсэн зээлтэй холбоотой асуудлаар зүй зохисгүй ажлууд хийгдээд байгаа юм уу гэдэг асуудлууд явж байгаа юм. Тэгэхээр энэ зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдэд ямар чиглэлээр, ямар төслүүдийг хэрэгжүүлэх гэж байгаа вэ гэдгийг хэн гаргаад байгаа юм бэ? Хэн гаргаж байгаа вэ гэдэг. Би бол бодохдоо орон нутгийн нөхцөл байдалд тулгуурласан хөрөнгө оруулалтуудыг хийх ёстой л гэж харж байна. Гэтэл нэг төсөл дээр шүү дээ. Энэ өвс.../минут дуусав/

С.Ганбаатар: Батлут гишүүний минутыг нэмж өгье.

Д.Батлут: Зах зээлийн ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл юм байна шүү. Энэ дээр болохоор малчдад сургалт, мэдээллийн танхим тохижуулах, ажлын байрны засвар шинээр барих, ЖДҮ-лэлийн төв, Хөдөө аж ахуйн газрын байрны засвар, борлуулалтын задгай талбайн тохижилт гээд хэнд хамааралтай юм гэж бол тодорхойлохгүй нь. Улсын төсвөөр, орон нутгийн төсвөөр хийчих ажлуудыг л баахан ийм төсөл төслөөр хэрэгжүүлчихсэн байна. Ингэж болох юм уу? Энэ төсөл хөтөлбөрөөр зээл тусламжаар авч байгаа зүйлийг чинь арай өөр зорилго, зорилтын доор хэрэгжүүлэх ёстой л гэж хараад байгаа юм. Тэгээд энэ дээр нэг тайлбар өгнө үү? Хариултын дараа тодруулъя. Баярлалаа.

С.Ганбаатар: Батлут гишүүн маш тодорхой асуулт асуулаа шүү. Нөгөө оролцогчдыг оролцуулдаг уу, орон нутгийн болон мэргэжлийн холбоодын оролцоог хангадаг уу гэж тодруулж асууж байна шүү. 4 номерын микрофонд нэмж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Батлут гишүүний асуултад хариулъя. Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн нарийн бичиг дарга. Ялангуяа энэ нөгөө зах зээл, бэлчээрийн удирдлагын төсөлтэй холбоотой асууж байна. Энэ төсөл бол хамгийн тийм онцлогтой төсөл. Оролцогчдыг бүрэн хамруулж байгаа. Төсөлд хамрагдаж байгаа малчдын бүлэг, эмэгтэйчүүдийн бүлэг тэд нарын санаачилга дээр тулгуурлаж энэ төслийн төлөвлөлтүүдийг хийдэг. Аймаг, сумын иргэдийн Хурал нь энэ асуудлаа хэлэлцэж саналаа ирүүлдэг төсөл. Тухайн хийгдсэн тэр хөрөнгө оруулалтын шинжтэй, тэр барилга байшин засвартай холбоотой ажлууд нь тухайн орон нутгийн төсөв, улсын төсөв дээр суугдаагүй ажил дээр хийгдсэн ажлууд. Энэ төслийн сүүлийн 2 дугаар үе шатны хэрэгжих хугацаанд эхний 2 жил нь хамтын санхүүжилттэй буюу төслөөс 70 хувийн

санхүүжилттэй, орон нутаг нь 30 хувийн санхүүжилттэй. Иргэдийн Хурлаараа шийдвэрлээд асуудлуудаа хийснээрээ бусад төслүүдээсээ онцлог их тийм сайн үр дүнтэй хэрэгжсэн.

Нэг төсөл хэрэгжээд тухайн аймаг орон нутаг нөгөө төслийнхөө талаар ойлголт мэдээлэл байхгүй эсвэл нэг салбарын яам гэдэг юм уу эсвэл дээрээс нэг төсөл ирээд хэрэгжиж байна гэдэг тийм ойлголт байхгүйгээр аймаг орон нутгийн иргэдийн Хурал нь өөрсдөө санал санаачилгаа гаргаад хэрэгжүүлснээрээ онцлог байгаа юм. Дараагийн 2 жил нь хамтын санхүүжилтийг нь 50, 50 хувийн санхүүжилттэй болгож байгаа юм. Нэг ёсондоо төслөөс авч байгаа хөрөнгөө бид орон нутагтайгаа хамтраад илүү үр дүнтэй, илүү орон нутгийн оролцоотой сайн жишгийг бий болгосноороо энэ төсөл онцлог байгаад байгаа юм. Эдгээр төслүүдийн үр шимээр гэдэг юм уу, үр шимийг хүртсэн иргэд, малчид, тариаланчид, зарим хөрөнгө оруулалтууд нь тухайн орон нутгууд руугаа тухайн иргэн, малчин, тухайн фермер, тариаланч, тухайн аймаг орон нутгийнхаа хөрөнгө өмчлөлд бий болгосон хөрөнгүүдийг нь бүрэн шилжүүлж байгаа. Ашиглалтынх нь асуудал цаашид тогтвортой явах асуудлуудыг нь аймаг орон нутагт эрхийг нь шилжүүлж байгаа. Сайн үр дүнтэй, сайн авч явж байгаа дээр бид дараа дараагийн төслүүдтэйгээ үргэлжлүүлээд хэрэгжүүлэх бололцоог нь хангаж өгч байгаа гэдгийг бас хэлье.

Ер нь энэ төслүүд дээр тэр дараагийн үр дүнг нь холбох, үр дүнг нь тогтвортой авч явж байна уу, ашигладаг уу, орхиж байна уу гэдэг дээр үнэлэлт, дүгнэлт өгөхгүй бол болохгүй байгаа гэдэгтэй санал нэг байгаа. Зарим төсөл дээр тодорхой тийм алдаа эндэгдэл гарч байгаа, иргэн, аж ахуй нэгжүүд нь тогтвортой авч явахгүй байгаа, аймаг орон нутагт бий болгосон хөрөнгө, тэр ААН, тоног төхөөрөмж нь гэдэг юм уу ашиглалтгүй үлдэх энэ тэр асуудлууд байгаад байгаа. Тийм учраас илүүтэй нөгөө аймаг орон нутгийнх нь санал санаачилга дээр тулгуурлаж энэ ажлуудыг тэр төслийн үр шим хүртэж байгаа иргэн, ААН дээр тулгуурлаж үйл ажиллагааг нь хийж, тогтвортой гэрээ, хяналт, мониторингийн ажлуудыг үр дүнтэй хийхгүй бол тодорхой ийм асуудлууд байгаа гэдэгтэй санал нэг байгаа.

Мал аж ахуйн эзэн төсөлтэй холбоотой асуудал дээр тодорхой яг улсын төсөв дээр сууж чадахгүй байгаа ажлуудыг хийх чиглэлээр нэлээн ажиллаж байгаа. Улсын төсөв дээр мал эмнэлгийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Тодруулах уу? Хариултаа дуусгая, 4 номерын микрофонд гүйцээж хариулт өгье.

Т.Жамбалцэрэн: Мал эмнэлгийн байгууллагыг чадавхжуулах чиглэл дээр улсын төсөв дээр сууж байгаа төсөв зардал маань хангалтгүй байгаа. Зөвхөн одоо сууж байгаа төсөв маань вакцин, үйлчилгээний хөлс хоёрт явчхаж байгаа юм. Тэгэхээр юу гэдэг юм энэ гарал үүслийг мөрдөн мөшгөх, энэ цахим шилжилтүүдийг хийх, тэр сургалт чадавхжуулах ажлуудыг хийх, тэр лабораторийн техник технологийн шинэчлэлүүд хийх, оношилгооны чадавхыг сайжруулах гээд ажлууд улсын төсөв дээр огт байхгүй байгаад байгаа юм. Тэгээд өөрөө мал эмнэлгийн байгууллага, бүтэц тогтолцооны хувьд босоо удирдлагатай. Тэгээд төсөв бол зөвхөн улсын төсвөөс хараат байгаа учраас энэ төслийг хэрэгжүүлэхэд ч гэсэн мал эмнэлгийн байгууллагын бүтэц тогтолцоог шинэчлээд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдсаны дараа чадавхжуулах чиглэлийн үйл ажиллагаануудыг нь

энэ төсөлд тусгаж хэрэгжүүлсэн байгаа юм. Тэгээд энэ чиглэлээр нэлээн ажлууд хийгдсэн. Ялангуяа энэ салбарын цахим үйлчилгээг сайжруулах, мал эмнэлгийн нэгдсэн системийг бий болгосноор бид хүнсний аюулгүй байдлыг хангах энэ гарал.../минут дуусав/

С.Ганбаатар: Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Олон нийтийн оролцоотой хийх гэж оролдож байгаа хэлбэрүүдийг ярьж байна л даа. Тэгэхдээ бид нэг тийм мэдээлэл, мэдлэг мэдээлэлгүй л байгаагийн зовлон энэ. Та бүхний энэ гаргаж байгаа төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхдээ ямар, ямар төсөл хөтөлбөрүүд дээр хөрөнгө оруулалт хийсэн бэ гэдэг зүйлээс харангуут зүгээр нэг хэдэн төрийн албан хаагчдын л санаанууд тусчихсан байгаа байхгүй юу. Яг үнэндээ манай Монгол Улсад статистик мэдээллээ цуглуулж чадахгүй хэмжээнд оччихсон байгаа шүү. Та бүхэн яг тэгээд ард иргэдийн хүсэл эрмэлзлийг энэ төсөл хөтөлбөртөө тусгаж чадаж байгаа юу, үгүй юү гэдэг дээр нь анализ хийх хэрэгтэй. Яг тэгж чадахгүй зүгээр нэг мэдээ мэдээлэлгүй өөрсдөө тулгадаг хэлбэрээр бид ийм зүйлийг хийх нь зүйтэй гэдэг хэлбэрээр асуудалд ханддаг учраас энэ төсөл хөтөлбөрийн үр шим нь иргэдэд очиж тусдаггүй. Тэгээд тэрүүхэндээ нэг байр сууцын конторын засвар үйлчилгээ болж хувирчих гээд байгаа юм шүү дээ. Энэ илэрхийллээр яг тэгж харагдаж байгаа юм.

С.Ганбаатар: Батлут гишүүнд 1 минут тодруулж өгье.

Д.Батлут: Тэгэхээр бид энд нэг зүгээр тэр багаас, сумаас, аймгаас ирсэн тоон мэдээллүүдийг нэгтгэж бид нарт танилцуулах биш, илүүтэй эргэх тогтолцоо, хяналт шалгалтын тэр нэг соён гэгээрлийн гэдэг зүйлүүд рүүгээ илүү анхаарч явах ёстой юм нөхөд өө. Ингэхгүйгээр бид зүгээр нэг тайлан мэдээ цуглуулаад бидэнд тайлагнадаг, энд авчраад бид нарын чихийг хуурдаг хэмжээний асуудал ярих юм бол харин бие биеийгээ хуураад яваад байх боломж, цаг хугацаа зөндөө гарна. Ингэцгээхээ больё бүгдээрээ. Хөрсөн дээрээ бууж, газар дээрээ очиж асуудалдаа ханддаг, яг хэрэгцээтэй, хүнд хэрэгцээтэй асуудлуудыг шийддэг түүн рүү чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг төсөл хөтөлбөрийн хэмжээнд авч үздэг байх ёстой. Үүний тулд л Монгол Улсын ЗГ эрсдэл гаргаж, тэр зээл, тусламжийг чинь хүлээн зөвшөөрдөг байх ёстой гэж харж байгаа шүү.

С.Ганбаатар: Гишүүн асуулт авч, хариултаа авлаа. Ер нь гишүүд ингэж асуугаад байгаа нь бид танай гэрт очоод мөнгөн аягыг чинь тоолъё гээгүй шүү дээ. Бид баталчихсан дараа нь Монголын ард түмэнд төлөх мөнгийг хэрэгжилт ямар байна вэ гэж шийдвэрийнхээ хяналтад бид оролцож байгаа юм шүү. Тэгээд гишүүд энэ завсарлагааны үеэр төсөл болгон дээр очиж ёстой гар биеэрээ үзэж, үр дүн нь юу байна, энэ чинь дараа нь Монголын ард түмэн төлөх мөнгө, бидний хүүхдүүд төлөх мөнгө учраас үр дүнг нь үзнэ. Олон төслүүд үр дүнтэй байгаа. Та нарын маань хичээл зүтгэл байгаа. Тэгэхдээ олон улсын практик дээр энэ ядарсан буурай орны хөдөө аж ахуй, мал аж ахуйн зовлон жаргалыг нулимс гартал бичиж байгаад, тэгээд тэр том, том байгууллагуудаас мөнгө аваад 60-аас 70 хувийг нь consulting service гээд буцаагаад аваад гараад явчихдаг практик дэлхийгээр нэг байгаа.

Манай дээр гэсэндээ өчигдөр би 2 долоо хоног яг энэ төслүүдтэй танилцлаа. Англи дээр нь, Англи дээр тайлангууд нь байх юм л даа ядаж. Тэгсэн 1 сая 380 мянган долларын төсөл байна. Нэр усыг нь хэлбэл тэртээ тэргүй ажлын хэсэг энд

шалгаад орох байх. Тэгэхэд эхлээд 544 мянган долларыг консалтинг гэж явж байгаад, дараа нь ревайтед гэж л хэлээд байх шиг байгаа юм. 867,9 мянган долларыг consulting гээд буцаагаад аваад явчихсан. Цаана нь training семинар сургалт гэсэн чинь 172,5-ыг аваад явчихсан. Нийт төслийнхөө 73 хувийг нь зүгээр буцаагаад цаас үйлдвэрлээд, аваад өөрийнхөө цалин болгоод аваад гараад явчихсан. Иймэрхүү төслүүд байх вий гэдэг дээр бид санаа зовж, та нартайгаа хамтарч, гар нийлж ажиллаж үр дүнг нь сайжруулъя л гэж хүсэж байгаа юм шүү. Энэ дээр чинь хүний муу үзэх гээд байгаа явдал ерөөсөө биш гэдгийг тайлбар илүүц болгож хэлээд, Энхтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Энхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Саяын энэ илтгэлээс харахад ер нь эдийн засгаа солонгоруулах, энэ хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд энэ гадаадын зээл тусламж дажгүй нэлээн сайн зээл тусламж орж ирдэг юм байна, мэдээлэл авлаа. Тэгээд өнөөдөр яг бодит байдал дээр яг эзэндээ очиж байна уу гэдэг асуудлыг олон гишүүд хөндөж байна. Миний хувьд бас энийг хөндөхийг хүсэж байна. Та бүхний саяын өгсөн энэ илтгэл дээр ерөнхийдөө энэ зээл тусламж малчид, хөдөө аж ахуйн бизнес эрхэлж байгаа энэ зээл тусламжийг хүссэн иргэдэд очихдоо арилжааны банкаар дамжиж очиж байгаа. Тэгэхээр харамсалтай нь өнөөдөр нөгөө арилжааны банкаар дамжиж очихоор арилжааны банканд арилжааны банкнаасаа илүү баян гэдгээ бататгаж байж зээл тусламж авах ийм хэмжээнд өндөр шаардлага жижиг, дунд бизнес эрхэлж байгаа болон малчдад ийм өндөр шаардлага тавьдаг.

Та бүхний яриагаар арилжааны банкнууд энэ эрсдэлээ үүрч байгаа гээд тэгж байна. Өнгөрсөн хугацаанд энэ өгсөн зээл тусламжаас арилжааны банкнууд хэдэн хувийн эрсдэлийг яаж үүрдэг юм бэ? Бодит байдал дээр зээл авахад хамаг л үл хөдлөх хөрөнгөө тавьдаг. Үл хөдлөх хөрөнгийг 50 хувиас доогуур үнэлж арилжааны банкнууд авдаг. Малчид ихэнх нь малаа Хаан банкны барьцаанд тавьчихсан иймэрхүү нөхцөл байдал өнөөдөр байж байгаа байхгүй юу. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд энд өгсөн зээл тусламжийг арилжааны банк энэ эрсдэлээ яаж ингэж үүрч, яг эрсдэл нь энэ арилжааны банкин дээр яг үнэн бодитойгоор тусаж байна уу гэсэн 1 дүгээр асуулт байна.

2-т нь энэ ковидын үед энэ хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулсан хүмүүст маш хүндрэлтэй тус гэсэн байх. 30 хувь нь ерөнхийдөө энэ жижиг, дунд бизнес эрхэлж байгаа ААН-үүд хаалгаа барьсан. Сая энэ 24 оны судалгаагаар энэ 30 хувийн хаалгаа барьсан ААН-үүд 60 хувь нь судалгаагаараа бид дахиад энэ үйл ажиллагаагаа явуулмаар байна. Харамсалтай нь бид нарт эргэлтийн хөрөнгө, зээл тусламж авах боломж алга байна. Яагаад гэвэл ингээд дампуураад хаалгаа барьчихсан. Гэхдээ үйл ажиллагаагаа цаашаа явуулах нь 60 хувь нь эргээд явуулмаар байна гээд тэгж байна. Тэгэхээр энэ 25 онд өгөгдөх гэж байгаа энэ зээл тусламжаас та бүхэн ямар шалгуураар энэ ААН-үүдэд зээл тусламжийг өгөх гээд байна вэ?

Миний хэлэх гээд байгаа санаа юу вэ гэхээр энэ арилжааны банкнуудаар дамжихаар л яг эзэндээ хүрч чадахгүй, яг үйл ажиллагаа явуулъя гэсэн хүмүүстээ энэ зээл тусламж чинь хүрч чадахгүй өндөр шалгууртай байгаад байна. Тэгэхээр хувь ААН-тэй, тэр ААН-үүдийн үйл ажиллагааны чиглэл байдаг юм уу, онцлогийг нь хараад үнэхээр энэ хөдөө аж ахуйн салбарт үнэтэй хувь нэмрээ оруулж чадах, энэ эдийн засгийг солонгоруулж чадах ийм судалгааг нь хийгээд, тэр ААН-үүдэд өөрсдөд нь эрсдэлийг нь даалгаад энэ зээл тусламжаас өгөх энэ боломж байдаг

юм уу? Ийм шинэ бодлогыг та бүхэн хэрэгжүүлэх боломжтой юм уу? Өнөөдөр энэ 25 онд хэрэгжих энэ зээлээс энэ 75 хувь нь буюу 42,7 сая ам.долларыг нэн хөнгөлөлттэй зээлээр буюу жилийн 2 хувийн хүүгээр олгоно гэсэн.../минут дуусав/

С.Ганбаатар: Тодруулах юм уу? Гишүүнд тодруулж минут өгье. Энхтуяа гишүүнд.

Д.Энхтуяа: 2 хувийн зээл хүүгээр олгоно гээд тэгж байна. Тэгэхээр яг энэ хэрэглэгчдэдээ энэ ААН-үүддээ 2 хувиар очих ийм боломж байгаа юу? Дундаас нь энэ арилжааны банкнууд оролцоод ингээд яг үнэндээ гэхэд өнөөдөр бодит байдал дээр нөгөө энэ малчдын үйл ажиллагаа ч сэргэхгүй байна, жижиг, дунд бизнес эрхлэгчид ч гэсэн энэ дампуурлын ирмэгт хүрээд, өнөөдөр бэлэн мөнгөний хомсдол орсон ААН-үүд 90 хувь байна гэсэн ийм судалгааг би сая харлаа. Тэгэхээр энэ дээр шинэчилсэн өөр бодлого 25 онд хэрэгжих энэ зээл тусламж дээр өөр ямар нэгэн бодлого байгаа юу? Хуучин энэ замаараа явах гээд байна уу?

С.Ганбаатар: Энхтуяа гишүүний асуултад хариулъя, 4 номерын микрофоныг нээж өгье. ТНБД хариулна.

Т.Жамбалцэрэн: Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Тэр 2 хувийн зээл гэдэг нь бид нарын нөгөө эх үүсвэртэй авсан зээлийн дүн явж байгаа гишүүнээ. Тэгэхээр бид дамжуулан зээлийнхээ гэрээ хийгээд иргэн, ААН дээр энэ Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төсөл, Жайкагийн 2 үе шаттай зээл бол 7-гоос 8 хувийн хүүтэй очиж байгаа юм. Тэгэхээр Монголбанкны бодлогын хүү ямар байна, тэр зээлжих зэрэглэл ямар байхаас хамаараад бид хүүгээ дотор нь ялангуяа Жайкагийн зээл шилжүүлэх боломжтой учраас бид 6-аас 8-ын хооронд бариад, 8-аас 7 болгож бууруулаад, 6 руу буулгаад, буцаагаад 7 дээр гэдэг ч юм уу иймэрхүү тохируулгуудыг хийж болж байгаа юм.

Дээр нь манай нөгөө зээлжих зэрэглэл, нөхцөл нөгөө GDP-н хэмжээ хувь өсөлтөөс хамаараад бид дээр буцалтгүй гэдэг юм уу тусламжийн төслүүд харьцангуй бага. Дандаа ерөнхийдөө хөнгөлөлттэй, нэн хөнгөлөлттэй гэдэг зээл рүү. Арилжааны зээл рүү ерөөсөө явахгүй. Аль болох нэн хөнгөлөлттэй зээл авах л ийм сонирхолтой байгаад байгаа. Манай дээр зүгээр сүүлийн жилүүдэд энэ олгож байгаа зээлүүд дээр хүүгийн хөнгөлөлтийг нь олгоод, арилжааны банкны эх үүсвэрийг ашиглаж юу гэдэг юм нөгөө байгаа эх үүсвэрээ нэмэгдүүлэх чиглэлийн агуулгууд нэлээн сүүлийн үед яваад байгаа. Нөгөө төсөв дээрээ төсөв маань өөрөө хязгаартай учраас.

Манай энэ Жайкагийн төсөл, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил 2-ын төсөл бол арилжааны банкин дээр судлагдаад тэгээд салбарын бодлого үйл ажиллагаатай нийцэж байна, салбарын нөгөө бүх консалтинг зөвлөмж үйлчилгээнүүдийг нь өгсний үндсэн дээр арилжааны банкин дээр шийдвэр нь гараад, шийдвэрийг нь манайхаас баталгаажуулж хүргүүлж байгаа юм. Тэгэхээр энэ хэлбэр маань л цаашдаа үргэлжлээд явах болов уу гэсэн ийм чигтэй. Аль болох бид нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй, бага хүүтэй байх, хугацааны хувьд урт, тэгээд эргэн төлөлтийн хугацааг нь урт байх тэр нөхцөлийг нь л бүрдүүлэх дээр илүү ажиллаж байгаа гэж хэлж болно. Тэгээд төслийн яг ерөнхий нөхцөлийг нь манай 2 төслийн зохицуулагч зээлийн төслийнхөө нөхцөлүүдийг нь эрсдэлээс яаж өөрсдийгөө хамгаалж байгаа, төсөл хүртэгчид үр шим хүртэж байгаа агуулгаар бас нэг хэлчихье.

С.Ганбаатар: 8 номерын микрофоныг нээж өгье. Хариулт авъя.

Ж.Түвшинтөгс: Жайкагийн 2 үе шаттай төслийн зохицуулагч Түвшинтөгс байна. Түрүүний эрсдэлийн талаарх асуултад эрсдэлээ үүрдэг, үүрэх талаар асуултад хариулъя. 2 үе шаттай зээл нь анх зээлийн гэрээ нь Их Хурлаар соёрхон батлагдахдаа банкаар дамжуулж олгоно гэсэн нөхцөлтэй байгаа. Тэр нөхцөлийнхөө дагуу бид шалгуур хангасан гэрээт банкнуудаар дамжуулж зээлээ олгож байгаа. Тэгэхээр зээлийн шалгуур, зээлийн хорооны шийдийг бол банк гаргаж байгаа. Төсөл зүгээс Төслийн удирдах хороо бол бодлогын чиглэлийг нь гаргаж өгдөг. Энэ зарчмаар энэ төсөл маань 1, 2 дугаар үе шат нь амжилттай хэрэгжээд, одоо эргэлтийн эргэн төлөлтийн сангаараа төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа. Манай энэ зээл маань ингээд тусгай сонгон шалгаруулалт байхгүй, бүх арилжааны банкаар.../минут дуусав/

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн тодруулах юм уу? Товчхон хариулахыг бодоорой. 8 номерын микрофонд нээж өгье.

Ж.Түвшинтөгс: Арилжааны банкаар дамжиж олгодог учраас нөгөө арилжааны банкны дэд бүтцээр ашиглаад бид санхүүжилтээ олгодог учраас орон нутагт хүртээмж өндөртэй. Зээл авъя гэсэн ААН бол банкаараа дамжаад хүсэлтээ гаргаад тэгээд л яг банкны процессоор зээл олгодог үе шат нь явдаг. Банк нь эрсдэлээ даана гэдэг зарчмаараа банк нь өөрсдийнхөө шалгуурыг тавиад, эрсдэлээ даагаад явдаг. Төсөл хэрэгжсэн хугацаанд төслийн эрсдэл 3-аас 5 хувьтай явж ирсэн. 3-аас 5 хувь гэдэг маань ААН нь банкандаа төлөх эрсдэл гэж байгаа юм. Энэ нь болохоор энэ давагдашгүй хүчин зүйл ч гэдэг юм уу энэ нөхцөлтэй уялдсан 3-аас 5 хувь. Банкнаас төсөл буюу Засгийн газарт 100 хувь бүрэн төлөгдөж байгаа. Дээрээс нь зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэхийн тулд.../минут дуусав/

С.Ганбаатар: 8 номерын микрофонд дахиад нэмэлт минут өгье. Энэ 2 удаа л өгөх журамтай юм байна лээ шүү, миний дүү болж өгвөл товчхон хариулахыг бодоорой.

Ж.Түвшинтөгс: Тэгээд зээлийн эрсдэл нь яах вэ ААН-үүдээ тэр эрсдэлээ даах, даван туулах тал дээр нь банканд нь бид банкных нь нөхцөл байдалтай нь уялдуулаад, ААН-үүдээ хамрагдалтыг нь сайжруулах үүднээс байгаа барьцааг нь тодорхой хэмжээнд банкны шалгуураа аваад, хүрэхгүй байгаа бол Батлан даалтын сангийн үйлчилгээг энэ төсөлд хамрагдах зорилгоор нэмэлтээр авах боломжтой байдаг. Тэгснээр ААН-үүдийнхээ эрсдэлийг бууруулах боломжтой явж байгаа. Тэгэхээр яах вэ 3-аас 5 хувь нь санхүүгийн салбарын хувьд урт хугацаатай, бага хүүтэй учраас эрсдэлийн хэмжээ буюу чанаргүй зээлийн хувь бага байгаа. Салбарын хувиар үзвэл 10 орчим хувьтай байдаг учраас хэвийн хэмжээнд гэж бид үзэж явж байгаа.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Энхтуяа: Баярлалаа. Тэгэхээр яг энэ нөгөө мэдээлэл, энэ бүх судалгаа та бүхний хэлж байгаа энэ тайлангуудыг мэдэж байна. Ерөөсөө бодит байдал дээр болохоор энэ банк чинь дахиад нэмэлт энэ эрсдэлээ үүрээд явж байгаа боловч яг энэ ААН-үүдэд очихоор энэ зээл чинь хүү нь өндөр учраас эргэн төлөгдөх нөхцөл

байдал, дээрээс нь энэ зээл авсан ААН-үүд хөл дээрээ босох, цаашид үйл ажиллагаагаа сайжруулах, цаашлаад гадаадын хөрш орнуудын зах зээлд гарах энэ бүтээгдэхүүнээ борлуулах ийм боломж нь үнэхээр боломжийг олгохгүй байгаад байгаа байхгүй юу өнгөрсөн хугацаанд. Тийм учраас энэ дээр арай л өөр шийдлээр, өөр бодлогоор л баймаар санагдаад байгаа юм. Ойлголоо.

С.Ганбаатар: Энхтуяа гишүүний асуулт нэг ийм л юм асуугаад байна шүү дээ. Монголын ард түмний нэрээр, Монголын ард түмнээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн нь шийдвэр гаргаад, дараа нь эрсдэл гарвал Монголын ард түмэн төлөх энэ мөнгөөр зээл туслалцаа, хөл дээрээ босгох гэж байгаа ААН-үүд нь банкаар дамжчихаар хамгийн бярттай, хамгийн барьцаа хөрөнгө сайтай, хамгийн 3 үсэгтэй томчуул нь авчих гээд байна охин компаниудаараа. Энэ дээр яг нөгөө жирийн ард иргэд 60 мянган ААН-үүдээс та нар энэ төсөл дээр 43 ААН л авсан байна. Ямар азтайнууд нь авдаг юм бэ? Дандаа л томчуул сайчуул нь авсан байж таараа гэж ойлгогдож байна. Энэ дээр жирийн хөл дээрээ босох гэж байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн оролцох оролцоо боломж нь хэр байдаг вэ? Та нар бодлогоор тэр оролцоог яаж нээдэг вэ гэж л тодруулж асуугаад байгаа гэж би ойлгоод байна шүү дээ. Түүн дээр 4 номерт ТНБД хариул даа. Маш азтай, энэ хар даа. 4 номерыг.

Т.Жамбалцэрэн: Энхтуяа гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ 2 төсөл нөгөө зээлжих ангилал нь ялгаатай байгаад байгаа юм. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн зээл юу гэдэг юм илүү дунд, том аж ахуй нэгж рүү чиглэсэн гэдэг юм уу 2-оос 8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч байгаа ийм зээл.

Жайкагийн 2 үе шаттай зээл болохоор 20-оос 800 сая хүртэл төгрөгийн санхүүжилт авч байгаа зээл. Монголбанкны мэдээлэл, дээр нь ЖДҮ-лэгч мөн гэсэн тодорхойлолтын үндсэн дээр ЖДҮ-лэл эрхлэгч ААН-үүдэд борлуулалтын орлого нь 2,5 тэрбумаас доош ААН-үүдэд Жайкагийн 2 үе шаттай зээлүүд очиж байгаа. Барьцаа хөрөнгийн дутагдалтай, банкны шалгуур үзүүлэлт хангахгүй байгаа тохиолдолд Зээлийн батлан даалтын сангаар дамжуулаад барьцаа хөрөнгийнхөө 60 хувь хүртэл буюу тэрбум төгрөгийн 600 сая хүртэлд нь баталгаа гаргуулаад зээлээ авах боломж нь бүрдчихсэн байгаад байгаа юм. Тэгээд.../минут дуусав/

С.Ганбаатар: 4 номерын микрофонд гүйцэд хариулах боломж өгье.

Т.Жамбалцэрэн: Өмнө нь ЖДҮХС-гаас гэдэг юм уу яг жижиг, дунд бизнес эрхэлж байгаа иргэн, ААН-үүдэд олгож байгаа зээлийг сангаас нь дамжуулаад шууд олгож байсан тохиолдлууд байгаад байгаа юм. Тэгэхээр зээлийн эрсдэл, тэгээд дахиад эргэн төлөлт нь маш өндөр тийм хувьтай алдагдалтай байгаад байсан. Тэгээд энэ арилжааны банкаараа дамжих асуудлууд, өмнөх нөгөө манай ЖДҮ-лэл дээр гарсан асуудлууд бол бид нарт нэлээн тийм сургамж өгсөн учраас ялангуяа энэ санхүүгийн бусад арга хэрэгслүүдийг энэ зээлийн батлан даалтын үйлчилгээнүүд, энэ зээлийн даатгалын асуудлууд, тэгээд энэ хугацаа, энэ хөнгөлөлттэй нөхцөлүүдийг сайжруулах чиглэлээр л илүү ажиллах нөхцөл бүрдэж байгаа.

Жайкагийн дараагийн үе шатан дээр Жайкагийн өөрсдийнх нь хийгээд өгсөн сайн судалгаа байгаад байгаа юм. Өөрийнх нь энэ санхүүжилтийн корпорац хэлбэрээр явуулъя. Эндээ таны хэлдэг шиг тэр нөгөө бусад хэлбэрийн дэмжлэгүүд

нь орж байдаг. Даатгал нь орж байдаг, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, тэр консалтингийн үйлчилгээнүүд нь орж байдаг, зах зээл дээр.../минут дуусав/

С.Ганбаатар: ТНБД дараагийн хариулт дээрээ бас гүйцээгээд хариулчихыг бодоорой. Баярлалаа. Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Аудитын дүгнэлт уг нь сонссон зүгээр байлаа. Гэхдээ яах вэ дараа нь бид танилцах юм байна гэж ойлголоо. Яг та бүхний сая энэ танилцуулгаас харахад нэг бодлын их гоё, сайхан, дандаа үр дүнтэй хэрэгжиж байгаа юм шиг харагдаж байна. Тэгэхдээ мэдээж бодит амьдрал дээрээ юм тийм байдаггүй гэдгийг бид мэдэж байгаа. Тэгээд ний нуугүй л байцгаая. Та нар яг салбартаа байгаа улсууд. Энэ дотроос үр дүнгүй ч юм уу, магадгүй цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй ч юм уу тийм төслүүд байна уу? Тэгвэл ний нуугүй та нар тийм байгаа бол тэрийгээ хэл, энийг больё. Эсхүл тэрийг үр дүнтэй болгохын тулд цаашид ийм, ийм арга хэмжээ авч ажилламаар байна гэж та бүхэн маань ажлаа дүгнэж санал, дүгнэлт гаргаж байгаа байх. Тэгэхээр тэрийгээ нэг хэлээд өгөөч.

Бид сайн сайхныг зөндөө сонслоо. Нэрээсээ сонсоход бүгдээрээ л дэмжих шаардлагатай гоё төслүүд сонсогдож байна. Гэтэл яг бодит амьдрал дээрээ олон гишүүд хэлж байна. Үр дүн муутай байдаг, чанаргүй зээл болчих гээд байдаг ийм төслүүд байгаа болов уу гэж бодоод байх юм. Тэгэхээр энэ бол бидэнд нэг их гоё байгаа, сайн байгаа, амжилттай ажиллаж байгаа гэж тайлагнахдаа гол нь биш. Эцсийн үр дүн нь үнэхээр болохгүй байгаа бол бид та нарыг буруутгах гээд байгаа юм биш, үнэхээр болохгүй байгаа юмнууд бол тэрийгээ засаж залруулаад Их Хуралтайгаа хамтраад ажиллаад явъя гээд. Тэгэхээр 1 дүгээр зүйл энэ болохгүй байгаа юмнууд юу байгаа юм бэ? Тэрийгээ цаашид яаж засаж залруулах юм бэ? Их Хурал, Их хурлын гишүүд, Байнгын хороо яаж дэмжиж хамтарч ажиллах вэ гэдэг дээр нэг тайлбар хэлээд өгөөч.

Дараагийн нэг зүйл болохоор юу вэ гэхээр энэ уул уурхайн салбарт, уурхайн бус салбарт ер нь гадаадын хөрөнгө оруулалт хэр байдаг юм бэ? Бид хөрөнгө оруулалт гэж ярихаар дандаа уул уурхайн салбартаа хөрөнгө оруулах тухай асуудал ярьдаг. Би энэ хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбартаа хөрөнгө оруулалт, гаднын хөрөнгө оруулалт татмаар санагдаад байх юм. Дандаа жижиг, дунд гээд бид энэ жижиг, дундын нуруун дээр энийг бараг л өнгөрсөн 30 жил ярьж явлаа. Үнэхээр амжилттай байж чадаж байгаа юу гэвэл бас жаахан төвөгтэй байх. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалт татах тал дээр гаднын том хөрөнгө оруулагчид сонирхдоггүй юм уу? Энэ тал дээр бид хөрөнгө оруулалт татах ямар ажлууд хийх боломжтой юм бэ, хийж байгаа юу гэдэг дээр нэг хариулт авмаар байна. Энэ шууд төслүүдтэй хамаагүй. Тэгэхдээ бол бодмоор асуудлууд байна.

Дараагийн нэг асуулт энэ Экспортыг дэмжих төслийн хүрээнд энэ ямар, ямар бүтээгдэхүүнийг дэмжсэн юм бэ, яг ямар дэмжлэг үзүүлсэн юм бэ? Экспортыг нь дэмжинэ гэхээр яасан юм, гадаадад гаргах тэр сувгийг нь нээж өгсөн юм уу, худалдан авагчийг нь олж өгсөн юм уу, чухам яг юу хийсэн юм бэ? Дээр нь экспортыг дэмжих энэ төсөлд хамрагдсан ямар, ямар бараа бүтээгдэхүүнүүд байгаа юм бэ гэдгийг асуумаар тодруулмаар байна.

Дараагийн нэг зүйл жижиг, дунд гээд бид их олон жил ярьж байгаа. Гэтэл жижиг, дундын үйлдвэрлэгчид маань үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх, борлуулах тал дээр маш.../минут дуусав/

С.Ганбаатар: Бум-Очир гишүүн маш чухал асуултууд асууж байна шүү. Экспортын талаар, мөн би нэмэлт тайлбар өгөхөд аудитын материалыг би энэ хурлыг зохион байгуулалтыг хангах үүрэгтэйгээр бүр мессеж явуулсан байгаа шүү. Хэнд нь явуулсныг нь би яриад яах вэ? Удирдлагууд, хамт олон, сайд бүгд мэдсэн байх ёстой. Тэгэхээр та нар маань өнөөдөр өгчөөрэй. Энэ 2 Байнгын хорооны гишүүдийг, Улсын Их Хурлын гишүүдийг үл хүндэтгэсэн гэж би бодохгүй байна. Та нар маань их завгүй байсан байх гэж би ойлгож байна. Хариултаа өгье. Хариулт 4 Номер ТНБД.

Т.Жамбалцэрэн: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Аудитын тайланг 23 оны жилийн эцсээр аудитлагдсан байдлаар тайлангуудыг ирүүлье. 24 оны аудитууд 3 сард дуусна. Яамны дотоод хяналтын нэгжээр хийсэн хагас жилийн тайлангууд байгаа. Тэд нарыг бас нэмэлтээр ирүүлье.

Төсөл хөтөлбөртэй холбоотой бидний хувьд ч гэсэн тийм нуух, хаах зүйл байхгүй. Сайн гэж өөрсдийгөө магтах тийм зүйл байхгүй. Тэгээд аль болох нөгөө ХХААХҮ-ийн салбар дээр сүүлийн 12 жил ингээд хөрөнгө оруулалтуудыг ингээд аваад үзэхээр хөрөнгө оруулалтын тийм зардлууд огт нэг ч төгрөгөөр ч нэмэгдээгүй өнөөдрийг хүрсэн. Ямар үед нэмэгдэж байсан бэ гэхээр ЗГ-ын бонд, ноолуурын мөнгө гэдэг юм уу, нөгөө улс төрийн шийдэлтэй энэ үеүдэд нэлээн тийм хөрөнгө оруулалтууд нэмэгдэж байсан. Нөгөөдөх нь дандаа татаас урамшуулалд явж байсан. Бодит салбар дээр хөрөнгө оруулалтууд огт хийгдэж ирээгүй.

Сүүлийн 3 жил хүнсний хангамж, аюулгүй байдал Үндэсний хөдөлгөөнтэй холбоотой, Цагаан алт хөдөлгөөнтэй холбоотой, Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотой арилжааны банкны эх үүсвэртэй санхүүжилтүүд гарч эхэлсэн. ХХААХҮ-ийн сайдын багцад зөвхөн хүүгийн хөнгөлөлт, татаас урамшууллууд нь л тусаж явж байгаа. Энэ нь юу хэлэх гээд байна гэхээр нөгөө талдаа манай энэ орон нутгийн чадавх, энэ орон нутгийн дэд бүтэц, энэ зах зээлийн сүлжээ, нэмүү өртгийн сүлжээнд холбогдох дэд бүтэц маань маш муу байна. Энэ дэд бүтцийг бид яаж бий болгох вэ, анхан шатын түүхий эд бэлтгэлийн тогтолцоо хоршооноосоо эхлээд боловсруулах үйлдвэрлэл хүртлээ яаж бид тийм зөв гарцыг явуулах юм, түүхий эдийн тогтолцоогоо бид яаж зөв урсгалтай болгох юм, хүнсний бүтээгдэхүүн дээр, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүн дээр ямар байх вэ гэдэг дээр бид нарт дэд бүтцийн асуудлууд хамгийн тулгамдсан асуудал байгаад байдаг.

Тэгээд энэ агуулгаараа бид нарт энэ гадаадын хөрөнгө оруулалт нэлээд дутмаг байна. Манай зах зээлийг их тийм жижиг байдлаар хардаг учраас энэ аль болох түүхий эд бэлтгэгч байдлаар авах ийм сонирхолтой. Тэгээд гадаад зах зээл дээр бид зах зээлээ тэлье гэхээр гадаад орнуудтай хорио цээрийн нөхцөл шаардлагуудыг тохирох шаардлага бий болдог. Тэгээд эргээд тэрэндээ олон улсын стандарт руу зайлшгүй явах шаардлагатай болдог. Тэгэхээр бид дээр энэ хууль, эрх зүйн орчин хамгийн ойрын жишээ гэхэд бид Хөрөнгө оруулалтын тухай хууль, Худалдааны тухай хуулиуд, тэгээд энэ үндэсний стандартуудын асуудал, Кодексийн стандартууд байдаг юм уу энэ олон улсын стандарт руу бид энэ үйл ажиллагаануудаа шахах ажлууд явах ёстой. Тэгээд энэ чиглэлийн ажлууд маань

бид дээр дутагдалтай байгаа учраас гадаадын хөрөнгө оруулалтуудын асуудлууд, энэ зах зээл нөгөө бизнес эрхлэхийн энэ нөгөө зах зээл нь өргөждөггүй, томордоггүй асуудлууд байгаад байгаа юм.

Яг түрүүний хэлдгээр бид ЖДҮ-лэлийн асуудал гээд 2006 онд Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг батлаад өнөөдөр үндсэндээ 20 жил бий болчхож байгаа юм. 20 жилийн үр дүнгээр гээд яг энэ зах зээл дээр томоохон массын үйлдвэрлэл хийж байгаа, экспортыг зорьж байгаа ААН-үүд бол илүүтэй том ААН-үүд.../минут дуусав/

С.Ганбаатар: Бум-Очир гишүүн тодруулж асууя.

Д.Бум-Очир: Түрүүн би яг хэлэх гэж байгаад орхисон. Та бас үргэлжлүүлээд ярьчихлаа. Жижиг, дунд маань бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхдэг. Сумаар энэ тэр явах юм бол орон нутагт нэг арьс шир боловсруулах гээд жижиг, дунд яачихсан. Яг яваад очихоор таны энэ ажиллаж байгаа юу гэхээр ажиллахгүй байгаа гээд. Үгүй ээ яачхав энэ чинь зээлд хамрагдаад та чинь арьс шир боловсруулаад гэхээр зарах борлуулах зах зээл нь байдаггүй. Тэр суман дээр амьдарч байгаа хэдэн хүн авбал авна, чадвал аймаг руу оруулбал оруулна, тэгээд л тэрнээс цааш байхгүй. Тэгээд нөгөө бид нарын дэмжээд байгаа жижиг, дунд маань тодорхой хэмжээгээр бүтээгдэхүүн боловсруулах боловчиг зах зээл дээр гаргаж чаддаггүй нэг ийм том зүйлүүд. Тэгэхээр энэ төсөл хөтөлбөрүүдээс түрүүн та нар яаман дээр тэр эрэлт шаардлагын жагсаалт байгаа гэсэн. Тэр жагсаалтаас энэ зах зээлд борлуулах ажлыг нь дэмжиж өгөх ажил хийгдэх боломжтой юу 1 дүгээрт?

2 дугаарт та сая тэр олон улсын стандарт гэсэн. Энэ олон улсын стандарт дээр миний ойлгож байгаагаар мөшгөх систем хамгийн чухал гэж би ойлгоод байдаг юм. Ялангуяа нүүдлийн мал аж ахуй дээр. Мөшгөх системийг... /минут дуусав/

С.Ганбаатар: 4 номер ТНБД хариулъя.

Т.Жамбалцэрэн: Бум-Очир гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ үйл ажиллагаанууд дээр бид энэ ОУБ төсөл хөтөлбөрүүдээ л илүүтэй дайчилж ажиллаж байгаа. Ялангуяа малын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл дээр бид энэ малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, мал эмнэлгийн нэгдсэн системийг бид нэвтрүүлж байгаа. Тэгээд энэ маань малчны хотноос хэрэглэгчийн ширээн дээр хүртэлх тэр экспортод гарах үе шат болгоныг ийм хянах тогтолцоо бүрдэж өгч байгаа юм. Энийг бид богино, өнгөрсөн хугацаанд бий болгож чадсан нэг дэвшил байгаа юм. Энийг сайжруулах шаардлага байгаа юу байгаа. Тэгэхээр энэ асуудлуудаа бид стандартуудынхаа асуудлыг, мөшгөх асуудлуудаа бид сайн хийж чадах юм бол бидэнд бол боломж гарах юм болов уу гэсэн ийм асуудал байгаа. Зах зээлтэй холбох асуудлууд дээр, юу асууж байлаа?

С.Ганбаатар: Тэр тодруулж Бум-Очир гишүүн асуухад экспортод гаргах тал дээр яг хамгийн гол төвлөрч ажиллаж байгаа, үр дүн гарч байгаа төсөл нь юу вэ? Тэр талаар нэг тодорхой мэдээлэл өг дөө. 4 номерын микрофоныг нээж өгье.

Т.Жамбалцэрэн: Энэ экспортод гарах асуудал дээр бид ялангуяа энэ нөгөө жижиг, дунд үйлдвэрлэлийн гэдэг юм уу, жоохон тийм онцгой чанартай unique

бүтээгдэхүүн дээр бид энэ нөгөө олон улсын шаардлагуудыг нэлээн газар зүйн заалттай гэдэг юм уу, Кодексийн стандартад орчихсон гэдэг юм уу, тэр бусад тэр гарцуудыг хайхгүй бол массын үйлдвэрлэлийн зах зээл дээр бид экспортод гарч чадахгүй байгаад байгаа юм. ХХААХҮ-ийн салбар дээр явж байгаа татаас, урамшуулал, дэмжлэг гэхээр гэхээр илүүтэй нөгөө бүтээгдэхүүний гарц тал руу яваад, бид нарын дутагдалтай байгаа хэсэг нь тэр чадавхжуулах, зах зээлтэй нь холбох, тэр маркетинг хийх энэ чиглэлийн үйл ажиллагаанууд нь орхигдчихоод яваад байгаа юм.

Цаашлаад бид бараг нөгөө хэрэглэгчийг дэмжиж байж, бодит хэрэглээг бий болгож байж нөгөө бүтээгдэхүүнийг нь зах зээлд борлуулдаг, зах зээл дээр нийлүүлдэг, ашиг орлоготой байх энэ чиглэл рүү бодлогыг чиглүүлэхгүй бол анхан шатын бүтээгдэхүүний гарц тал дээр нөгөө татаас, урамшуулал, дэмжлэг энэ чиглэлүүд маань яваад байгаа учраас болохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр бид үндсэндээ 3 үе шатлалтай арга хэмжээ.../минут дуусав/

С.Ганбаатар: 4 номерын микрофоныг гүйцэд хариулах боломж өгье.

Т.Жамбалцэрэн: Зөвхөн эхнийхээ шатан дээр ерөөсөө татаас, урамшуулал тэр нэг бүтээгдэхүүний гарц тал дээр яваад, 2 дахь шат руугаа тэр нөгөө бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, зах зээлтэй нь холбох, борлуулах, экспортод гаргах энэ чиглэл дээрээ бид хийж чадахгүй яваад байгаа юм. Тэгэхээр бидний энэ хэрэгжүүлж байгаа төслүүд маань улсын төсөв дээр ч гэсэн энэ асуудлуудыг ярихаар ерөөсөө төдийлөн дэмжигддэггүй, батлуулж чадахгүй яваад байгаа юм. Тэгэхээр болохгүй байгаа асуудлууд эд нар байгаад байгаа юм. Тэгээд эргээд энэ нөгөө болохгүй байгаа асуудлаа реформын шинжтэй өөрчлөлтүүд байгаад байгаа юм. Зөвхөн бид энэ дээр энэ гарал үүслийн асуудал ингээд л яригдангуут нөгөө татаас, урамшууллуудын асуудлууд ороод ирж байгаа юм. Ноосны, арьс ширний, тэгээд төмс, хүнсний ногоо, сүү гэдэг юм уу. Тэгэхээр бид тодорхой зорилтод хүрээд энэ арга хэмжээ нь хэрэгжсэн бол тэр тохируулгын дахиж шинэчлэлүүдийг нь, арга замуудыг нь тодорхойлоод, дараагийн шат руу хэрэглэгдчихмээр байгаад байгаа байхгүй юу.

Дараагийн нэг асуудал нь хэрэглэгчээ бид яаж дэмжих юм. Бид нэг талдаа ингээд үйлдвэрлэлээ дэмжээд яваад байна, тэр нөгөө консалтинг юу гэдэг юм тэр үйлдвэрлэгчийг дэмжээд яваад байна, буцаагаад тэр хэрэглэгч хэсэг дээр нь яаж дэмжих юм бэ. Дахиад энэ төслүүдийнхээ нөгөө боловсруулах шатан дээр тэр санаануудаа оруулж явмаар байгаа юм. Улсын төсөв дээр ч гэсэн энэ нөгөө чадавхжуулах чиглэлийн асуудлууд түрүүн асуулт дээр яригдаж байсан. Нөгөө соён гэгээрүүлэх гээд хэлж байсан, энэ агуулгууд ч гэсэн ер нь их тийм дутмаг байгаа. Тэгээд энэ дээр анхаарч өгвөл сайн байна гээд гэдэг дээр гишүүний санал дээр хэлэх гэсэн юм.

С.Ганбаатар: Төрийн нарийн бичгийн дарга хариулж дууслаа. 1 зүйл нэмж хэлэхэд байна шүү дээ дарга нараа манай ХААЯ мал аж ахуйн салбар, хөдөө аж ахуйн салбар дээр хамгийн шилдэг гэсэн туршлагууд бид хэрэгжүүлэхгүй бол болохгүй шүү дээ. Бенч Марк ч гэж яриад байдаг. Тэгэхээр тийм туршлага жишээнүүдээ бидэнд болж өгвөл өгөөч. Би 2 сар ХААЯ-наас л гуйж байгаа газар, хэлтсийн дарга нараас нь гуйж байгаа. Яагаад гэвэл бид чинь хөдөөгүүр орон нутгаар тойргуудаараа явдаг. Хамгийн тэргүүн зэргийн хоршоо туршлага энэ байна шүү. Одоо хоршооны сургалт хийсэн гээд л та нар чинь энд 3881 төлөөлөлд

шат дараалан хоршооны сургалт хийсэн л гэж байна. Ямар бүтээгдэхүүн дээр, яаж экспортод гаргах гэж байгаа юм гэдэг ийм талаар та нэг бест практикуудаа бүгдийг нь хуваалцаж өгөөрэй. Энийг би дахиад гуйя. Бүр микрофон дээрээ хэлж байна шүү. Жаргалсайхан дарга хариулъя, асуулт асууя.

Л.Жаргалсайхан: Өнөөдөр нийт 7 төслийн 220 гаруй сая доллар буюу 770 тэрбум төгрөгийн зээлээр хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдийг хараад сууж байна л даа. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар үндсэндээ нэг ЖДҮ-лэл, газар тариалан, мал аж ахуй гээд. Тэгэхээр энэ дээр хаягдаад байгаа нэг зүйл энэ мал аж ахуй бас нэг тийм тодорхой түвшинд бодлогоос хаягдаад байгаа юм шиг ингээд харагдаад байна л даа. Түрүүн Уянга гишүүн ингээд асууж байсан. Яг энэ малчны тэр өвөлжөө, малчны малыг эрсдэлээс хамгаалах дээр ямар төслүүдийг бид оруулж ирсэн бэ? Энэнээс гарсан үр дүн, үүнийг яаж бид бүхэн цаашид авч явах бодлого, зорилго байна вэ гэдэг нэг дэх асуудал.

Ингээд Монголчууд үндсэндээ ингээд мал аж ахуй дээрээ суурилсан эдийн засагтай буюу 247 мянга гаруй малчин буюу мал бүхий иргэн байгаа юм. Тэгээд энэ дээрээ шинэчлэлт өөрчлөлтүүд янз янзын л бодлого, зорилгоо тодорхойлохгүй бол ер нь бидний хувьд өнгөрсөн энэ онд маш их хэмжээний хохирлыг амслаа шүү дээ. Монгол Улсын эдийн засагт 4 хувийн хасах оноо авчирсан ийм салбар байж байгаа. Тэгээд энэ дээр ер нь бодлого, зорилго байна уу?

3 дахь асуудал бидний хувьд ер нь энэ бодлого, зорилгоо тодорхойлоод энэ олон улсын зээл хөтөлбөрийг хайдаг юм уу, эсхүл орж ирсэн энэ зээл хөтөлбөрийг ингээд аваад байдаг юм уу? Тэгээд гишүүдэд нэг ийм ойлголт байгаад байна шүү дээ. Ийм хэмжээний зээл хөтөлбөрүүд хэрэгжээд байна. Яг үр дүн хаана байгаа юм бэ энэ дээр бид хяналт буюу аудитад хийлгэсэн тайлан байна уу гэдэг чинь л бас л үр дүн муу байгаа учраас л ингэж яриад байна шүү дээ. Тэгээд энэ тал руугаа та бүхэн дээр ямар байдлаар энэ төслөө олдог юм бэ, ямар байдлаар энэ төслөө хэрэгжүүлдэг юм гэдэг дээр асуулт байгаа юм.

Тодорхойлоод ярих юм бол манай энэ хангайн бүс буюу Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймаг, тэгээд говийн бүс Өмнөговь, Дундговь, Дорноговь мал аж ахуй их суурилсан, бэлчээрийн даац хэтэрсэн, уур амьсгалын өөрчлөлт нэлээн хатуу ширүүн болдог. Тэгээд ийм газрууд дээр илүү их энэ усалгаатай хадлан тэжээлийг, хүнсний ногоог бэлтгэх асуудал байгаа байхгүй юу. Гэтэл гол мөрөн ихтэй, хадлан тэжээл ихтэй, бараг усалгаа шаардлагагүйгээр ургадаг газрууд дээр л баахан усалгаатай систем тавьчихсан байж байгаа байхгүй юу. Тэгээд энэ яг хаанаас энэ бодлого нь гараад яваад байдаг юм бэ? Энэ дээр яагаад ийм бодлого яваад байдаг юм бэ? Тэгэхээр энэ тал руу бол миний хувьд ганц хүнсний ногоо гэдэг байдлаар бариад байна уу даа гэсэн юм л харагдаад байна л даа. Энэ МАА-гаа яагаад ингээд бодохоо байгаад хаячихсан юм бэ? Тэгэхээр энэ гол мал аж ахуй чинь яг энэ хангайн бүс дээр байна шүү дээ. Хамгийн их бэлчээр.../минут дуусав/

С.Ганбаатар: Хариулт Төрийн нарийн хариулах уу? 4 номерын микрофоныг нээж өгье.

Т.Жамбалцэрэн: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Мал аж ахуйн салбар дээр салбарын хувьд анхаарч байгаа. Ялангуяа энэ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй энэ мал аж ахуйн салбарт учирч байгаа энэ сөрөг

нөлөөллийг бууруулах, малчдын мэдлэг мэдээллийг сайжруулах чиглэлд энэ төслүүдийн маань үр дүнгүүд чиглэж байгаа. Өнөөдрийн энд Байнгын хороон дээр танилцуулж байгаа 7 төсөл гээд аваад үзэхээр одоо манайд хэрэгжиж байгаа нь 4 төсөл байгаад байгаа. 2 нь зээлийн төсөл зөвхөн арилжааны банкаар явж байгаа ийм төсөл байгаад байгаа. 2 нь нэг нь усалгаатай газар тариалан дээр, нэг нь мал аж ахуй дээр явж байгаа төслүүд. Тэгээд цаашдаа дараа дараагийн ингээд төслүүд дээр явахаар нөгөө илүү төсвийн сахилга батыг сайжруулах чиглэл, манай энэ зээлжих зэрэглэл, эргээд нөгөө эргэн төлөлтийн асуудал маань бид нарт тулгамдаж байгаа учраас эргээд яаж үр ашигтай хэрэгжүүлээд буцаагаад төлөх вэ гэдэг асуудал яригдаж байгаа учраас энэ дараа дараагийн төслүүдийн дизайныг боловсруулаад, эх үүсвэр олоход нэг тийм амар байхгүй болов уу л гэж ингэж бодож байгаа.

Нөгөө талаар энэ мал аж ахуйн эдийн засгийг эргэлтийг нэмэгдүүлэх төсөл дээр бид энэ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдээд энэ тэжээлийн зангилаа төвүүдийг байгуулах, энэ бэлчээрийн ургамлын тариалалт тэр дотроо энэ сэлгээний таримлыг нэмэгдүүлэх энэ чиглэл дээр нэлээн ажиллаж байгаа. Дээр нь ирэх жил энэ Атрын 4 дүгээр аяны хүрээнд тэжээлийн асуудал дээр бид онцгой анхаарна гэсэн ийм чиглэлтэй байгаа. Ялангуяа бид Дархан, Сэлэнгэ, Төв гэдэг нь өөрөө бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлал дээр тулгуурлаад аж үйлдвэрийн төрөлжсөн, хөдөө аж ахуйн төрөлжсөн дэд бүс гэдэг агуулгаар энэ рүү төвлөрөөд байгаа. Эхний ээлжид хүнснийхээ хангамж, аюулгүй байдал дээр эрэмбийн хувьд явж байгаа. Тэр чиглэлээрээ бид газар тариалан, төмс хүнсний ногоо, үр тариан дээрээ нөгөө тал дээрээ малынхаа эрүүл мэндийн асуудал дээр. Одоо малын эрүүл мэндээ дагаад бид малын үржлийнхээ хэсгийн асуудал дээр.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэг нь цэвэр малын эрүүл мэндийн чиглэл байгаа. Баянхонгор, Өвөрхангай, Архангай гээд энэ дээр Өвөрхангай дээр бүсийн лабораторийн чадавхыг сайжруулах ажлууд хийгдэж байгаа. Тарилга, вакцин тэр эрүүл бүсийн асуудлууд яригдаж байгаа. Дагаад энэ дээр үржлийн асуудлууд орж ирж байгаа. Энэ шинэлэг шийдлийн төслүүд, бүтээмж түншлэлийн хөтөлбөрүүд дээр малын тэр загвар аж ахуйнуудыг байгуулаад, тэгээд тэд нарыгаа бид хөгжүүлээд явах. Энэ гол бүсээ дагнасан эрчимжсэн мал аж ахуйн салбараа байгуулаад, буцаагаад бусад салбарууд дээрээ бид юу гэдэг юм нэг загваруудыг бий болгоод явах ажлууд хийгдэнэ гэж ингэж үзэж байгаа.

Дээр нь ялангуяа тодорхой энэ урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн салбарыг энэ байгалийн гамшгаас хамгаалах, цаг уурын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэгээд байгаль цаг ууртай зохицсон мал аж ахуй эрхлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаануудыг бусад энэ ОУБ-ын техник туслалцаа, НҮБ-ын төрөлжсөн байгууллага.../минут дуусав/

С.Ганбаатар: Гүйцээж хариулъя 4 номерт.

Т.Жамбалцэрэн: УОК-той хамтраад тодорхой төслүүд бол техник туслалцааны төслүүд яваад байгаа юм. Тэгээд ялангуяа энэ дотроо бид энэ цаг цаг уурын урьдчилан мэдээлэх системүүдийг хөгжүүлэх, эрсдэлийн үнэлгээнүүдийг урьдчилж хийх, орон нутаг дээр явж байгаа энэ өвөлжилтийн бэлтгэлийг хангах чиглэлээр малчдын өөрсдийнх нь үйл ажиллагаа, өөрсдийнх нь мал аж ахуйн салбараас урьдчилан сэргийлж байгаа үйл ажиллагаа дээр нь

дэмжлэгийг үзүүлье. Малаа байгаль цаг уурт тэсвэртэй, ашиг шимтэй байх чиглэлд нь илүүтэй анхааръя гэдэг бодлогыг барьж ажиллаж байгаа. Энэ хүрээндээ Архангай, Баянхонгор, хангайн бүс, хойд бүсүүд дээр дараагийн гол бүсийн төлөвлөлтүүд явна. Дараа дараагийн энэ хөдөө аж ахуйн бүсүүд дээр явж байгаа энэ төсөл хөтөлбөрүүдийг тухайн жилд нь хэрэгжүүлэх бодлого чиглэлүүдийг нь гаргаж өгдөг энэ хүрээндээ төвийн бүс, хангайн бүс, хойд бүс гэдэг байршлуудаас нь илүүтэй чиглүүлээд явах.../минут дуусав/

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Л.Жаргалсайхан: Дутуу л хариулж байна л даа. 247 мянган малчин буюу мал бүхий иргэн байна. Хангайн бүс бэлчээрийн даацаар 4-өөс 5 дахин хэтэрчихсэн. Яг энэ аймгууд руу тэжээл ургамал тариалах буюу хэрэгцээ шаардлагатай байгаа энэ асуудлыг манай яам өөрсдөө тодорхойлоод, зээл энэ олон улсын тусламжаа хүсдэг юм уу эсвэл орж ирсэн зээл тусламжийг л ингээд л хаашаа ч хамаагүй хуваарилчихдаг юм уу гэдэг нэг дэх асуудал, энд хариулт авсангүй.

Дээрээс нь бидний хувьд энэ нэг юу гэдэг юм малчин гэхээр энэ чинь анхны бүтээгдэхүүн гарч ирж байна шүү дээ. Тэгээд энэ тал руугаа гэхээр малын л эрүүл мэндийн асуудал яриад байна л даа. Түрүүн Уянга гишүүний ярьж байгаа бол тэр өвөлжөө, хаваржааг эрсдэлээс хамгаалах дээр, бэлтгэл ажил хангах дээр ер нь та бүхэн саяын өнгөрсөн жилийн гашуун сургамжаас ямар бодлого тодорхойлсон бэ? Энэ дээр авч хэрэгжүүлж байгаа ямар ажил, арга хэмжээ байна вэ? Энэ 2-ыг тодорхой хэлж өгөөч.

С.Ганбаатар: 4 номерын микрофон ТНБД хариулна.

Т.Жамбалцэрэн: Жаргалсайхан гишүүний асуултад тодруулж хариулъя. Яамнаас гэдэг юм уу шууд тийш нь, ийш нь гээд хуваарилдаг зүйл байхгүй. Түрүүн танилцуулгын явцад хэлсэн. Зээл болгон өөрийн хамрах хүрээтэй, зорилтот байршил, сонгогдсон аймаг, сумдтай байгаад байгаа. Тэгээд энэ үйл ажиллагаа маань өөрөө ЗГ, Улсын Их Хурлаар хэлэлцэгдээд ерөнхий хэлэлцээр зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах үйл ажиллагаанууд маань явагдаж байгаа. Шинээр эхэлж байгаа төслүүд дээр бид энэ зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээд тусгаад явах бололцоонууд байгаа. Одоо энэ хэрэгжүүлж байгаа төслүүд дээр бид тусгаад явах бололцоо байхгүй гэдгийг л хэлэх гэсэн юм.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Эхлээд саналаа, бодлоо хэлчихье. Энэ бид Их Хурал дээр төсөв ярьж байхад л нэг тийм ойлгогдохгүй, уншихад их хэцүү материал ирээд зовоогоод байсан. Энэ удаа бас би тэгж л харлаа. Тэгээд олон дахин гомдол явуулсаар байгаад Сангийн яамнаас сүүлд нь гайгүй юм ирүүлдэг болсон шүү дээ. Тэгэхээр саяын энэ танилцуулсан материал, тараасан материал 2 формат нь өөр, би арай гэж л уншиж араас нь гүйцэд тэмдэглэж авлаа. Түрүүн Ганбаатар дарга хэлээд байсан. Та бүхэн энэ материал дээрээ урьдчилж өгөөд, энэ дээрээ жоохон анхаараач гэж хүсмээр байна. Гишүүдэд энэ тал дээр хүндэтгэлтэй хандах хэрэгтэй байгаад байгаа юм.

Энэ тоонуудыг сая нийлүүлж бодож үзлээ л дээ. Тэгээд миний энэ бодсоноор нийтдээ энэ төслүүд 322,5 сая доллар болж байна 2016 оноос хойш хэрэгжсэн. Тэгээд зарим нь дуусаагүй явж байгаа. 322 сая доллар буюу 1,1 их наяд төгрөг энэ дээрх нийлбэр шүү. Тэгэхээр ер нь их хэмжээний мөнгө л зарцуулж байна хөдөө аж ахуйн салбарт гэдэг нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрт харагдаж байгаа юм. Тэгээд эд нар дундаас яах вэ янз бүр л байна. Би зүгээр энэ Жайкагийн төслийг сүүлийнхийг нь харлаа. Тэгээд Жайкагийн тэр жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл гээд. Тэгээд эндээс харахаар 382 тэрбум төгрөгийг 40 мянган хүнд хүргэнэ гээд 200 мянган хүнд хүргэсэн, эрсдэлтэй зээлийн хэмжээ нь 5 хувь. Энэ ингээд харахаар ер нь манай энэ янз бүрийн төслүүдээс магадгүй хамгийн сайн үр дүнтэй нь явж байгаа юм болов уу гэж эндээс бол тэгж харагдаад байгаа юм. Т

эгэхээр энэ юуг харуулж байна вэ гэхээр нөгөө ЖДҮ сан гээд л бид чинь бөөн хэл ам болсон. Миний санахын нэг тал орчим нь бараг нөгөө эрсдэлтэй зээл байх ангилал. Энэ дээр ердөө 5 хувь. Тэгээд энэ зээлийг ийм хэт бага хүүтэй, хиймэл орчин үүсгэж, тэгээд хуваарилалт хийхээр нөгөө дарга нарын намын найз нар түлхүү авчихдаг, баахан хэрүүл болдог, буцааж төлдөггүй. Энэнээсээ ингэж яг бизнесийнх нь зарчмаар арилжааны банкаар дамжиж явсан нь хамаагүй илүү үр дүнтэй гэдэг нь харагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь цаашдаа ингээд хиймэл орчин үүсгээд, худлаа ийм хулхи эдийн засаг үүсгээд, бодит өртгөөс нь бага юмаар дэмжлэг, бодлого гэж ингэж явуулсаар байгаад сүүлдээ ингээд дийлэхээ больчихдог. Энэнээсээ бид зайлсхийх цаг нь болчихсон юм биш үү?

Тэгээд дээр нөгөө Аж үйлдвэрийн байнгын хороон дээр би бас асууж байсан юм. Энэ хөдөө аж ахуйн, хүнс, хөдөө аж ахуйн салбар дээр чинь 555 тэрбумыг хувийн хэвшилд дэмжлэг болгож олгоно гээд татаас энэ тэр гээд, хүүгийн юу энэ тэр гээд оруулчихсан байсан гээд. Тэгэхээр одоо бодоод үзэхээр энэ их хугацаанд мөнгө зарснаар хүнсний үйлдвэрлэл хэр их хөгжиж байгаа юм бэ? Эсхүл нөгөө түрүүн яриад байсан, нэмэлт хугацаагаа авчихъя, 1 минут.

С.Ганбаатар: Золжаргал гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ж.Золжаргал: Нөгөө бүтээгдэхүүний сүлжээ үүсгэх, экспортод гаргах, дэмжих энэ тал нь орхигдчихоод байдаг. Тэгээд энэ рүүгээ хөрөнгөө цаашдаа ер нь шилжүүлэх шаардлагатай юм биш үү? Тэгэхгүй ингээд салбар салбарт худлаа эдийн засаг үүсгээд, баахан хямдралтай юм гаргаж өгөөд, тэрийгээ буцаагаад нөхөх гэж төсөв дээрээ ачаа аваад, төсөв нь томроод, тэгээд улам ихээр л төр нь данхайгаад л, нөгөө худлаа эдийн засгийн үр дүнд худлаа төсөв үүсээд, тэгээд буцаад тэрэндээ орооцолдоод, нөгөө бид нарын дагаж явах гэж байгаа чөлөөт нийгэм чинь ганцхан ЗГ гэдэг хамгийн том компанитай, тэрийгээ тойрсон улс төрчид нь дагаад тэрийгээ тойрсон ийм паразит шимэгч эдийн засагттай ийм л юм болж хувирах гээд байна. Тэгээд энэ ийм өөрчлөлтийг танай салбар дээр хийх хугацаа нь болсон юм шиг санагдаад байгаа юм. Энэ талаар яригдаж байгаа зүйлс байгаа болов уу гэж? Дараагийнх нь нэмэлтээр тодруулъя. Баярлалаа.

С.Ганбаатар: ТНБД 4 номерт хариулт өгье.

Т.Жамбалцэрэн: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Жамбалцэрэн ХХААЯ-ны ТНБД. Тантай санал нэг байгаа. Ялангуяа хөдөө аж ахуйн салбар дээр энэ олгож байгаа татаас, урамшуулал энэ бодлогын дэмжлэгүүд дээр бид нэг тийм

реформын шинжтэй өөрчлөлт хийхгүй бол яг нийтлэгээрээ улсын төсвийн асуудал хэлэлцдэг, тэгээд л энэ хөрөнгө оруулалттай ажил, салбарын бүтээмжийн асуудлыг ярингуут ХХААХҮ-ийн салбар баахан татаастай, баахан дэмжлэгтэй ийм салбар болчихоод байгаа юм.

Нөгөө талаараа аваад ингээд аваад үзэхээр ДНБ-ий 30 гаруй хувийг бүрдүүлдэг, тэгээд ажиллах хүчний 2 хүн тутмын 1 нь энэ ХХААХҮ-ийн салбарт ажил хөдөлмөр эрхэлж энэ салбарын баялгийг бүтээж байдаг. Тэгээд үр шимийг нь хүртэж байгаа улс үндэстнээрээ хүртэж байдаг. Нөгөө талдаа нийгмийн ийм том салбар болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ зээлийн үр дүн, багтаамж, жижиг, дунд бизнес, бүртгэлтэй хуулийн этгээдийн жагсаалтаас аваад үзэхээр 80 гаруй хувь нь ерөөсөө цэвэр энэ жижиг, дунд бизнесийн ангилалд хамаарч байдаг. Тэгээд энэ агуулга багтаамжаараа нэлээн тийм багтаамжтай салбар болчихоод байгаа юм.

Нөгөө талдаа энэ олон дэмжлэгүүд яг энэ хүнсний хангамж, энэ нийлүүлэлт салбар дээр бодитой хувь нэмэр орж байна уу гэдэг дээр яг үндсэндээ энэ 20 оноос хойших гэдэг юм уу, Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний үр дүнтэй холбоотой гэдэг юм уу, өнгөрсөн хугацаанд хийсэн энэ бодлогын өөрчлөлтүүдтэй холбоотой тодорхой ахицууд гарч байгаа юм. Энэ оны тухайд тэгэхэд ХХААХҮ-ийн салбар 6 хувь гаруйн өсөлттэй гарч байх шиг байна. Ирэх онд бид 10 хувь руу дөхүүлчих юм сан гэсэн ийм чиглэлтэй байгаад байгаа юм. Бидний энэ авч байгаа бодлогын шинэчлэлүүд, зохион байгуулалтын арга хэмжээ бид анхан шатны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж чадаж байна уу, чадаж байна. Тэгэхээр дараагийн шатныхаа алхмыг хийхгүй бол энэ түвшиндээ яваад байна гэдэг л асуудал болчихоод байгаа юм.

Тэгээд бүтээгдэхүүн болгоныг нэр төрлөөр нь аваад үзэхээр харилцан адилгүй байгаад байгаа юм. Тодорхой бүтээгдэхүүн дээр гэдэг юм уу, үр тариа, төмс, хүнсний ногоо, мах гэдэг дээр бид илүү боломжууд байгаад байдаг. Нөгөө талдаа бусад тэр сэлгээний таримлын, будаа гэдэг юм уу энэ чиглэл дээр бид байдаггүй. Тэгээд л өндөг, мах, сүүний боловсруулалтын түвшин гээд эд дээр нь ахиц гарахгүй байгаад байдаг. Энэ яригдаж байгаа төслүүд ч гэсэн өөрсдийнх нь тодорхой зорилтууд нь нэгж малаас авч байгаа махны гарцыг нэмэгдүүлэх, нэгж малаас гарч байгаа сүүний гарцыг нэмэгдүүлэх гээд. Одоо манай дээр сүүний гарцыг нэмэгдүүлэх гээд манай дундаж фермерүүд 2-оос 3 мянган литр сүү л гарч байдаг. Олон улсын жишиг нь гээд тэгэнгүүт 12-оос 13 мянга, 14 мянга, 15 мянга гээд гараад явчихдаг. Бүтээмж нь бусад улсуудтай ингээд өндөр хөгжсөн хөдөө аж ахуйн салбар өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад 4 дахин бага бүтээмжтэй. Төдий хэмжээгээр өртөг нь өндөр байгаад байдаг. Яаж бид бүтээмжийг нь нэмэгдүүлж, өртгийг нь бууруулах вэ гэдэг дээр.../минут дуусав/

С.Ганбаатар: Золжаргал гишүүнд тодруулж асуулт асууя.

Ж.Золжаргал: Энэ нөгөө шинээр хэрэгжих төслүүдээс эхлээгүй байгаа учраас нэг зүйлийг асуучихъя. Энэ Хөдөө аж ахуйн хөгжлийн 2. Тэгэхээр энэ дээр хүрэх үр дүн гээд 3 багц үр дүн бичсэн байгаа, 9 зүйл байна. Энэ 9 зүйл дундаас нэг нь ААН-үүдэд арилжааны банкнуудаар дамжуулж зээл олгоно. Нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нь. Бусад нь болохоор зэрэг сургалт явуулна, чадавхыг бэхжүүлнэ, мэргэжлийн туслалцаа үзүүлнэ, зөвлөх үйлчилгээ үзүүлнэ, бодлогын зөвлөх үйлчилгээ үзүүлнэ, төслийн санал бэлдэхэд тусална, чадавхыг хөгжүүлнэ гээд ингээд. Тэгэхээр энэ чинь нийтдээ 63 сая долларын төсөл

байсан байх буюу 200 гаруй тэрбум төгрөг том мөнгө байгаа байхгүй юу. Тэгээд энэ мөнгийг битгий сургалт, чадавх бэхжүүлэхэд бүгдийг нь зарцуулаасай. Хэд нь тийшээ, хэд нь ийшээ орсон бол?

С.Ганбаатар: Асуултад 1 номерт хариулъя. Нэрээ, албан тушаалаа хэлээрэй.

Ж.Түвшинсанаа: Сайн байна уу? Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн зохицуулагч Түвшинсанаа байна. Би нэмэлт хариулт өгье. Тэгэхээр энэ нийтдээ энэ 2 дахь шатны төсөл маань нийтдээ 57,1 сая долларын юугаар зээлээр авах юм. Үүнээс арилжааны банкаар дамжуулж олгох нь 51 сая доллар буюу 90 хувийг нь олгох юм. Яах аргагүй энэ үр дүн 1 гэж ААН үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын хүчин чадал дээшлүүлнэ гэдэг маань бид энэ дээр шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, стандартыг юу яах нөгөө олон улсын болон бусад стандартыг нэвтрүүлэх гэсэн ийм мэргэжлийн үйлчилгээ байгаа. Энэ дээр нийтдээ нийтдээ 400-гаад мянган долларын ийм үйл ажиллагаа байгаа. Энэ дээр яг төслийнхөө юун дээр болох юм бол бас нөгөө ногоон санхүүжилтийн туршилтын төсөл нэвтрүүлнэ энэ тэр гээд нэлээн задаргаа дээр энэ нь байж байгаа. Үр дүн 3 гэдэг дээр малчид, фермерүүдийн хүчин чадлыг сайжруулах гэж байгаа. Энэ бол.../минут дуусав/

С.Ганбаатар: Тодруулж хариулах боломж өгье 1 номерт.

Ж.Түвшинсанаа: Баярлалаа. Тэгээд энэ нөгөө малчид, фермерүүдийг дэмжүүлэх юман дээр яах аргагүй энд нэмүү өртгийн сүлжээнд орж байгаа Монголын ААН-үүдэд түүхий эдээ нийлүүлж байгаа энэ баг, хоршоод, малчдыг нөгөө юуг сайжруулах сургалтууд явагддаг. Энэ дээр нийтдээ 100 мянган доллар 6 жилийн хугацаанд ингээд зарцуулахаар иймэрхүү юу байж байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Ерөнхийдөө та нар маань төсөл хэрэгжүүлж байгаа улсууд Монгол хүн байна сэтгэлээсээ л ажилгүй яах вэ. Гэхдээ л олон улсын практик дээр ч, өөр яамнууд дээр ч гэсэндээ баахан мөнгө үрж, үрж Монголчуудад өр болгочоод л, тэгээд л нэг хэдэн цаас үлдээгээд л, баахан стандарт үлдээгээд л, семинар улс болгож хаячхаад л гараад явчихдаг тийм тохиолдлыг л тал талаасаа хоорондоо ярьж, үр дүн нь ийм байна, сайн үр дүнг нь улам өргөжүүлье, таарууг нь засаж залруулъя л гэдэг зорилгоор бид өнөөдөр энд хуралдаж байна. Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Энэ гадаад зээлийг ер нь аль салбарт, ямар хугацаанд, ямар хэмжээгээр ашиглах вэ? Ер нь тэргүүлэх аль, аль салбарууд авч байх вэ гэдгийг зохицуулсан ийм хууль гаргах хэрэгтэй юм шиг санагдаж байна. Тэгээд энэ талаар танай яамны байр суурь.

2-т нь энэ төслийг чинь нутагшуулж, цаашаа авч явах ёстой шүү дээ. Ингээд энэ төсөл мөнгө нь дуусчхангуут орхичихдог биш, энд бэлтгэгдсэн боловсон хүчин, энд туршигдсан зүйлүүдийг бусад газрууддаа нутагшуулах энэ чиглэлээр ер нь ямар ажил хийдэг вэ?

Хамтарсан хөрөнгө гаргах талаар ЗГ болон орон нутгуудад хуваарилахдаа энэ шалгуурыг харгалздаггүй уу? Өөрөөр хэлбэл тодорхой хувьд нь хөрөнгө гаргавал энэ зүйл дээр нь хуваарилдаг ч юм уу тэр шалгуурт нь оруулж тухайн

орон нутгийг нь сонгодог ч юм уу ийм тогтолцоо байдаг уу, байдаг нэг жишээ хэлээч?

Дараагийнх нь энэ нөхөн сэргээгддэггүй уул уурхайн салбараас нөхөн сэргээгддэг салбар луу оруулах энэ хөрөнгийн эх үүсвэрийг нэг ийм тогтмол болгох шаардлагатай гэж харагдаж байгаа. Энэ бол ийм хоорондын чухал уялдаа холбоо. Өөрөөр хэлбэл манай энэ 2 Байнгын хорооны хувьд энэ асуудлыг нэг тогтсон нэг ийм бодлого гаргах талаар салбарын яамдтай хамтарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Энэ дээр ер нь та бүхэн ямар санал байна вэ? Өөрөөр хэлбэл Үндэсний баялгийн сангийн тухай хууль шиг нэг ийм төсвөөс хамааралтай биш эсвэл гадаад зээл тусламжаас хамааралтай биш тогтсон ийм нөхөн сэргээгддэг салбарынхаа буюу мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбар, аялал жуулчлалын салбараа дэмжих чиглэлээр энэ дээр ийм өөрийн хөрөнгийн эх үүсвэртэй болох, ингэвэл урт хугацаанд бид бодлогоо зөв тодорхойлж чадна. Энэ талаар ямар төлөвлөлт байна вэ?

Экспортын уян хатан бодлого хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрхэн хэрэгжүүлэх вэ? Жишээлбэл өндөр ургацтай жил холоос тээвэрлээд, ингээд борлуулж чадахгүй. Компаниуд чинь өндөр ургацтай жилдээ экспорт хийж орлого олох юм бол эргээд тэрүүгээрээ өөрийгөө ингэж хөрөнгө оруулалтаа хийж бэхжих ийм боломж гарна. Тэгэхгүй болохоор ингээд хавтгайд нь Монгол Улсын хэмжээнд нэг экспорт хийхгүй гээд бодлого гаргачихаар энэ чинь зах зээлийнхээ зарчимтай нийцэхгүй байгаад байгаа юм. Энэ дээр ер нь ямар бодлого байна вэ? Жишээлбэл энэ жил өвс хадлан их хэмжээгээр бэлдлээ. Энэ ингээд агуулах сав байна уу? Энийг эсвэл экспортлох нэг удаагийн энэ жилийн хувьд экспортлох бодлого байна уу? Ингээд л яг царцанги байгаад байж болохгүй байгаа байхгүй юу. Ноднин зудтай байсан экспортлохгүй байх нь зөв байсан. Энэ жил өнөтэй байгаа учраас экспортлох нь зөв ч гэдэг юм уу. Тэгээд ингэхгүй бол энэний ард их олон үр дагаврууд бас гарна.

Дараагийнх нь тэжээлийн ургамлын ургамал тариалах талбайг ер нь нэмэгдүүлэх үү? Жишээлбэл, манай Хэнтий, Дорнодын бүс нутагт. Энэ тариалангийн газрыг нэмэгдүүлэх талаар ямар бодлого байна вэ? Ер нь өрхийн болон энэ бичил, жижиг, дунд бизнесийг дэмжихэд хөнгөлөлттэй зээлийн бодлого дээр нэмэх нь газар олголт, үнэгүй газар олголт гэсэн үг шүү дээ, давуу эрхээр газар олголт, тэгээд дэд бүтцээр л дэмжих ёстой. Энэ дээр ер нь ямар ийм уялдуулсан бодлого байна вэ? Хөдөлмөр хөнгөвчлөх малчдын талаар ямар бодлого баримталж байна вэ?

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн бол жинхэнэ мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж байгаа, амьдралд ойрхон асуудлуудыг маш тодорхой асуулаа. Хариулт 4 номер ТНБД хариулья.

Т.Жамбалцэрэн: Бадамсүрэн гишүүний асуултад хариулья. Хөдөө аж ахуйн салбар уул уурхайн бус эдийн засгийн бодит салбарыг хөгжүүлэх, эдийн засгаа солонгоруулья гэж ярьж байгаа тохиолдолд зайлшгүй хөдөө аж ахуйн салбар. Түрүүн хэлсэн ДНБ-ий 30 гаруй хувийг хөдөө аж ахуйн салбар бий болгож байна. Ажиллах хүчний 2 хүн тутмын 1 нь байгаа. ААН-үүдийн хувьд хамгийн тийм бодитой бүтээмжтэй салбар. Тэгээд хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийгээд явлаа гэхэд тухайн салбарт оролцож байгаа малчин, фермер, тухайн салбарын оролцож байгаа ААН-үүд бүгдээрэнд нь хүрч байгаа.

Тэгээд энэ маань өөрөө нөгөө шууд үр дүнг нь харахаар тийм бодитой салбар учраас яг таны хэлсэн энэ тэргүүлэх салбарууд дээр тогтсон сан бий болгоод, санхүүжилт хийгээд явдаг бол манай салбарт хамгийн тус дэмтэй болох болов уу гэж ингэж тооцоод байгаа юм.

Түрүүн хэлж байгаа өнгөрсөн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалтууд, одоо энэ олгож байгаа ЗГ, Их Хурлын тогтоолоор батлагдсан энэ хэрэгжилтийг хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдэд бол тухайн салбарууд 2 жилийн дараа гэхэд тодорхой бодит үр дүнгүүд өгөөд явах байх. Тийм учраас бид нарт дутагдаж байгаа хэдий энэ хөтөлбөрүүд хэрэгжүүлээд явж байгаа ч гэсэн цаана нь дахиад бид нарт нөөц эх үүсвэрүүд шаардлагатай болдог. Тэр дэд бүтцүүдийг бий болгодог, сууриар нь тогтвортой энэ нэг салбарыг хэдэн жил дэмжихэд, эргээд энэ өөрөө нийгмийнхээ тогтвортой хөгжлийг аваад яваад, өөрөө өөрийгөө аваад явах боломжтой бодит салбар гэж ингэж үзэж байгаа.

Өвс экспортлох чиглэлээр 2023 онд бэлдсэн буюу өнжсөн экспортыг экспортод гаргая гээд Гаалийн ерөнхий газар луу холбогдох чиглэлийг нь өгчихсөн байгаа. Тэгэхээр бэлдсэн өвснүүдийг гаргах бололцоотой байгаа. 2024 онд бэлдсэн өвсийг энэ өвөлжилтийн нөхцөл байдалтай нь уялдуулаад тодорхой шийдвэрийг гаргах бүрэн бололцоотой. Экспортод гаргах бололцоотой гэж энэ мэдээллийг танд өгье.

Дээр нь Атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлэхтэй холбоотой тариалангийнхаа талбайг бид 200 мянган га-гаар нэмэгдүүлье, нэмж газраа эргэлтэд оруулъя гэж тооцоо судалгааг гаргасан. Холбогдох аймгуудаас тариалангийн талбайд шилжүүлэх, тэжээлийн ургамал тариалах чиглэлээр тариалангийн талбайгаа өргөтгөх чиглэлээр хүсэлтүүдээ саналуудаа ирүүлж байгаа. Энэ процесс нь өөрөө сумын иргэдийн Хурал, аймгийн иргэдийн Хурал гээд дамжаад Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам нэгтгээд, барилга, хот байгуулалтын, Газрын харилцааны газраараа дамжаад ингээд Засгаар шийдвэрлэдэг. Тэгэхээр энэ 200 мянган га-гаар өргөтгөж байгаа нь цэвэр тэжээл рүү бид өргөтгөнө. Цаашдаа энэ эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, энэ тэжээлийн ургамал тариалалтын чиглэлээр нэлээд ахиц гаргана гэж ингэж Атрын 4 дүгээр аян дээр төлөвлөж ингэж оруулж байгаа.

Тэгээд энэ цаашдаа хэрэгжүүлэх энэ ОУБ-ын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүдийг ч гэсэн энэ чиглэл рүү илүү уяж хийх бололцоо байгаа. Ялангуяа манай энэ зүүн бүс өөрөө энэ газар тариалангийн, хөдөө аж ахуйн гол бүс нутгийн нэг. Энэ агуулгаараа ч гэсэн эдгээр салбаруудад хамрагдаад явах бүрэн бололцоо.../минут дуусав/

С.Ганбаатар: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Ер нь хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн их том салбар учраас Монголчуудын хийж чадах салбар учраас энийгээ зах зээлийн зарчмаар нь сайн хөгжүүлэх талаар тийм либерал бодлогыг сайн хэрэгжүүлэхгүй бол тогтсон ийм бодлогоор яваад байхаар болохгүй байгаад байгаа юм л гэдгийг хэлж байгаа юм. Тэгээд энэ талбай нэмэгдүүлэх, тэжээлийн ургамлын талбай, экспорт энэ тэрийнхээ бодлогыг яаралтай гаргахгүй бол цаг хугацаа биднийг хүлээхгүй шүү гэдгийг хэлье.

Тэгээд 1 тодруулах юм нь энэ малчдын энэ хөдөлмөр хөнгөвчлөх чиглэлээр ер нь ямар бодлогын арга хэмжээ авч байна вэ? Ер нь малчдыг дэмжих бодлого, мал сүргийг дэмжих бодлого гээд энэ бол их тодорхой бодлого байх ёстой. Жишээлбэл улсын аварга малчны шагнал ингээд жил болгон л нэг гэр олгодог. Энийгээ ер нь боливол яасан юм бэ? Оронд нь харин тэр хөдөлмөр хөнгөвчлөх нэг ковш ийм техник байдаг юм уу, тэгээд ийм битүү нэг хашаа загварын байдаг юм уу, эсвэл ийм зөөврийн сууц байдаг юм уу, тэгээд цөөхөн хүн шагнаад үнэ цэнтэй улсын аварга малчныг.../минут дуусав/

С.Ганбаатар: Гишүүний асуултад хариулъя. 4 номерын микрофонд ТНБД.

Т.Жамбалцэрэн: Бадамсүрэн гишүүний асуултад тодруулж хариулъя. Зах зээлийг тэлэх, экспортын баримжаатай либерал бодлого хэрэгжүүлэх дээр салбарын яам анхаарч ажиллаж байгаа. Ялангуяа энэ дээр зөвхөн ХХААХҮЯ бас энэ салбар хоорондын уялдаа маш чухал байгаад байгаа юм. Хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүнийг экспортод гаргах, зах зээлийг тэлэх, илүү чөлөөтэй болгох чиглэлээр гадаадын хорио цээрийн нөхцөл шаардлагуудыг маш олон улсуудтай тохирсон тэр гарцуудыг нь бий болгох хэрэгтэй.

Нөгөө талдаа энэ татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийн асуудлуудыг тухайн улсуудтай маш сайн хэлцлүүдийг хийх шаардлагатай бий болж байгаа юм. Бид хорио цээрийн нөхцөлийг бий болгож байна, экспорт хийж байна гээд үр тариа, улаан буудайн гурил, сүүн дээр хорио цээрийн нөхцөлүүд тохирсон. Мах, махан бүтээгдэхүүн дээр тохирсон. Эргээд экспортод гараад ирэхэд нөгөө татварынх нь асуудлуудаас болоод бусад нөгөө импортолж байгаа улсуудтай нь харьцуулахад татварынх нь хувь хэмжээ нь үнийн дүн дээрээ очоод зөрчихдөг. Тэгээд энэ дээр асуудал байдаг. Дээр нь манай энэ.../минут дуусав/

С.Ганбаатар: Гүйцээж хариулъя 4 номерын микрофонд.

Т.Жамбалцэрэн: Хилийн энэ боомтын чадавхууд энэ хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүнийг экспортлоход энэ хилийн боомтуудын чадавхууд, энэ стандартын асуудлууд бас нэлээн тийм тулгамдсан асуудал байдаг. Энэ дээр энэ салбар хоорондын уялдаатай нэлээн сайн бодлогыг хэрэгжүүлж гаргах нь зүйтэй. Тэгээд энэ дээр Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн, Цагаан алт дээр нэлээн ахиц гарчих болов уу гэсэн ийм тооцоотой байгаа.

Малчид хөдөлмөрийг хөнгөвчлөх, мал аж ахуйн салбарт техникийн шинэчлэлийг хийх чиглэлээр Цагаан алт хөтөлбөр, Хүнсний хөтөлбөр, энэ Атрын 4, Шинэ хоршоо хөдөлгөөн гээд энэ өөрөө харилцан уялдаатай ийм хөтөлбөрүүд байгаад байгаа юм. Тэгээд энд малчдынхаа бодлогыг илүү энэ шинэ хоршоо, чинээлэг малчин дээрээ төвлөрүүлээд, тэгээд энэ чиглэлийнх нь тэр сургалт, консалтинг зөвлөгөө, тэр гаднын шинэлэг сууц, техник технологи, хөдөлмөрийг нь хөнгөвчлөх сургалтууд, соён гэгээрүүлэх ажлуудыг маш сайн хиймээр байна.

С.Ганбаатар: Үг байгаа шүү. Бадамсүрэн гишүүн дахиад тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Ер нь энэ улсын аварга малчин намайг Засаг даргаар ажиллаж байхад нэг аймгаас 4 хүн шалгаруулдаг байсан юм, одоо ингээд 8 гээд болчихсон юм байна лээ. Тэгээд энэ ер нь болж байна уу? Энийг жоохон үнэ

цэнтэй болгож, цөөлж, харин цөөлөөд шагналд нь ингээд Монгол гэр өгөхөөс илүүтэй бодитой ингээд ийм загварын жишиг энэ танай энэ төсөл дээр чинь ингээд жишиг юмнууд гээд байна шүү дээ гадаадын дээд тусламжаар хийсэн. Жишиг ийм зөөврийн сууц, жишиг малын битүү хашаа, жишиг техникийн шинэчлэл. Ингэхгүй бол малчид чинь ингээд нуруу, бөөр нь их хүндээр өвддөг болж байна хүнд хүчир ажил. Дээр нь ингээд малаа эрсдэлээс хамгаалах энэ битүү хашаатай болох энэ зүйлийг нь ингэж урамшуулсан, дэмжсэн, бусдад жишиг болсон аварга хүн гэдэг чинь нэг ийм хүнийг аварга гэж байгаа юм. Хөдөлмөр хөнгөвчилсэн ийм технологи нэвтрүүлсэн гэж энэ чиглэл рүүгээ явахгүй бол энэ хуучин арга барилаасаа салъя.../минут дуусав/

С.Ганбаатар: Хариулт Болорчулуун дарга 5 дугаар микрофон дээр. Болорчулуун даргаа цол тэмдгээ хэлээрэй.

Ц.Болорчулуун: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Бадамсүрэн гишүүний асуултад хариулт өгье. Тэгэхээр улсын аварга малчин, улсын хошой аварга, улсын аварга тариаланч, тариаланч хамт олон, улсын аварга фермер, саальчин гээд үндсэндээ эдгээр төрлийн шагналууд Монгол Улсын ЗГ-ын энэ мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа ЗГ-аас олгодог энэ шагнал. Энэ бол олон жилийн улбаатай ингэж явж ирсэн.

Мэдээж энэ олгох хугацаандаа улсын сайн малчин, улсын аварга малчин, дахиад улсын аварга малчин гээд энэ нэрээ хэд хэдэн удаа сольж ирсэн. Ер нь ЗГ-аас олгож байгаа энэ шагнал дээр гэр нэг хэсэг мөнгөн шагналыг нь олгож ирсэн улсын сайн малчны хувьд. Улсын аварга малчин болгоод 2016 оноос энэ бэлгэдэл уламжлалаа бодоод Монгол гэрийг олгоод явж байгаа.

С.Ганбаатар: Аубакир гишүүн асуулт асууя. Болорчулуун дарга дараа нь хариултдаа нэмж хариулаарай.

Т.Аубакир: Баярлалаа. Тодорхой хэдэн асуулт байна. Баян-Өлгий аймаг дээр буюу ер нь аймгууд дээр энэ баригдаж байгаа усалгааны систем энэ ADB-н төслөөр санхүүжээд явж байгаа. Би яг тойргийнхоо л асуудлыг асууя. Манай аймаг дээр баригдаж байгаа 2 сум дээр байгаа усалгааны систем яг хэдэн хувьтай байгаа вэ? Энэ усалгааны систем ашиглалтад орохоор ашиглалтыг нь дараагийн ашиглалтыг нь яг хэнд өгөх гэж байна вэ? Сая түрүүн нэг гишүүний асуултад хариулчих шиг болдог юм сумдаа өгнө гэж. Энэ усалгааны бригадыг ажиллуулах бол ерөөсөө тийм амархан зүйл биш. Яг л мэргэжлийн усалгааны инженер, цахилгааны инженер, тухайн тэр хөрсний янз бүрийн юмаа агро технологийг нь тохируулдаг агроном энэ тэр нийлж байж усалдаг болохоос биш сумд яг тэр бригадыг ажиллуулаад явах боловсон хүчин байгаа гэдэгт би эргэлзэж байна. Тийм учраас энэ дараагийн ашиглалтыг яг хэнд өгөх гэж байна вэ гэсэн тодорхой асуулт.

3 дахь асуудал маань бид энэ Ерөнхийлөгчийн хүртэл ярьж байгаа хүнсний хангамжийн хүрээнд аймгууд дээрээ гишүүдийн өөрсдийнх нь санаачлаад явдаг Шинэ хөдөө төсөл байна, ХААЯ-наас явуулдаг янз бүрийн төслүүдийн хүрээнд механикжуулалтын асуудал, агротехнологийн хор, бордоо, гербицидийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдээд, өмнөх жилүүдтэй харьцуулахад Монгол Улсын хүнсний ногооны тариалалт маш сайжирсан. Энэ зээлийн хүрээнд ТНБД-аа зоорь

барих ер нь бодлого баримталж байгаа юу? Саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг. Манай аймгийн хувьд жилдээ 8-аас 9 мянган тонн төмс хурааж авах хүчин чадал бүхий техникээр өнгөрсөн жил гишүүд бид хангасан байж байгаа. Тийм учраас энэ зээл маань зорь луу чиглэгдэх үү гэсэн нэг тодорхой асуулт байна.

Ер нь энэ зээлийн хэрэгжилт энэ тэр янз бүрийн юмнуудыг бид энэ эрчимжсэн мал аж ахуйн чиглэл рүү нэлээн чиглүүлмээр байна. Одоо яг бид Байгаль орчны байнгын хороо зарим мэдээлэл энэ тэрийг харж байхад энэ цаг агаарын өөрчлөлттэй холбоотой манай энэ Монгол орны бэлчээр талхлалд, бэлчээрийн даац хэтэрсэн байдал энэ тэр бол 10-аас 20 жилийн дараа их л хэцүү түвшинд очно доо. Яамны нөхдүүд маань Болорчулуун дарга олон жил болж байна. Манай Тариаланчдын холбооны дарга сууж байх шиг байна. Энэ байгаль орчинтойгоо зохицсон энийг урьдчилан хамгаалах зорилготой энэ зээл, хөтөлбөр янз бүрийн юмныхаа ахиухан хувийг нь энэ эрчимжсэн, хагас эрчимжсэн байдал руу ер нь чиглүүлбэл яасан юм бэ? Малчдаа ч гэсэн бид түүнд тохируулж бэлдмээр байна залуу малчид.

Энэ 10, 20 жилийн дараа яг энэ Төв Азийн цээжинд байгаа Монгол Улсын байгалийн гамшиг бол их юм дуулгана шүү. Энэ бол тоглоом биш болчихсон. Сая тэр Германы нөхдүүдийн танилцуулсан судалгаа энэ тэр бол сэтгэл эмзэглэмээр юм байна лээ. Тийм учраас тийм санал байна. 1 минутаа нэмээд авчихъя даргаа.

С.Ганбаатар: Аубакир гишүүнд 1 минут нэмье.

Т.Аубакир: 4 дэх асуудал маань малчид маань зээлдээ баригдсан. Миний өрөөнд Улаанхус сумын Ойгороос ирсэн М... гээд малчин сууж байна. Тэтгэврийн зээл авчихсан, малчны зээл авчихсан. Бусад малчид маань хоршооны зээлийг аваад, өмнөх зээлээ дарахад л зориулагдаж байгаа шүү наад хоршооны зээл чинь гэж байгаа. Тийм учраас энэ малчдыг энэ төлбөрийн чадвар, эдийн засгийн байдалд нь хийсэн судалгаа гэж юм ер нь байдаг юм уу? Магадгүй тэр малчдыг энэ хотод сурч байгаа оюутнууд нь дампуурахад нь нэлээн хувь нэмэр оруулж байгаа л даа. Энд бид нар сурч байна, жаргааж байна л гээд байгаа. Тийм учраас энэ эдийн засгийн чадавх, түүнд зориулж тэр залуу малчдадаа эдийн засгийн соёлыг сургах энэ танай энэ зээлийн зарцуулалт дотор явж байна шүү дээ. Энэ рүүгээ ер нь бид анхаарах цаг болчихсон юм биш үү гэж?

Тэгээд 5 дахь асуулт маань энэ ЖДҮ сангийн чанаргүй зээл 5 хувь гэхих шиг болдог юм. Сая бид улсын төсөв хэлэлцэх үед аудитын мэдээлэл авч үзсэн 58 хувь байгаа шүү дээ чанаргүй зээл чинь. Сая яг энэ төсөв хэлэлцэж байх үед бид аудитын дүгнэлтийг авч.../минут дуусав/

С.Ганбаатар: Аубакир гишүүний асуултад хариулъя. 4 номерын микрофоныг нээж өгье Жамбалцэрэн дарга ТНБД.

Т.Жамбалцэрэн: Аубакир гишүүний асуултад хариулъя. ХХААХҮ-ийн яамны Төрийн нарийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Сая танилцуулга дээр гарсан 5 хувь гэдэг энэ зөвхөн нөгөө Жайкагийн санхүүжилттэй ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төслийн үр дүн байгаа юм. ЖДҮ-ийнх бол тусдаа дүн байгаа. Малчдын амьжиргааны түвшин, малын тоо, А дансны мэдээлэл дээр тулгуурласан судалгаа ХХААХҮЯ-н дээр байгаа. Тэр зөвхөн нөгөө малынхаа тоон дээр уялдчихсан. Тэгээд малынхаа тоон дээр гарч байгаа түүхий

эд дээр прогнозолсон ийм судалгаа яваад байгаа юм. Тэгээд энийг нөгөө салбар хоорондын гээд түрүүн ярьж байсан. Салбар хоорондын уялдааг хангах чиглэлээр малчдын нийгмийн асуудлыг нөгөө Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр салаад явчихдаг. Тэгээд энэ хооронд тэр нөгөө салбар хоорондын уялдаа холбоог хангах чиглэлээр нэлээн ахиц гаргахгүй бол бид хэд зөвхөн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, ургамлын гаралтай бүтээгдэхүүн талдаа, салбарын бүтээмж тал дээрээ анхаараад явчихдаг.

Тэгээд малчдынхаа нийгмийн асуудал, тариаланчдын нийгмийн асуудал гэдэг юм уу энэ нь манай тал дээр ингээд орхигдоод явчихдаг. Нөгөө талдаа Хөдөлмөр, нийгмийн хамгаалал дээр болонгуут энэ чиглэл дээр зөвхөн халамж гэдэг агуулгаараа явчихдаг. Тэгээд дунд нь орхигдоод байдаг ийм асуудал байдаг. Тэгэхээр салбар хоорондын уялдаа холбоог хангуулах чиглэлээр энэ тодорхой арга хэрэгслүүдийг хийж ажиллахгүй бол болохгүй тийм нөхцөл байдлууд харагдаад байдаг. Зөвхөн ямар үе дээр гээд тэгэх үү энэ нөгөө нийтийг хамарсан байгалийн гамшиг гэдэг юм уу, ган, зудын энэ гачигдлын үед л энэ асуудал дээр нэг тодорхой асуудал яригдаад орхичихдог ийм нөхцөл байдал байгаад байгаа.

Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд үндэсний хөдөлгөөний хүрээнд нийтдээ арилжааны банкны эх үүсвэртэй зээл, зээлээр хүнсний ногооны агуулах зоорь барих асуудлууд тусгагдчихсан яваад байгаа. Тэгээд одоо гарсан зээлийн дүн дээр судалгаа хийгээд үзэхээр үндсэндээ 55 мянган тонн агуулах зоорийг барина гэсэн ийм төлөвлөгөөтэй. Гарсан зээлийг аваад үзэхээр 32 мянган тонныг барихаар ийм дүн гарсан байгаа юм байна лээ. Тэгэхээр улсын төсөв дээр энэ 25 оны төсөв дээр аймаг, сумдуудад хүнсний ногооны агуулах зоорь барина гэсэн хөрөнгө оруулалт байхгүй байгаа. Цаашдаа энэ хүн амын өсөн нэмэгдэж байгаа өсөлт, энэ хүн амын хэрэгцээг тулгуурлаад нэмэх зайлшгүй шаардлага байгаа юу байгаа.

Атрын 4 дүгээр аяны хүрээнд нэлээдгүй ажлыг хийнэ гэж тооцож байгаа. Энэ дээр яг түрүүний ярьсан энэ тэжээлийн ургамал тариалалт, энэ атар газраа тариалангийн талбай руу шилжүүлэх асуудлууд, малын үржлийн асуудлууд, эрчимжсэн, хагас эрчимжсэн суурин маллагаатай аж ахуйнуудыг байгуулах асуудал зайлшгүй. Хамгийн түрүүнд бидэн дээр байгаа төсөв маань өөрөө хязгаартай учраас эхний ээлжид бид тариалангийн гол бүс нутаг тариалангийн талбай дээрээ түшиглээд эрчимжсэн аж ахуйнууд.../минут дуусав/

С.Ганбаатар: Асуулт хариуллаа. Пүрэвдаваа гишүүн. Тодруулж байна уу та? Болорчулуун дарга, Болорчулуун дарга 5 номерын микрофоныг нээж өгье. Дараа нь 7 Отгонбаяр дарга хариулах юм байна.

Ц.Болорчулуун: Аубакир гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр Баян-Өлгий аймаг дээр энэ АХБ-ны усалгаатай газар тариалан төслийн хүрээнд 2 төсөл хэрэгжиж байгаа. Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цул-Улааны услалтын систем. Энэ услалтын системийн нийт гүйцэтгэл ерөнхийдөө дууссан. Энэ хавраас ажил бид улсын комисс хүлээж авахаар ажиллаж байгаа.

2 дахь нь Сагсай сумын Улаандэлийн услалтын систем байгаа. Энэ услалтын системийн ажил 64 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа. Хавраас бид ажлаа

идэвхжүүлээд ерөнхийдөө оны эцэст дуусах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Энэ төсөл хэрэгжүүлэх, хэрэгжиж байхад зөвлөх үйлчилгээний компани тодорхой хэмжээнд орж ирж энэ бүх төслүүд дээр хэрхэн яаж гүйцэтгэл явагдаж.../минут дуусав/

С.Ганбаатар: 5 номерын микрофон. Болорчулуун даргаа жоохон товч хариулбал нөгөө тайлбар нь бага, яг шууд үр дүнг нь хэлбэл их амар шүү.

Ц.Болорчулуун: Зөвлөх үйлчилгээний компани ажиллаж байгаа учраас төслийг ашиглалтад хүлээж авснаас хойш нэг жилийн хугацаанд энэ компани өөрөө төслийг зүгшрүүлэх, үйл ажиллагааг нь жигдрүүлэх тал дээр зөвлөх үйлчилгээ үзүүлж ажиллана. Энэ хугацаандаа тухайн орон нутгийн иргэд, ногоочдын бүлэг, хоршоодын төлөөллийг энэ услалтын системийг хэрхэн ажиллуулж, яаж цаашаа авч явах вэ гэдэг тал дээр зөвлөх үйлчилгээ үзүүлнэ. Тийм учраас ийм чиглэлээр явж байгаа. Тэгээд орон нутаг өмчлөлийг нь бол тухайн орон нутгийн хоршоодод эзэмшүүлэхээр ийм гэрээ байгуулаад явж байгаа гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Аубакир гишүүн тодруулъя.

Т.Аубакир: Нийгэм хамгааллынхаа яамтайгаа хамтраад энэ малчдынхаа эдийн засгийн чадавх, янз бүрийн юман дээр нэг үнэлгээ гаргах нь зөв байх. Энэ чинь эргээд нөгөө малчдын хойч халаа болсон залуучуудад өгөх ёстой хүмүүжил. Тэнчээнээ хөөрхий өвөл, зунгүй халуун, хүйтэнд л малаа хариулаад явж байгаа хүмүүс янз бүрийн мэдээллээс хол байгаа шүү дээ. Тийм учраас энэ малчдын зээлийн асуудал ер нь хүндэрчихсэн шүү. Бид яг тойрог дээрээ яваад малчидтайгаа байнга уулзаж байгаа хүмүүс учраас энийг мэдээд байгаа юм.

Тэгээд Болорчулуун даргаа энэ усалгааныхаа системийн дараагийн ашиглалт дээр бид онцгой анхаарахгүй бол 1 жил тэгээд л, 1 жил гэдэг чинь 1 л удаагийн ургац гэсэн үг шүү дээ. Зүгширч амжих ч юм уу, үгүй ч үү? Түүн дээр чинь цаашид нь залгаад явах агро технологийн маш олон ажлууд бий. Усалгаатай талбай гэдэг бол багарын талбай шиг буюу усалгаагүй талбайнаас шал өөр агро технологийн ажилтай шүү дээ. Би бол зарим хөрөнгө оруулалтууд маань хайран юм болчих вий л гэж санаа зовоод байгаа юм. Тийм учраас энэнийхээ эзэмшлийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Аубакир гишүүн ажил хэрэгч санал гаргаж байна. Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Юун түрүүнд энэ яг мэдээллийг тулгаж өгсөн. Тэгээд тодорхойгүй байна. Тэгээд хэд хэдэн асуулт байна. 16-аас 24 оны хооронд хэчнээн хэмжээний энэ зээл тусламж хэрэгжүүлсэн юм бэ? Тэдгээрээс хэдэн хувийг нь хувийн хэвшил санхүүжсэн юм, хэдэн хувийг нь төр санхүүжсэн юм гэдгийг тодорхой болгомоор байна 1 дүгээрт?

2 дугаарт ер нь ялангуяа 16-аас 24 оны хооронд энэ 21, 100 гэдэг 21 аймагт 100 үйлдвэр барина гээд хөтөлбөр батлагдсан. Дараа нь цуцлагдсан. Тэгэхээр зэрэг энэ 100 үйлдвэрээс хэд нь баригдсан юм бэ энэ 8 жилийн хугацаанд? Ялангуяа энэ 100 үйлдвэрээр бол МАН тухайн үед 60 гаруй суудалтай, 2 удаа засагласан. Тэгэхдээ бол энийгээ маш ихээр хийсэн ажил болгож ярьсан. Тэгээд

энэ 8 жилийн хугацаанд хэдэн төгрөг зарцуулагдсан юм, ямар үр дүнд хүрсэн юм бэ? Тухайн үед 1,8 их наяд төгрөг зарцуулж 6 мянгахан ажлын байр бий болгоно гэдэг хөтөлбөр батлагдсан. Нэг ажлын байр 300 сая төгрөг. Энэ бүр маш өндөр өртөг байхгүй юу. Ийм зүйл хийгдсэн. Энэний тайлан огт алга.

2 дугаарт ер нь бизнесийнхийг, бизнес хийж байгаа жижиг, дунд үйлдвэрлэлийг эрхэлж байгаа ААН-үүдэд бол зээлийн хөнгөлөлттэй зээлээр нэг дэмждэг, татварын хөнгөлөлтөөр дэмждэг. 2025 оны төсөв батлагдахад дагалдаж хуулиуд орсон. Түүн дээр та бүхэн санаж байгаа байх татварыг 90 хувиар хөнгөлнө, гаалийн татварыг 100 хувь хөнгөлнө гэсэн. 3 нам нийлээд ЖДҮ-ээс зээл авч байсан нөхдүүд маань томроод, өөрсдөдөө хөнгөлөлт үзүүлэхээр болж байгаа юм уу, зөв үү? Тэгэхээр зэрэг тэр энэ ЖДҮ авсан нөхдүүд чинь бүгд сайд хийж байгаа шүү дээ, зөв үү? Нэлээн олонх нь сайд хийж байгаа шүү. Тэгэхээр зэрэг ард түмэнд хардах эрх байгаа. Ямар улсуудад өнөөдөр ирээдүйн энэ 3 нам чинь шинэ 30 жилийг эхлүүлж байгаа гэж байгаа юм. Ямар ААН-үүд нь татварын хөнгөлөлт эдлэх гээд байгаа юм, ямар ААН-үүд нь гаалийн хөнгөлөлт эдлэх гээд байгаа юм, судалгаа байгаа юу, тоо хэмжээ байгаа юу? Яагаад энэ улсын төсвийн 2025 оны төсөв батлагдахад энэ зайлшгүй дагаж орж ирсэн юм бэ? Тусад нь яагаад хэлэлцүүлээгүй юм гэдэг асуулт байна. Асуултаа авчхаад, хариултаа авчхаад араас нь тодруулъя.

С.Ганбаатар: Хариулъя. Болорчулуун дарга 5 номер.

Ц.Болорчулуун: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Энэ сүүлийн асуултаас нь явъя. 2025 оны төсвийн тухай хуулийг дагаж Гаалийн албан татвараас чөлөөлөх хууль дагаж явсан. Энэ дээр ер нь хөдөө аж ахуйн салбарт тодорхой хэмжээний хөнгөлөлтүүд байдаг. Тухайлбал хөдөө аж ахуйн зориулалттай трактор, комбайн, техник тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордоог гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2008 оноос үе шаттайгаар 3, 3 жилийн хугацаатай чөлөөлж ирсэн. Дундаа бас хуулийн үйлчлэх хугацаа зогсож байсан ийм талууд байгаа.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд гэвэл гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас 3 жилийн хугацаанд чөлөөлөөд, сая энэ 12 сарын 31-нээр дуусгавар болсон. Гаалийн албан татвар бол төлөгдөж байсан. Энийг энэ боловсруулах үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмж, дээрээс нь трактор, комбайныг гаалийн албан татвараас чөлөөлнө гэдэг хуулийг оруулсан байгаа. Яагаад гэвэл энэ нэмэгдсэн өртгийн албан татварын үйлчлэх хугацаа дуусаж байгаа учраас энийг оруулж тодорхой хэмжээнд техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, боловсруулах үйлдвэр гэдэг нь бид Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хүнсний үйлдвэрүүдээ нэлээд зээлийн дэмжлэгээр дэмжсэн байгаа.

Тэгэхээр энэ боловсруулах үйлдвэрүүдийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой хэмжээний хөнгөлөлтийг үзүүлэх, тоног төхөөрөмж дээр хөнгөлөлт үзүүлэх чиглэлд энэ дэмжлэгүүдийг оруулсан. Энэ гаалиар орж ирж байгаа тоо судалгаа хэдий хэмжээний татвар, чөлөөлөлт, хөнгөлөлт эдэлдэг энэ тоо судалгааг танд албан шугамаар жичид нь хүргүүлье гэж бодож байна.

21, 100 хөтөлбөр тухайн үед гараад хэрэгжээд явсан. Энэ 21 аймагт 100 үйлдвэр гэдэг байдлаар явуулсан. Яг манай салбар дээр энэ дээр яг гурилын

үйлдвэрийн хүчин чадал, махны боловсруулах үйлдвэрийн хүчин чадал аймгууд дээр тодорхой хэмжээнд улсын хэмжээнд хүрэлцээтэй байсан учраас яг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбараас энэ дээр 21, 100 хөтөлбөртэй холбоотойгоор малын гаралтай түүхий эдийг боловсруулах арьс ширний цогцолборыг Дархан-Уул аймагт байгуулна гэдэг төсөл бол энэ хөтөлбөрийн хүрээнд орж байсан. Дээрээс нь баруун бүсэд энэ үйлдвэр, технологийн парк байгуул гэдэг төсөл орсон. Баруун аймаг, баруун бүсийн үйлдвэр, технологийн парк байгуулах асуудал нь Ховд аймагт, дэд бүтцийн асуудлыг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгээд, энэ жил 25 оны 10 сар гэхэд бид дэд бүтцийн асуудлыг нь хүлээж авахаар ажиллаж байна. Энэ дэд бүтцийн асуудал шийдэгдсэнээр энэ үйлдвэр, технологийн паркт бол хувийн хэвшлийн ААН-үүд үйлдвэрүүдээ бариад явах ийм бололцоо нөхцөл нь хангагдана гэж үзэж байгаа.

Дархан-Уул аймгийн энэ арьс ширний цогцолбор бол цэвэр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ажил нь яваад зогссон байгаа. Энэ жилийн 25 оны төсвөөс эхлээд энэ Дархан-Уул аймагт бид төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийн, байгуулахад дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээр тусгаад ажлаа эхлүүлээд явж байна. Түүнчлэн ер нь хөдөө аж ахуйн гаралтай энэ боловсруулах үйлдвэрүүд дээр ямар нэгэн хөрөнгө оруулалт хийхгүй. Бид дэд бүтцийн асуудал дээр нь анхааръя гэдгээр. Говийн аймагт бол Говьсүмбэр аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар энэ үйлдвэр, технологийн паркийн асуудал яригдаад явж байгаа. Зүүн аймагт Дорнод аймагт мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар энэ дэд бүтцийн асуудлууд нь шийдэгдэхээр ингээд үндсэндээ 5 газар бид үйлдвэр, технологийн парк дээр анхаарлаа хандуулж ажиллаж байна гэдгийг хэлье.

С.Ганбаатар: 5 үйлдвэр ямар ч байсан хэн нь ч ажилд ороогүй, зүгээр яах вэ хичээгээд явж байгаа гэж ойлгож байна. Зөв үү Болорчулуун даргаа? Нэг нь ч ажилд ороогүй шүү дээ, ажиллаагүй байгаа, бүтээгдэхүүн гаргаагүй байгаа. Тодруулах уу? Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Энэ Төрийн нарийн хариулмаар байна. Тэгээд ингээд шал ингээд гуйвуулах, хөөрхий тэгээд Болорчулуун даргын ч буруу юу байх вэ. Тодорхой асуулаа шүү дээ. Нэг ажлын байрыг 300 сая төгрөгөөр танай өмнөх 2 сайд гэсэн үг шүү дээ, 4 жил, 8 жилийн хугацаанд тийм үү 1,8 их наяд төгрөгийг зарцуулаад 6 мянган ажлын байр бий болгоно гээд хөтөлбөр зарлаад, үйл ажиллагаа нь явсан. Ялангуяа МАН-ын мөрийн хөтөлбөрийн нэг тийм чимэг хэсэг нь байсан. Тэгээд хэд нь хэрэгжсэн юм бэ, хэчнээн ажлын байр бий болсон юм бэ, хэдэн төгрөгийг нь хувьд зарсан юм бэ, хэдэн төгрөгийг нь улсад зарсан юм бэ гэдгээ тодорхой хэлээч гэхээр Төрийн нарийн хариул. Боломжгүй бол тэрийгээ хэл.

2 дугаарт дахиад нэг юм. Хэчнээн ажлын байр одоо бий болох гээд байгаа юм бэ? 25 онд төсвөө батлуулсан та нар. Тэгээд татварын 90 хувийн хөнгөлөлт үзүүлэх гэж байна. Гаалийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Тодруулж хариулъя. 4 номерт Жамбалцэрэн дарга.

Т.Жамбалцэрэн: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Энэ ХХААХҮ-ийн салбарт хэрэгжсэн ОУБ-ын санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүд өөрсдөө төсөл бүр өөр өөрийн онцлогтой. Тэр дотор юу гэдэг юм төр талдаа, хувь талдаа гэдэг юм уу, төр нь хэдийг нь аваад, хувь нь хэдийг нь авсан гэдэг агуулга дээрээ биш,

төслийн үр шимийг энэ салбарт оролцож байгаа иргэн, ААН, хуулийн этгээд хүртэж байгаа.

Зөвхөн энэ Жайкагийн 2 үе шаттай гэдэг юм уу санхүүжилттэй энэ төслийн зээлийн хувьд аваад үзэхэд 99 хувь нь цэвэр хуулийн этгээд, иргэн, ААН-д зээл болгож очиж байгаа юм. Нэгхэн хувь нь төслийн үндсэн үйл ажиллагаа буюу өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд 4 хүний орон тоотой л ажиллаж өнөөдрийг хүрсэн. Үндсэндээ 21 аймагт 419 үйлдвэрийг ААН-д зээл олгосон. Үүний.../минут дуусав/

С.Ганбаатар: 4 номерын микрофон Жамбалцэрэн дарга тодруулж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Үүний 60 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар байгаад байгаа юм. Энэ хугацаанд 15 мянган ажлын байрыг бий болгосон, 12 мянган ажлын байрыг хадгалсан зөвхөн энэ Жайкагийн 2 үе шаттай зээлийн төслийн хүрээнд. Дахиад Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн хүрээнд гээд аваад үзэхээр 68 төслийг санхүүжүүлсэн, 1260 ажлын байрыг шинээр бий болгосон, 6 мянга орчим ажлын байрыг бий болгосон гээд энэ төслийн өөрийнх нь зорилт нь нөгөө илүү нөгөө том үйлдвэрүүд дээр санхүүжилт олгосон учраас төслийн үр дүн нь ингээд харилцан адилгүй гарч байгаа.

Төслийн бүрэлдэхүүн хэсгийн буюу түрүүн хэлсэн төслийн 80 хувь нь цэвэр арилжааны банкаар гараад, зээл олгоод очиж байгаа ийм төсөл. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, Усалгаатай газар тариалангийн төслүүд дээр төслийн тодорхой 30 хүртэл хувь нь сургалт, консалтинг, зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаа.../минут дуусав/

С.Ганбаатар: Ямар ч байсан сая долларын төсөл гэхэд л 300 мянган доллар нь зүгээр консалтинг, зөвлөх үйлчилгээ, цалин гээд явдаг юм байна гэж би ойлголоо. Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ хөдөө аж ахуйн чиглэлээр олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байна л даа. Энэнээс би Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүд дээр асууя. Энд бас 30 сая долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт байгаа 20-оос 25 онд хэрэгжиж байгаа. Энэ төслийн нийт 4 бүрэлдэхүүн хэсэгтэй юм байна л даа. Малын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэхэд 8,5 сая доллар буюу 28,9 тэрбум төгрөг. Гэтэл энэ малын вакцины асуудлыг оруулж чадахгүй байгаа мэдээлэл ирж байгаа бидэнд. Би Мал эмнэлгийн газрын даргатай залгаад утсаа авдаггүй, мессеж бичдэг, дараа ярья энэ тэр гээд л. Гэтэл энэ ОХУ-ын Владимир хотоос авах ёстой юм байна сахуугийн вакцин, бас юу, юу гэнэ вэ хэд хэдэн вакцин. Гэтэл тэдний тал бид вакциныг нь оруулж өгье, тэр тээврийн зардал юм хамаагүй гээд ингэж ярьж байгаа юм байна. Гэтэл энэ төсөв нь хуваарилагдсан юм уу, энэ төслийн хүрээнд энэ ямар учиртай юм бэ? Ингээд юуны үед өвчлөл гарчихсан байвал яаж яах юм бэ энийг? Нөгөө талаар ашиг сонирхлын зөрчил байна уу энэ дээр нэг?

2 дахь асуудал энэ мал аж ахуйн эдийн засгийн эргэлт нэмэгдүүлэх гээд энэ юунаас асууя Баяртулга даргаас. Төслийн хэрэгжилтийг дэмжихэд, үгүй ээ нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэхэд 6,5 сая доллар 22,9

тэрбум төгрөг, мөн төслийн хэрэгжилтийг дэмжихэд 2 сая доллар буюу 6,9 тэрбум. Энийг яг чухам юунд зарцуулсан юм бэ, энэ задаргаа байна уу? Энийг асууя.

Дараа нь Отгонбаяраас Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалангийн төслийн зохицуулагч юм байна. Ерөнхийлөгчийн би даргаа 1 минутаа нэмээд авчихъя. Хүнсний хувьсгалын хүрээнд дотооддоо хүнсний ногоогоор хангахгүй бол хавдрын ихсэлтийн 80 хувь нь хүнсний аюулгүй байдал алдагдсантай холбоотой. Өсөж байгаа хавдар залуужиж байна.

С.Ганбаатар: Бейсен гишүүн 1 минутыг нэмж өгье.

Б.Бейсен: Энэ цэвэр гений өөрчлөлттэй ч юм уу ... ийм бодистой холбоотой байгаа. Хавдрын ихсэлтийн 80 хувь нь энэтэй холбоотой шүү, бараг 20 хувь нь тэр эм юм уу, агаарын бохирдол бусад юмтай холбоотой байж болно. Энэ дээр ямар арга хэмжээ авах гэж байна вэ? Энэ төсөл ер нь зарцуулахгүй юм уу? Энэ бол хамгийн чухал тулгамдаж байгаа асуудал шүү дээ. Дэлхийд бараг манай Монгол Улс бол хавдар эрсдэлтэй юугаар эхний байранд орчхоод байна шүү дээ.

Дараагийн асуудал энэ Байгалийн гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах гээд 13 аравны, 13 сая доллар буюу 44,2 тэрбум төгрөг. Жилийн жилд бид энэ гамшигт юм зараад байна. Тэрний түрүүн гишүүд бас ярьж байна. Малын битүү хашаа ч юм уу, зүүн бус аймгууд зарим аймаг дээр хэрэгжүүлэх тал дээр энэ дээр ямар бодлого барьж байна вэ? Цаашдаа энэ дээр төсөл зарцуулах уу? Энэ 13 сая долларыг яг тодорхой юунд зарцуулсан юм бэ? Одоо тэжээлийн өсөлт хэд байна вэ? Баруун аймаг дээр цасан бүрхүүл тогтсон, өвөлжилт хүндэрч эхэлж байгаа юм байна. Энэ талаар тодорхой хариулт авъя. Дараа нь асуулт асууя, тодруулъя.

С.Ганбаатар: Хэн хариулах вэ? Жамбалцэрэн дарга 4 дүгээр номерын микрофон дээр нээж өгье.

Т.Жамбалцэрэн: Бейсен даргын асуултад хариулъя. ХХААХҮЯ-ны ТНБД Жамбалцэрэн. Тэр сахуутай, сахуугийн вакцнтай холбоотой асуудлыг би тодруулъя даргаа. Яг энэ талаар мэдээлэл алга байна. Гаднаас авна гэхээсээ илүүтэйгээр манай Био комбинат өөрөө сахуугийн вакцин үйлдвэрлэдэг дотоодоосоо авах бололцоо байгаа. Ямар асуудал болсон юм бол би тодруулаад албан ёсоор танд эргээд мэдээлэл өгье.

Ялангуяа энэ мал аж ахуйн эдийн засгийг эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд бид Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж энэ бүтэц тогтолцоог сайжруулаад, төсөв хөрөнгө, бүтэц зохион байгуулалтыг нь дэмжих шаардлага нэлээдгүй гарсан. Энэ дотроо бол улсын төсвөөс зөвхөн малын олон улсын хорио цээртэй малын гоц халдварт вакцины зардал, тарилга үйлчилгээний хөлс л улсын төсөв дээр суудаг. Бусад үйл ажиллагааг бид энэ малын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд нэлээдгүй сайн хийсэн болов уу гэж тооцож байгаа. Энэ дотор түрүүн би хэлсэн энэ мал эмнэлгийн нэгдсэн системийг бий болгох, энэ дэд бүтцийг бий болгож, хөгжүүлэлтийн ажлуудыг хийгээд явж байгаа. Энд бид 410-аад мянган долларыг зарцуулсан, 21 оноос эхэлсэн. Мэдээллийг боловсруулах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ, тэгээд боловсруулах үйлдвэрлэл дээр гарал үүслийг тодорхойлох, баталгаажуулах гээд, мал эмнэлгийн системд оролцож байгаа бүх сүлжээний

талууд ингээд оролцох ийм цахим платформыг бий болгож өгч байгаа юм. Энэ маань өөрөө хэрэглэгчийн ширээнээс малчны хотноос хэрэглэгчийн ширээ хүртэл, экспорт хүртэлх бүхий л үйл ажиллагааг хянахад энэ систем хэрэг болж байгаа. Экспортыг хөнгөвчлөхөд ч гэсэн бид нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэхэд дэм болж байгаа.

Нөгөө талдаа бид мал эмнэлгийн лаборатори, оношилгооны чадавхыг сайжруулах зайлшгүй шаардлага байгаа. Энэ дээр бас улсын төсвийн хөрөнгө оруулалт маань хангалтгүй байгаатай холбоотой. Үндэсний түвшний манайд 2 л том лаборатори байгаа. Нэг нь мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, нэг нь нөгөө нь малын эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори 2 байгаа. Тэгээд энэ хоёроо олон улсын хянан магадлагаанд оруулах, тодорхой хөрөнгө оруулалтын ажлыг нь шийдвэрлэхэд энэ дээр бас зарцуулсан. Нийтдээ 1 сая орчим доллароор бид энэ 2 лабораторийнхоо чадавхыг сайжруулах, олон улсын магадлан итгэмжлэлд авах ажлыг хийсэн. Ховд аймаг, Хэнтий аймагт мал эмнэлгийн бүсийн оношилгооны лабораторийг байгуулсан. Өвөрхангай, Нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн чадавхуудыг сайжруулсан, хөрөнгө оруулалтуудыг хийсэн.

Малын халдварт өвчнийг оношлох, ялангуяа энэ хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах, шинжилгээг олон улсын стандартад нийцсэн аргачлалын дагуу хийж гүйцэтгэх чадавхтай болсон гэж үзэж байгаа. Нөгөө талдаа энэ малын өвчний тандалт, хяналт, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэлээдгүй ажлуудыг хийсэн юм. Энэ дотроо энэ мал.../минут дуусав/

С.Ганбаатар: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Гол нь би тэр юу тийм мэдээлэл өгч байгаа би Мал эмнэлгийн газрын дарга дуудсан, 2, 3 удаа ярилаа, утсаа авахгүй. Улсууд хов, жив ярьж байж магадгүй, ингээд яах гээд яасан чинь мэдээлэл өгч байгаа улсууд, үнэмшихгүй яасан чинь ирдэггүй. Дараа нь залгахгүй ерөөсөө 1 дүгээрт.

2 дугаарт энэ сая ЖДҮ-ийн хэрэгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах 2 шаттай зээлийн төслийн зохицуулагч байна шүү дээ Түвшинтөгс. Түүн дээр энэ тодорхой эргэн төлөлтийн асуудалдаа анхаарахгүй бол жижиг, дундын үйлдвэр дээр энэ жил мөнгө тавигдаагүй шүү дээ. Тэрийг бид хамтарч байж, Байнгын хороо, яамтай хамтарч байж эргэн төлөлтийн асуудлаар анхаараад, энийг нэмэгдүүлэхгүй бол болохгүй байна.

Дараагийн асуудал сая Отгонбаяраас асууя, хүнсний ногооны үйлдвэрлэлийн асуудал. Сая хавдрын асуудал. Энэ дээр нийтдээ анхаарахгүй бол эх орны хөрсөнд ургасан, эрүүл хүнсний ногоогоор хангахгүй бол энэ хавдар ерөөсөө багасахгүй гэдэг асуудалтай байна. Энэ дээр энэ тодорхой.../минут дуусав/

С.Ганбаатар: 7 номерын микрофоныг нээж өгье. Нэрээ хэлээрэй.

Б.Отгонбаяр: Гишүүний асуултад хариулъя. Нийт 23 онд орон нутгийн хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн хөдөө аж ахуйн газарт пестицид гербицидийн үлдэгдлийг тодорхойлох 15 нэр төрлийн бүтээгдэхүүнийг авч өгсөн. Ямар үр дүн хүрсэн талаар бол хөдөө аж ахуйн газрууд дээр бүх мэдээллийн тайлан нь байгаа.

Мөн Ургамал газар тариалангийн хүрээлэн, эрдэм шинжилгээний хүрээлэнд механикжуулалтын багц худалдан авалтын төлөвлөгөөнд орсон, энэ 25 онд хийгдэхээр төлөвлөсөн байгаа.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд Жамбалцэрэн дарга хариулъя.

Т.Жамбалцэрэн: Бейсен гишүүний даргын асуултад хариулъя. Ялангуяа энэ ЖДҮ-ийн хөгжүүлэх сан ЖДҮ-ийн газар дээр улсын төсвөөс сүүлийн 3 жил ерөөсөө 1 ч төгрөгийн хөрөнгө оруулалт тавихгүй байгаа. Эргэн төлөлтөөсөө нэг жилдээ 20 орчим тэрбум төгрөгийг санхүүжүүлээд, 21 аймаг, нийслэл гээд, том дүнтэй төслүүд нь арилжааны банкаар, жижиг дүнтэй төслүүд нь сангаас олгогдоод явж байгаа. Тэгэхээр эх үүсвэр дутагдалтай байгаа учраас энэ эх үүсвэрийг хамгийн сайн нөхөж байгаа төсөл маань манай энэ Байгаль орчныг хамгаалах, ЖДҮ-ийг дэмжих 2 үе шаттай зээл байгаа. Тэгээд энэ төсөл маань арилжааны банкаар хэрэгжээд явж байгаа. Зээлийн хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүн, тэгээд чанаргүй зээлийн ангилал нь 5 хувьтай гээд харьцангуй их тийм сайн үзүүлэлттэй байгаад байгаа юм. Цаашдаа бид энэ төслийнхөө дараагийн үе шатыг эхлүүлээд явах юм бол эх үүсвэр нэлээдгүй бүрдэх болов уу гэж тооцож байгаа. Ирэх жилд бид 25 онд бид нарт 18 тэрбум төгрөгийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Гишүүдийн асуултад хариуллаа. Ер нь хойшид бид ч дахиад 3 жил гаруй зууралдах байх. Тэгээд гишүүд асуулт асуухад шууд хариулбал их амар шүү. Сая Отгонбаяр дарга зүгээр салхи сийгтэл сайхан хариуллаа шүү дээ. Энэ чинь ингээд л тас хийгээд л явчих. Түрүүн Бадамсүрэн гишүүн мянгат малчны шагналыг нэг жоохон амьдралд ойрхон, үр дүнтэй хэрэгцээтэй юм өгмөөр байна гэхэд л тэгээд л хариулт нь мянгат малчны шагнал хэдэн онд эхэлсэн бэ гээд л эхэлж байгаа юм шүү дээ. Ерөөсөө үгүй ээ мөн агуу юм. Асуулт асууж, хариулт авлаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Амгаланбаатар, Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ хөдөө аж ахуйн чиглэлээр жижиг, дунд үйлдвэрийн зээлийн эргэн төлөлт дээр ер нь Байнгын хороотойгоо хамтраад, аймгуудын хөдөө аж ахуйн газартай хамтарч ажиллаж байгаад яамныхан маань эргэн төлөлтөд анхаарахгүй зарим нь чанаргүй зээл байна, зарим нь тийм жижиг, дунд зээл авчхаад ерөөсөө төлөхгүй байгаа асуудлууд байж байгаа. Тэгэхээр энэ дээр 1 дүгээрт анхаарч ажиллаач гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт энэ дахиад хэлье. Хавдрын ихсэлтийн асуудал Ерөнхийлөгчийн үндэсний хувьсгал энэ хүнсний аюулгүй байдал алдагдсантай холбоотой хавдар ихсэж байгаа. Энэ дээр онцгой анхаарахгүй бол эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнсний ногоогоор хангах боломж байгаа энэ төслийн хүрээнд. Цөөхөн хүн амтай юм чинь энийг хангах боломж байгаа гэж бодож байгаа. Хавдрын ихсэлт нь 80 хувь нь цэвэр хүнстэй холбоотой гэж ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр нэг анхаараад төсөл хөтөлбөрийн хэрэгжилт дээр бас Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгалын хүрээнд үүнийгээ бас хэрэгжүүлэх ажил дээрээ анхаарч ажиллаач гэж бодож байна.

Нөгөө талаар Азийн хөгжил банкны 57 сая долларын юу бас хэрэгжиж байгаа юм байна шүү дээ. Энэний хуваарилалт дээр эрэмбэлэх асуудал дээр анхаараад, сая хүнсний үйлдвэрлэлийн асуудал, ногооны, хүнсний ногооны үйлдвэрлэлийн асуудал, жимс, ногоо дээр анхаарахгүй боол энэ дэлгүүрүүдээр

явж байхад бараг ялаа хонохгүй байгаа шүү дээ, суухгүй байгаа ерөөсөө. Тэгэхээр энэ дээр нэлээн анхаараад. Хавдрын асуудал залуужиж байгаа нь яг цэвэр хүнстэй холбоотой асуудал байгаа гэдгээ анхаараач гэдгийг та бүгдэд хэлмээр байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Ганбаатар: Маш чухал санаа хэллээ. Идэрбат гишүүн үг хэлнэ.

Ц.Идэрбат: Та бүхэн тэр аудитынхаа юуг явуулаарай. Яах вэ хөдөө аж ахуйн салбарын асуудлыг эрэмбэлсэн зүйл байна уу гэдэг нь энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж байгаа Хүнсний хувьсгал, Цагаан алт, мөн Шинэ хоршоо гээд энэ хөтөлбөрүүд төрийн бодлого болоод ингээд явж байгаа. Би эрэмбэлсэн зүйл байна уу гэж асуудаг нь хэрвээ санхүүгийн боломж олдвол гаднын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх бол 1 дүгээрт нь энийг хийх юм гэсэн эрэмбэ байна уу гэж ингэж би асууж байгаа юм. Өнгөрсөн парламент дээр нэлээн юмнууд яригдаж байсан шүү дээ. Хэдэн аймагт малчдын хашаа хороог янзалж өгнө гээд л наад асуудал чинь байхгүй болж байсан, эсэргүүцэлтэй тулж байсан.

Болорчулуун сайд бол бүүр сонгодог жишээ шүү дээ. Манайх хөдөө аж ахуйн салбар дээр үүгээр юм хийхгүй, тэрний оронд зам барьчих, тэр нь илүү хэрэгтэй байна гэж байсан жишээ зөвхөн танай салбар дээр байгаа байхгүй юу. Тийм учраас хийх ёстой зайлшгүй хиймээр байдаг санхүүгийн эх үүсвэр байхгүйгээс хийж чадахгүй байгаа төслүүдээ эрэмбэлчихсэн юм байна уу л гэж би асууж байгаа юм. Тэрнээс энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа олон зүйлүүдийг мэдэж байгаа.

Тэгэхээр цаашдаа бид энийг бодож байх ёстой юм билээ шүү. Мөнгөтэй хүн болгон орж ирээд танайд төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ гэхэд за гэж хүлээж аваад 20, 30 жилийн хугацаатай урт юм, энийг дараа нь төлчих л байлгүй гэх байдлаар хэдүүлээ хандмааргүй байна гэсэн ийм санаа. Энэ байгаль орчин дээр ч бас би ялгаагүй ийм зүйлийг ярьж байгаа юм.

2 дахь зүйл зуд турхантай холбоотой хөдөө аж ахуйн салбар маш хүнд байдалд орсныг хэдүүлээ 2 жил ярьж байгаа. Үүний эсрэг хариу арга хэмжээ бол энэ Шинэ хоршоо хөдөлгөөн байгаа. Өнгөрсөн оных бол нэлээдгүй амжилттай явсан. Ингээд он гараад энэ жилийн төсвийн гүйлгээнүүд хийгдэж эхэлнэ. Зээлийн энэ юмнууд олгогдож эхэлнэ. Тэгэхээр яах вэ малчдыг тэр хоршоологчдыг нэг зовоож байгаа юм бол материалаа өгчихдөг, маш уддаг. Яагаад гэвэл эх үүсвэр дутуу гэж байгаа. Бид энд ярихад 8 банк ингээд эх үүсвэрийг нь гаргаж байна, дэмжиж байна гэж ярьдаг. Яг амьдрал дээрээ Төрийн банк, Хөдөө аж ахуйн банк л олгодог. Төрийн банк 70 хувийг нь олгодог, Хөдөө аж ахуйн банк 20 гаруй хувийг нь олгодог.

Тэгэхээр бид ингээд малчдадаа зээл олгож байгаа гэж яриад байгаа. Нөгөө хэд маань авъя гэхээр хоршоологчид маань зээл нь удаад байгаагаас шалтгаалаад бизнес төлөвлөгөө янз янзын юм өөрчлөгдөөд байгаа юм. Тэгэхээр энэ арилжааны банкнуудтай, ялангуяа зээлийн эх үүсвэрээ гаргах энэ зүйлүүдээ бид ний нуугүй л хэлж баймаар байгаа юм. Тэгэхгүй зүгээр танд олгоно гэххэд ингэх биш, энэ сард тэдэн төгрөг олгох юм байна. Хаан банк ингэж байгаа юм байна, Төрийн банк ингэж байгаа юм байна хэн хэндээ амар. Тэгэхээр энэ дээр би ХААЯ-ыг анхаарч өгөөч. Энэ бол манай малчдын маш их хүсэж байгаа зүйл, хэрэгцээтэй байгаа, үр дүнгээ ч бас өгч байгаа. Зарим нь ч тэр өмнөх зээл төлж

байгаа юм гарч л байгаа. Гэхдээ ерөнхий утгаараа би нэлээн амжилттай явах ийм л төсөл хөтөлбөр гэж бодож байгаа гэдгээ хэлье.

2 дугаарт би ХААЯ-ныхантай нэг байнга л ярьдаг зүйл энэ отрын бүс нутаг. Ялангуяа манай тэр Хэрлэн Баян-Улааныг та бүхэн онцгой анхаараач. 200 гаруй мянган га газрыг отрын бүс нутаг гээд хавийн амьтны мал аваачаад оруулчихдаг, хоёрхон хүн тэнд ажилладаг нэртэй. Тэгээд яг тэнд байгаа уугуул, суугуул иргэдийн маш тулгамдсан асуудал болдог. Тэгээд энийг олон жил ярилаа. Энэ 2 дарга бараг ойлгож байгаа байх гэж бодож байна.

Энэ төслийн хэрэгжилт дээр 3, дараагийн асуудал энэ усалгаатай газар тариалан гэж ярьж байгаа. Манай Хэнтий аймгийн Хэрлэн сум дээр хийгдсэн Хэрлэн голын хөвөөн дээр хийгдсэн тэр Жинстийн овоо компанийнхаа асуудлыг та нар өөрсдөө хариуцаарай. Та нараас сонгон шалгаруулалт нь хийж очсон компани шүү. Одоо Мөрөн сум дээр хийнэ гэж байгаа. Жинстийн овоо шиг компани явуулав гэж би онцгой анхааруулж хэлье. Сонгон шалгаруулалт дээрээ.

Дараагийн нэг асуудал бол дараа, дараа хэдүүлээ олон уулзах учраас энэ Халх голын энэ тэр газар нутаг 500 мянган га гээд байгаа. Энэнийхээ асуудал дээр эхлээд нэг зөв зүгийг нь олоорой.

С.Ганбаатар: Идэрбат гишүүн үг хэллээ. Замира гишүүн үг хэлнэ.

С.Замира: Ер нь энэ хэрэгжүүлж байгаа төслийн хэмжээг нь харахад маш том төсөл хэрэгжиж байгаа юм байна. Үр дүнг өгсөн бол манай Монгол орон бараг хөгжихөөр. Жижиг, дунд бизнес эрхлэгчид бүгдээрээ хөл дээрээ босчихоор тийм хэмжээний мөнгө л байна шүү дээ энэ. Тэгээд энийг хэрэгжүүлж байхад ингээд хэрэглэсэн, ингээд хэрэгжүүлсэн гэх юм. Үр дүн нэг л мэдрэгдэхгүй байна даа.

Дээрээс нь энэ ХААЯ гэдэг чинь энэ ЗГ-ын яам биз дээ. Яахаараа Дархан руу нүүчихдэг байна. Тэгээд мал аж ахуйн тэр малын, Мал эмнэлгийн газрын дарга нь Байнгын хорооны даргыг тоохгүй байна гэдэг чинь энэ газар гар, хөл алдаж байгаа юм биш үү. Уг нь яам ЗГ-ын ойролцоо байх ёстой биз дээ. Ийм том төсөл хэрэгжүүлж байгаа газар ингээд нэг аймаг руу нүүчхээд, тэгээд эндээс хааяа нэг дуудлагаар ир гэхээр нь ирэхгүй, нэг ирэхгүй, утас авах нь авна, авахгүй ийм замбараагүй юмаа зогсоох хэрэгтэй. Эхний ээлжид тэр Дарханаас наашаа яамаа нааш нь татсан нь дээр. Ийм том төслийг хэрэгжүүлж байх газар нэг аймаг руу нүүнэ гэж ямар юм байдаг юм.

2 дугаарт хэлэхэд түрүүн Мал эмнэлгийн газарт бид нэг очоод сонсгол хийхэд манай мал эмнэлгийн газарт ер нь хөдөө орон нутагт малчдад хүрэх, хүрч ажиллах малын мэргэжилтэн ч байхгүй, техник ч байхгүй, хүрэлцээ муутай гэсэн. Тэгээд тэр үед би нэг санал хэлж байсан л даа. Уг нь бид 70 жил Оростой хамтраад, малаа эрүүлжүүлээд, газраа эрүүл байлгаад, эрүүл хүнс идэж уугаад, хорт хавдаргүй эрүүл амьдарчихсан биз дээ. Одоо яагаад Оросоос ингээд зайгаа бариад, ингээд хамаагүй хилээс янз бүрийн вакцин оруулаад хортой нь ч мэдэгдэхгүй, хоргүй нь ч мэдэгдэхгүй. Малд тарина, газарт хорхой шавж устах гээд газар цацна, тэгээд хүн болгон хорт хавдартай болсон байна шүү дээ. Айл болгон дунд хорт хавдартай. Эрүүл хүн бараг л үлдэж байна уу, үгүй юу.

Тийм учраас өнгөрсөн 30 жилдээ ингэж явсан аясаар биш, одоо шинэ 30 жил эхэлж байгаа юм чинь юмаа нэг шинээр эхэл л дээ та нар. Олон улсын банкнууд олон улсын төсөл хэрэгжүүлнэ гээд өндөр хүүтэй зээл авснаас зүгээр өөрсдөө хамтраад юмаа хийгээд, туслалцааг нь аваад, хамтран ажиллах хэрэгтэй, ... гэхээр нь, гуйлгачин царайлахгүй. Тэрний оронд бид махаа гаргаж болж байна, арьс ширний үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнээ ноолуураа гаргаж болж байна. Тэгж ашигтай гэрээ хийж болно шүү дээ. Одоо энэ юугаа өөрчлөөч. Энэ хийж байгаа энэ байр сууриа. Тэгж байж арай амьдралд ойрхон юм хийгээд, малаа эрүүлжүүлье, газраа эрүүлжүүлье, энэ хүн болгон хилээсээ ингээд вакцин оруулж ирээд, малчин болгон ингээд вакцин тарихаа зогсооё. Тэгж байж эрүүл болно шүү дээ мал, мал мах бүгд, цагаан идээ нь ч гэсэн.

Тэгээд энэ ЖДҮ гээд хэрэгжүүлж байгаа төсөл ер нь Монголын 90 хувь, сая 60 хувь гэх шиг боллоо. 90 хувь нь түрүүн Сангийн яамны сайд өөрөө амаараа ярьж байсан. Ажилгүйчүүдийг ажлын байраар хангаж байсан нь 90 хувь нь дунд давхарга байсан. Тэр нь зогсонги байдалд ороод ажилгүй болсон хүмүүс, ямар ч ажилд. Ажилд орж байгаа гээд би ийм дунд давхаргын ийм компани үйл ажиллагаа нь ААН нь сэргээд, ийм хүмүүс ажилтай болсон гэж сонсоогүй юм байна. Тийм учраас энэ тал дээр гол анхаарлаа хандуулаач. Энд хэрэгжүүлж байгаа төслүүдээ банкаар дамжуулна гэхээр банкны хүү гэдэг чинь хэтэрхий шүү дээ. Тэгээд тэр чинь барьцаа гэсэн үг. Жижиг, дунд бизнес эрхэлж байгаа хүмүүс чинь түрээсийн байранд амьдардаг. Би яг оёдолчдыг харж байна, хүний түрээсийн байранд амьдарна, тэнд үл хөдлөх хөрөнгө байхгүй, банканд тавих хөрөнгө байхгүй учраас тэр хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадахгүй. Бодитой амьдралд хэрэгтэй, 1 минутаа.../минут дуусав/

С.Ганбаатар: Замира гишүүн маш чухал сайхан үг хэллээ. 1 минут нөгөө үг хэлэхэд байдаггүй юм байна шүү гишүүнээ, ойлгоорой. Амгаланбаатар гишүүн үг хэлнэ.

О.Амгаланбаатар: Манайхан 2 Байнгын хорооны дарга, манай ХААЯ-ныхан өнөөдөр хэдүүлээ ингээд уулзаад сонсож байгаа нь ер нь энэ үр дүн ямар байгаа вэ, хэдүүлээ яаж энэ Монголын хөдөө аж ахуйг сайжруулах вэ гэдэг л ийм зорилгоор уулзаж байгаа. Та хэд маань ч гэсэн, бид ч гэсэн үүрэг хүлээсэн хүмүүс гэдгээ 1 дүгээрт аль, аль талдаа сайн ойлгомоор юм шиг байгаа юм.

Би нэг ийм саналууд хэлье. Тэгээд 2 Байнгын хороон дарга маань энийг цаана нь хөөцөлдөөд хэдүүлээ ажлын хэсэг гаргаад явсан нь дээр байх. Одоо 2000 оноос хойших бүх ЗГ-ын мөрийн хөтөлбөрүүд, хүрсэн үр дүн, улсын төсөв, гадаадын зээл тусламж, хувийн хэвшил гэх зэргээр бүх л хэрэгжсэн зүйлүүдийг төсөв мөнгөтэй нь тэр 2000 оноос хойших малчдын тоо, дээр нь малын тоо, тэр цөлжилт гэх зэргээр бүх үзүүлэлтүүдийг, цаг агаарын мэдээ зэрэг гэх зэргээр бүх үзүүлэлтүүдийг, бүх хэрэгжсэн төслүүд үнэхээр энэ сүүлийн 25 жилд ямархуу хэмжээний санхүү оруулаад тэр вакцинжуулалт дээр нь хэд юм, энэнээс ямар үр дүн гарсан юм гээд бүх хэрэгжсэн бүх мөнгө болгоны цаадах үр дүнг хэдүүлээ нэг харъя. Сүүлийн 25 жилд гарсан энэ хэрэгжсэн бүх зүйлүүдийг хараад яг газар тариалан, мал аж ахуй, энэ нийгмийн амьдралд ямар өөрчлөлтүүд гарсан юм, энэний үр дүнд бид ямар ахиц дэвшил гарсан юм гэдэг энэ дүр зургаа харж байгаад үүн дээрээ дүгнэлт хийж байгаад, урагшаа явахгүй бол үнэхээрийн 20 жилийн өмнө, 10 жилийн өмнө хэрэгжсэн ажлаа нэр нь солиод л яваад байдаг. Үндсэндээ

аймагт 1 төслийг биччихээд 10 газар очоод хандаад, 10 төсөл авчихдаг ийм зүйлүүд байдаг. Тэгээд тайлангаа 10 тийш нь явуулчихдаг.

Тэгэхээр өнөөдөр манай энэ бүх яамнуудын ажил бас л иймэрхүү байгаад байгаа юм. Тэгэхээр хэдүүлээ ийм нэг сүүлийн 25 жилд энэ хөдөө аж ахуй дээр гарсан бүх зүйл дээр нэг ийм үнэлгээ хийгээд, дүгнэлт хийх ийм бүх цаасыг та маань 14 хоногийн дотор бүрдүүлээд энэ 2 Байнгын хороонд өгөөдхөөч. Бүх гишүүдэд тараагаадах. Хэдүүлээ дахиад эндээс нэг ажлын хэсэг гаргаад, нэгэнт л хэдүүлээгийнх нь зорилго энэ Монголын хөдөө аж ахуйг сайжруулах, ард түмний амьдралыг сайжруулах юм бол үүн дээрээ нэг ийм нэг иж бүрэн зураглал хийсэн ажлуудаа нэг дүгнээдэхье. Тэгчхээд харин хойшид яах вэ, дээр нь дахиад та нар энэ дэлхийд хэрэгжиж байгаа энэ хөдөө аж ахуйд хэрэгжиж байгаа шинэ санаануудыг, хамгийн үр дүнтэй шинэ санаануудыг танилцуулаад, тэр юуны цахимжуулалт, дээр нь дахиад энэ шинжлэх ухаан техникийн ололтуудыг яаж хэрэгжүүлж байгаа юм гэх зэргээр. Хэдүүлээ энийг яахгүй бол одоо ингээд л газар тариалангийн юм яахаар л дахиад л тэр социализмын үед хэрэгжүүлж байсан нэг л зүйл яриад байдаг.

Тэр сая 200 мянган га-гаар талбай нэмэгдүүлнэ гэж байна. Гэтэл чинь нэг га-гаас авах ургацаа нэмэгдүүлэх, бүс нутагт нь таарсан гэдэг юм уу, тухайн орчинд нь таарсан тэр үр өгөөжтэй жижиг талбайгаас гэдэг юм уу, үр өгөөжтэй ийм ургац авах л зүйлийг нэгдүгээрх асуудал болж байгаа болохоос биш, том талбай томсгосноороо үр өгөөж ирэхээ больчихсон шүү дээ. Тэгэхээр энэнээсээ авхуулаад бүх юман дээрээ хэдүүлээ нэг үнэлгээ хийчхээд, энэ үнэлгээ дээрээ тулгуурлаад бид яг Их Хурал ямар үүрэг хариуцлагаа хүлээх юм, та нар ямар үүрэг хариуцлага хүлээх юм, орон нутаг нь ямар үүрэг хариуцлага хүлээх юм гэдэг дээрээ эрх зүйн орчныг нь бүрдүүлээд илүү хурдацтайгаар өнгөрсөн 25 жилийнхээ алдааг, магадгүй 30 жилийнхээ алдааг засаад урагшлах энэ боломжоор та нар маань мэдээллээр бид нарыг хангаадхаач.

Тэгэхгүй ингээд л 1 ЗГ ороод л нэг хэдэн жил болоод л сайд нь солигддог, Төрийн нарийн солигддог, аймгийн дарга нь солигддог. Дахиад л шинээр эхэлдэг, нэр нь өөрчлөгддөг. Ингэж явсаар байгаад ингээд Монгол Улс баларчихлаа. Тэгэхээр хэдүүлээ 25 жилийнхээ зураглалыг иж бүрнээр нь гарах 14 хоногийн хугацааг та нар маань нэг гаргаад бидэнд нарт өгөөдхөөч. Тэгээд хэдүүлээ эргээд уулзалдъя. Илүү өргөн бүрэлдэхүүнтэй энэ цаг давчигдалгүй уулзаад шинэ, шинэ гарцуудыг.../минут дуусав/

С.Ганбаатар: Амгаланбаатар гишүүн үг хэллээ. Бадамсүрэн гишүүн үг хэлнэ.

М.Бадамсүрэн: Эдийн засгийн чиглэлийн 2 Байнгын хорооны даргад санал байна. Уул уурхайн салбараас хамгийн их орлого олж байна энэ нөхөн сэргээгддэггүй салбар хөрсөн доор байгаа. Энэ бол малчин өвөг дээдсийн бидэнд үлдээсэн баялаг. Тэгэхээр энийг нөхөн сэргээгддэг салбар буюу мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбар луу дэмждэг болгох энэ тогтолцоог бид бүрдүүлсэн ийм нэг ийм өөрчлөлтийг л хийх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол ингээд хөдөө аж ахуйн салбар маань төсвөөс хараат байна шүү дээ. Төсөв дээр нэг хэдэн төгрөг тусгавал тэгээд явдаг, тусахгүй бол явдаггүй. Тэгэхээр энийг ийм хамтарсан ямар хэлбэр байх вэ энэ дээр санал гаргаж байна.

2-т нь энэ хамгаалагдсан хөрсний тариалан гэдэг зүйлийг нэлээн түлхүү хөгжүүлэхээс гадна бидэнд тулгамдаад байгаа нэг том асуудал бол ерөөсөө энэ өрхийн аж ахуй, бичил бизнесийг дэмжих чиглэлийн зүйл маш их хэмжээгээр орхигдож байгаа. Тэгэхээр энэ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Энэ нэг босгуудыг нь өөрчлөхгүй бол болохгүй байхаас гадна, энэ жишээлбэл Дорнод аймагт гэхэд 10 мянган хүлэмж гээд төслийг бид хэрэгжүүлдэг юм. Ингээд 5, 6 жилийн дараа Дорнод аймгийн хашаанд амьдардаг 10 мянган өрхийг бүгдийг нь 90 хувийн хөнгөлөлттэй үнээр хүлэмжтэй болгох зорилт л тавьж байгаа юм. Энэ бол өрхийн аж ахуйг дэмжихдээ орлогыг нь нэмэгдүүлж, зарлагыг нь бууруулж байгаа ийм нэгжид чиглэсэн л ажил л даа. Тэгээд энэ рүү ийм анхан шат руугаа өрх бүр үйлдвэрлэгч гэдэг зорилтыг лоозон биш, ажил болгож явах маягаар явахгүй бол энэ бидний хүнсний хангамжаа нэмэгдүүлэх, найдвартай экологийн хүнсээр өөрсдийгөө хангах, хүүхэд багачуудыг ажил хөдөлмөрт сургах, хөдөлмөрийнхөө үр шимээр сайхан амьдарч болдгийг ойлгуулах гээд энэ олон зүйлүүд маань ингээд орхигдох гээд байгаа ийм зүйл байгаа учраас энэ төслүүдийг ингэж ийм бүх өрхөд, бүх хүнд энэ уул уурхайн баялгийн өгөөж очдог байх энэ зарчмаа л хэрэгжүүлэх нь зүйтэй.

Яагаад гэвэл бид Дорнод аймагтаа уул уурхайн салбараас орон нутгийн өөрийн санаачилгаар байгуулсан гэрээний дагуу жилдээ 5-аас 6 тэрбум төгрөг төвлөрүүлээд, энэний тодорхой хувь нь хүүхдийнхээ хөгжилд ирээдүйд, тодорхой хувь нь энэ нөхөн сэргээгдэх хөдөө аж ахуйн салбар луугаа гэх зэргээр одоогийн хэрэгжиж байгаа Үндэсний баялгийн сангийн тухай хуультай ижилхэн зарчмыг бид иргэдийн Хурлаараа батлуулаад, хэрэгжүүлээд амжилттай явж байгаа юм. Тэгэхээр энэ чиглэл рүү хөрөнгө хуваарилах тал дээр ялангуяа миний хэлээд байгаа нь гадаадын хөрөнгө оруулалттай компани гэхээр л учиргүй сайхан боломж олгодог, томоохон үндэсний компаниудад том боломж олгодог. Энэнээс гадна өрхийн болон бичил энэ айл өрх бүрийн бизнесийг дэмжсэн ажил руу л бид илүү онцгой анхаарал хандуулж чадах юм бол амжилт олно гэдгийг бас энд хэлье.

Дараагийнх нь нэг санал байна. Манай зүүн бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүдэд ялангуяа манай Сүхбаатар аймгийн малчид, залуучууд, уяачдын зүгээс нэг саналыг удаа дараа тавьж байгаа юм. Энэ бол малын удмын санг хамгаалах чиглэлээр тусдаа хуульч байгаа. Ер нь энэ малыг эрлийзжүүлэхэд энэ чинь ингээд нэг шинжлэх ухааны үндэсгүй дураараа явдаг юм гэж байхгүй шүү дээ. Тэгээд энэ импортоор орж ирж байгаа хурдны удмын азарга, гүүг оруулж ирэхийг хориглох хэрэгтэй гэдэг энэ саналыг дэвшүүлж байгаа юм. Бид энийг зөв гэж үзэж байгаа юм. Яагаад гэвэл хурдны өлгий Сүхбаатар аймагт наадмаар 11-хэн азарга уралдаж байгаа шүү дээ. Тэгээд тэрнээс 5 нь барианд орно. Тэгээд энэ чинь жирийн иргэдэд, жирийн малчин залуучуудад боломж олдохоо болилоо. Энэ импортын азаргыг чинь мөнгөтэй хөрөнгөтэй боломж бололцоотой улсууд оруулж ирээд, тэгээд энийг чинь эргэлтэд оруулахгүй олон мянгаар нь үржүүлээд, тэгээд ингээд ерөөсөө энэ уламжлалт юу байхгүй. Та бүхэн санаж байгаа бол 2005 онд Өвөр Монголын Чингис хаан кино хийгдэхэд энэ дээр Монгол адуу байхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр Монгол адууны удмын санг ер нь яаж хамгаалах вэ? Энэ импортыг яаж.../минут дуусав/

С.Ганбаатар: Манай Бадамсүрэн гишүүн чухал санал, санаачилга гаргаж үг хэллээ. Батлут гишүүн үг хэлнэ.

Д.Батлут: Энэ гаднын зээл тусламжаар хийж байгаа төслүүд яах вэ амжилттай сайн хэрэгжиж байгаа төслүүд байгаа үүсгэхгүй. Тэгэхдээ асуудал байгаа юу байгаа шүү нөхөд өө. Бид тийм үнэ цэнтэй зүйлд хөрөнгө оруулалт хийх ёстой юм байгаа юм. Монгол Улс өөрөө эдийн засгийн бүтцээ аваад үзвэл ерөөсөө уул уурхайг шүтсэн эдийн засагтай. Цаашлаад ер нь яаж эдийн засгаа солонгоруулах вэ хөдөө аж ахуй хамгийн нэн тэргүүний бид нарт хамгийн ойрхон солонгорох боломжтой ийм салбар. Тэр дундаа нийт хүн амын тодорхой хувь нь илүү хувь нь нүүдэлчин уламжлалт мал аж ахуй, хөдөө аж ахуй дээрээ суурилсан ийм эдийн засгийн бүтцийг бий болгож явж байна гээд л ярьдаг.

Тэгвэл бид энэ зээл тусламжийг нэн өгөөжтэй, Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх тэр үндсэн чиглэлд нийцсэн, цаашлаад бүүр нарийвчлах юм бол иргэн хүний сайн сайхан амьдралын тусын тулд зарцуулдаг тийм зүйл олгомоор байна нөхөд өө. Энийг та бүхэн бодлого гаргаж яваач гэж хэлмээр байгаа юм. Тэрнээс биш багийн Засаг даргын контор засдаг тийм хөрөнгө оруулалтыг хиймээргүй байна. Өнөөдөр өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа эрхлэх боломжийг бид хөдөөд бий болгоё л доо. ЖДҮ-лэл гэж ярьдаг, өрхийн бичил бизнес гэдэг бол өнөөдөр төрийн бодлогоос яг үндсэндээ хаягдчихсан гэж хэлж болно. Ямар ч тодорхойгүй, зохицуулалтгүй явж байна. Яг үнэндээ өрхийн бизнес эрхлээд өөрөө өөртөө ажлын байраа гаргаад, хэн нэгнийг ажлын байраар хангасан олон мянган малчид байгаа, олон мянган иргэд байгаа. Тэнд мэдээж татвар бага төлдөг ч гэсэн асар олон хүнийг бид ажлын байраар хангах боломжууд гардаг шүү харин.

Том, том аж үйлдвэрлэл, том, том компаниудаас ялгаварлал нь тэр, ялгаа нь тэр. Том, том ААН-үүд татвар өндөр төлдөг байх. Тэгэхдээ нийт ажиллах хүчний маш цөөхөн хувийг бий болгож байгаа. Тэгвэл тэр салбар луу, тэр малчид руу малаа эрүүлжүүлэх, цаашлаад тэр түүхий эдээ боловсруулж нэгж малаас авах өртгийг нэмэгдүүлэх, өрхийн үйлдвэрлэл эрхэлж ашиг орлого олох боломжуудыг нь нэмэгдүүлэх чиглэл дээр бид зээл тусламж ашигладаг болгож, тэр зээл тусламжийн өгөөжийг ингээд шингээж өгмөөр байна. Ингэж ажилласнаараа л энэ гаднын зээл тусламж гэдэг зүйлийг бид илүү Монголдоо өгөөжтэй, иргэддээ хүрсэн хүртээмжтэй хэлбэрээр хэрэгжүүлэх боломжууд бүрдэж байгаа юм.

Тэгээд миний түрүүн асуугаад байгаа зүйл чинь л тэр л дээ. Тэгээд олон нийтийн оролцоонд тулгуурлаад сайн хэрэгжсэн гэж байх шиг байна лээ. Малчид нь өөрөө магадгүй багийн даргаа, дарга нь энэ миний ажлын байрыг засах хэрэгтэй байна гэхэд түүн дээр нь гар өргөж байгаа байхгүй юу чааваас. Яах вэ би мэднэ л дээ, анхан шатын нэгжид ажиллаж байсан учраас. Та бүхнээс ялгаатай нь. Манай Бадамсүрэн дарга байна анхан шатын нэгжид ажиллаж байсан. Тэр доор байгаа жаргал, зовлонг асар сайн мэднэ. Ямар байдлаар мэдээлэл цуглуулдаг вэ гэдгийг ч аягүй сайн мэдэж байгаа. Тэгэхээр бид нэгж дээр очиж, илүү иргэд дунд орж, тэдний санаа бодлыг таньж, тэд нарт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэхийн төлөө л илүү чиглэж, бас чиглэлээ үр дүнтэй байлгах тал дээр нь анхаарч ажиллаж байж л энэ асуудлыг шийдэх ёстой гэж харж байгаа юм. Асар их мөнгө, хэдэн зуун тэрбум төгрөг байгаа. Энэ мөнгийг Монгол Улсад хэрэгцээтэй, үр өгөөжтэй хэлбэр лүү нь оруулах боломж нь байдаг, байх тал дээр л анхаарлаа хандуулж ажиллаасай гэж хүсмээр байна. Ингэж чадаж гэмээр харин эдийн засгийн солонгорол, тэр дундаа хөдөө аж ахуйн сэргэлт дээр томоохон үр өгөөж, үр дүнтэй зүйлүүд бий болж эхэлнэ шүү. Үүнийг л бүгдээрээ хамтдаа хийе гэж уриалмаар байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Батлут гишүүн үг хэллээ. Жаргалсайхан гишүүн үг хэлнэ.

Д.Жаргалсайхан: Манай гишүүд өөр өөрсдийнхөө өнцгөөс ингээд зөндөө саналуудыг хэлж байна. Миний энэ нэг давхардахгүйгээр нэг саналыг хэлмээр байна. Энэ 247 мянган малчин буюу мал бүхий иргэд байгаа. Тэгээд энэ малчдыг эрсдэлээс хамгаалах, ер нь өөрийнх нь ч эрүүл мэндийн асуудал энэ өмнөх жилийн энэ хүндрэл бэрхшээл, байгалийн гамшиг учирсан сумдуудад айл өрхөд манай Онцгой комиссынхон бүр Шадар сайд очиж ажиллаж байхад ярьж байсан даа. Харьцуулаад ярьж байсан шүү дээ. Хажуу талынх нь айл янзын сайхан нэг ч малын хорогдолгүй байхад нөгөө талынх нь айл ингээд бараг мал нь ингээд хорогдоод дууссан байх жишээний. Тэгэхээр энэ тал дээр бид энэ олон улсын төсөл хөтөлбөрийг тэр малчдыг мэдээлэлжүүлэх, чадавхжуулах, туршлага судлуулах, энэ мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах, тэжээлийн ургамал тариалах, түүнийг хадлан тэжээл бэлтгэх гээд ийм хэрэгцээ шаардлага бол бид нарт байна гэж л ингэж би харсан. Тэгээд энэ тал руу манай яам ямар байдлаар ажиллаж байгааг асуусан боловч тодорхой хариулсангүй.

Ер нь өмнөх жилийнхээ энэ хүндрэл бэрхшээлээс бид бодлого гаргаж, түүндээ зорилт тавьж, түүн рүү гадна, дотнын ямар л хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг хийж, ингэж ажиллах нь л чухал байх гэж бодож байна л даа. Тэгэхээр энэ 250 мянган малчин буюу мал бүхий иргэн гэдэг бол Монгол Улсын бараг ¼-ийг эзэлж байгаа ийм хүн амын амьжиргааг авч явж байгаа салбар шүү дээ. Тэгэхээр энэ тал руу асуудлуудыг хандуулмаар байна. Энэ дээр учир дутагдалтай байна. Тэгээд энийгээ бас нэг бүсчлээд Монгол Улс бүсчилсэн хөгжлийн загварт орж, бодлого тодорхойлж, энэ дээр бол миний хувь сая бас Монгол Улсын хамгийн их цастай буюу Баянхонгор аймгийн Гурванбулаг, Баянбулаг, Заг, Жаргалант, Галуут гээд сумдаар яваад ирлээ. Тэнд яг л нөгөө зудын нөхцөл байдал яг хэвээрээ. Эхнэр нь хүүхдүүдээ аваад сум руугаа орчихсон, тэгээд л ганц бие нэг эрэгтэй зайлуул тэгээд л тэнчээнээ малаасаа бараг долоон дор, бүр ингээд өөрийнх нь эрүүл мэнд, амьдарч байгаа орчин нь дордчихсон, хоол хүнс байхгүй, тэгээд л малынхаа хойноос яваад л орой орж ирдэг ийм хүн байж байгаа. Тэгээд энэ тал руу бид ер нь анхаарахгүй бол болохоо байжээ. Тэгээд энэ бол ерөөсөө ингээд л энэ жил яг л нөхцөл байдал хэвээрээ. Тэгээд энэ дээр та бүхнийг бас анхаарч өгч, энэ дээр бас энэ олон улсын төсөл хөтөлбөр байвал оруулж ирээч. Энэ нэг дэх асуудал байна.

Дараагийн асуудал бид бүхэн сая ингээд ярьж байна. ЖДҮ тэр тусмаа бидний хувьд энэ Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд нэлээдгүй ЖДҮ-тэй холбоотой хүнсний үйлдвэрлэлийг дэмжихдээ олон улсын зээл тусламж, хөтөлбөрүүд ярьж байна л даа. Ахиц дэвшилтэй юм байгаа юу гэвэл үгүйсгэж болохгүй байгаа. Гэхдээ энэ дээр бас их нэлээн тодорхой хэмжээний хяналтыг гэх юм уу, хариуцлагыг сайжруулахгүй бол яг үнэндээ зээл орж ирээд л тэрийг буцаагаад аваад, хэрэгжүүлсэн нэрээр аваад гарч байгаа юм бол байгаа. Энэ дээрээ та бүхэн тодорхой хэмжээний бүр тийм санал оруулж ирж, хяналтынхаа механизмыг сайжруулаач. Ганцхан танай салбар дээр ч биш, манай энэ Байгаль орчны сайдын 28 төсөл арга хэмжээ танилцуулсан та нарын өмнөхөн. Тэгэхээр энэ дээр ч гэсэн ийм асуудлууд байж байгаа. Тэгэхээр энэ дээр мэргэжлийн байгууллага та бүхний хувьд санасан бодсон санал санаачилга байдаг бол энэ саналыг оруулж ирэхийг маш их хүсэж байна. Ийм 2 саналыг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн үг хэллээ. Би 2 санаа хэлчихье. Ж.Энхбаяр сайдад хэлээрэй, би ч мессеж явуулъя хэлье, завгүй л байгаа байх даа. 3 удаа асуудлыг орж ирсэнгүй шүү. 2 удаа асуудал хойшлууллаа. Оруулж ирж байгаа яамных нь материалууд нь маш түүхий, хамгийн гол нь Байнгын хорооны гишүүдийг хүндэл гээд байгаа юм биш. Байнгын хорооны гишүүд, Улсын Их Хурлын гишүүдийг сонгосон Монголын ард түмнийг хүндлээрэй. Туваан, Одонтуяа, бусад сайд нарт бүгдэд нь адилхан шаардлага тавьж байгаа. Бид энийг ажил хэргийн үүднээс хэлж байна шүү. Энэ Дэгийн тухай хууль дээр асуудлаа танилцуулах нь ганцхан сайд байгаа шүү. Тэгээд дахиад хойшлуулаад Монголын ард түмний эрх ашгийг хохироохгүйн тулд өнөөдөр сонслоо, асуулаа. Харин ТНБД цээжээрээ аваад гарч байх шиг байна.

Асуудалтай холбогдуулж би нэг хэдэн санал хэлье. 1 дүгээрт Дэлхийн банкны Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл гээд 30 сая доллар, Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариалангийн төсөл 40 сая доллар миний ойлгож байгаагаар, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл 50 сая доллар, 57 сая доллар. Үгүй ээ мөн их том, том мөнгөний тухай ярьж байна. Тэгээд би танай хашаанд ороод танай хувийн малыг тоолъё гэж гуйж байгаа юм шиг битгий хялайж хараач. Монголын ард түмний нэрээр орж ирээд, Монголын ард түмнээс сонгогдсон хүмүүс нь Монголын ард түмэн дараад нь төлөх энэ мөнгөний талаар, үр дүнгийн талаар асууж, шалгааж, тайлан аудитыг нь асууж байгаа юм шүү. Тэгэхээр эндээс үүдээд нэн яаралтай өнөөдөр ямар та нар балруулдаад, дахиад шинээр зохиож бичих гэж байгаа биш, аудит болон хяналтын материалуудыг бүгдийг нь явуулаарай. Дээр нь нэмээд төсөл хариуцсан газрын дарга утас, бүх холбогдох тэр төлөөлөн удирдах зөвлөл гэж би яриад байгаа юм. Би чинь бас хэд хэдэн төслийн удирдах зөвлөлд байсан хүн шүү дээ. Удирдах хороо гээд одоо шинэ нэртэй байх шиг байна. Энэний нэр усыг нь бүгдийг нь өгөөрэй, явуулаарай, материалуудаа, тайлангуудаа гишүүдийг нэн яаралтай өнөөдөртөө хангаарай.

2 дугаар зүйл гэвэл би бүр газар, хэлтсийн дарга нартай нь уулзсан шүү. Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр. Энэ төсөлтэй болон төсөвтэй холбогдуулж төсөл болон төсөвтэй холбогдуулж хамгийн тэргүүний туршлагыг Монгол орон даяар мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбараар тэргүүн туршлага болчихоор та нарт хэрвээ ололт амжилт байдаг бол тэрийгээ бидэнд нэг тодорхой болгож өгөөрэй л гэж байнга хэлж байгаа. Энэ дээр бүүр ажил хэрэгчээр хандаарай.

4 дүгээрт нь та нар энэ саяын 4 том төслөөс жирийн танил талгүй, улс төрд ямар ч мэдээлэл байхгүй, ямар ч ингээд бор зүрхээрээ түмний төлөө зүтгэж байгаа мал аж ахуй, хөдөө аж ахуйн жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хүмүүс энэ туслалцаа дэмжлэг, зээл тусламж, янз бүрийн татаасанд оръё гэвэл яаж орох вэ гэдэг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Байнгын хорооны дарга нарт болон гишүүдэд явуулна шүү. Би ийм 4 асуудал ярилаа. Энэ чинь нийтдээ 322 сая долларын асуудал, 1,2 их наяд төгрөгийн асуудал ярьж байна шүү дээ. Энэ талаараа та нар дэлгэрэнгүй мэдээлэл явуулна гэж найдаж байна. Гишүүд үг хэлж, асуулт асууж, үг хэлж дууслаа. Ажлын өндөр амжилт хүсье. Дараагийн асуудлаа ярилцъя. Хэлэлцэх асуудлын 2-т оръё. ХХААХҮЯ-ныхаа хамт олонд баярлалаа.

Хоёр. Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэх асуудлын 2-т Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Бейсен нарын гаргасан хүсэлтийн дагуу Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсоно. Ингээд оролцогчдоо би та бүхэнд танилцуулъя. Одонтуяа сайд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Э.Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД, З.Батбаяр Усны газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Х.Мягмаржав Усны газар Ус ашиглалтын технологийн хэлтсийн дарга, Сайханжаргал Усны газрын Төрийн захиргааны газрын дарга. Одонтуяа сайд харагдахгүй байх юм хэвээрээ байгаа биз дээ? Энэ чинь бүр айдаг болчихоод байгаа юм шүү дээ сүүлд. Ж.Энхбаяр сайд энэ 2 маань үгүй ээ мөн их завгүй улсууд байна шүү.

Ажлаа хурдан шуурхай явуулах үүднээсээ, яамны нөхдүүд ээ сайд нартаа анхааруулж хэлээрэй. Энэ нээрээ ажил хэргийн төлөө шүү. Энэ Монголын ард түмэн сонсож байгаа шүү бүгдээрээ. Ингээд бас дахиад хойшлуулбал тэгээд чуулган завсарлалчиг гээд байгаа учраас хойшид ингэхгүй. Баттулга дарга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД мэдээлэл хийнэ үү. 5 номерын микрофон өгье.

Ж.Баттулга: Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ус ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлын талаар та бүхэнд танилцуулъя. Байгаль орчны статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалын дагуу нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм гэж байдаг. Энэ усны нормыг үндэслээд Үндэсний статистикийн хорооны дүн мэдээлэлд тулгуурлан тухайн жилд ашигласан усны хэмжээг бол Монгол Улс тооцож байгаа. Үйлдвэрлэл, барилга, ногоон байгууламж, үйлчилгээний зориулалтаар олборлосон усны хэмжээг бол ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг үндэслэн гаргаж байгаа. Монгол Улс 2021 онд нийт 594,8 сая м³ жил, 2024 онд 606,2 сая м³ жил, 2023 онд 679,1 сая м³ жил ус олборлож ашигласан. Харин 2024 оны урьдчилсан дүнгээр 618 сая м³ жил ус ашигласан байна. Урьдчилсан дүнгээр гэж хэлж байгаа нь нөгөө статистикийн мэдээллүүд маань цуглараад, 2025 оны 1 дүгээр улиралд эцсийн дүн гарахаар байгаа.

Энэ слайд дээр бид салбарын ус ашиглалтын талаарх мэдээллийг та бүхэнд хүргэж байна. Унд ахуй, үйлдвэр, ахуй үйлчилгээ, хөдөө аж ахуй, эрчим хүч, дулаан, уул уурхай гээд ингээд гол салбаруудаар нь ангилсан байгаа. Энэ усны ашиглалтын талаас харах юм бол хэмжээгээрээ хөдөө аж ахуйн салбар 300,5 м³ жил буюу нийт ашиглаж байгаа усны 50 орчим хувийг бүрдүүлж байгаа. Үүний дараа уул уурхайн салбар, тэгээд унд ахуй, бусад салбарууд орж байгаа. Хөдөө аж ахуйн салбарт хамгийн их усны хэрэглээтэй аймгуудыг бол Сэлэнгэ, Төв, Ховд, Увс, Дорнод, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай аймгууд эзэлж байгаа. Мал аж ахуй, усалгаатай тариалангийн зориулалтаар Сэлэнгэ аймаг тэргүүлж байгаа нийт хэрэглээний 20 орчим хувийг эзэлж байгаа юм. Уул уурхайн зориулалтаар Өмнөговь аймаг бол хамгийн том ашиглагч байдаг бол Орхон аймаг, Төв аймаг дараагийн том ашиглагч аймгууд байдаг. Дулааны цахилгаан станцын

эрчимжилттэй холбоотойгоор эрчим хүчний зориулалтаар ашигласан усны хэмжээ 2023 онд нэмэгдсэн. Нийт ус ашиглалтын хэмжээгээр хөдөө аж ахуйн салбар 48,6, уул уурхайн салбар 26,1, хүн амын унд ахуйн хэрэглээ 14,5, эрчим хүчний салбар 5,8, үйлдвэр, ахуйн үйлчилгээний салбар 5 хувийг эзэлж байна.

2024 оны урьдчилсан байдлаар Усны газраас ус ашиглуулах дүгнэлтээр хоногт 100 шоо метрээс дээш ус ашиглагчдын ашиглах нийт усны хэмжээ 224,2 сая м³ жил байна. 50-аас 100 шоо метр ус ашиглагч буюу 21 сав газрын захиргааны ус ашиглах дүгнэлтээр нийтдээ 3,6 сая м³ жил, 0-ээс 50 шоо метр ус ашиглагчдын ус ашиглалт буюу аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын ус ашиглуулах дүгнэлтээр 1,5 сая м³ жил буюу нийтдээ 229,4 м³ жил ус ашиглах зөвшөөрлийг олгоод байна. Барилгын сууриас хөрсний ус шавхан зайлуулах 22 иргэн, ААНБ-ын ус ашиглуулах дүгнэлтээр нийт 11,2 сая м³ жил ус байна.

ЗГ-аас 2013, ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолоор ус ашиглах төлбөрийн хэмжээг тогтоосон байдаг. Энийг 8 жилийн дараа буюу 2021 онд шинэчлэн баталсан. Ингэж батлахдаа бид ашигт малтмал олборлох, зэсийн баяжмал, хайлуур, жонш баяжуулах, архи, пиво, согтууруулах ундаа үйлдвэрлэхэд гадаргын усанд энэ хувь хэмжээ 10 байсныг нь 25, газрын доорх усанд 20 байсныг нь 35 буюу 15 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөх хувь хэмжээг мөн шинэчлэн тогтоосон байгаа. Ингэж тогтоохдоо эрдэсжилт, хатуулгийг нь цэнгэгжүүлж, зөөлрүүлэн буюу сайжруулж ашиглаж байгаа тохиолдолд усны төлбөрийг газрын доорх болон гадаргын гэж ялгахгүйгээр 50 хувиар хөнгөлсөн. Мөн ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах зориулалтаар ашигласан гадаргын болон газрын доорх усыг аль алийг нь 100 хувиар чөлөөлсөн. Хамгийн сүүлд нь бид энэ гадаргын усыг буюу цас, бороо, үерийн усыг хуримтлуулж мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан тохиолдолд 100 хувь чөлөөлөхөөр энэ тогтоол боловсруулж оруулсан. Энийгээ хэрэгжүүлээд ажиллаж байна. Монгол орны ус ашиглалтын тал хувийг эзэлдэг хөдөө аж ахуйн салбар, 10 орчин хувийн эзэлдэг хүн амын унд ахуйн усны хэрэглээ түрүүн дурдсаны дагуу 2025 оны 1 дүгээр улиралд багтаж гараад, танилцуулагдах учраас та бүхэнд эргэж мэдээлье.

Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 2021 онд 48,1 тэрбум, 22 онд 50,9 тэрбум, 23 онд 85 тэрбум, 24 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн бидэнд байгаа мэдээллээр 74,3 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрсөн байгаа. Ингээд оны сүүлийн мэдээллүүд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 90 орчим тэрбумд хүрч нэмэгдэх болов уу гэсэн ийм урьдчилсан таамаг байна. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хүрээнд ус ашиглагчдад ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт, ус ашиглуулах дүгнэлт, хаягдал усны дүгнэлтийг цахимаар аваад, хүсэлтийг хүлээж аваад, шуурхай шийдвэрлээд явж байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 2023 оны гүйцэтгэл бол 41,2 тэрбум төгрөг буюу журмын хэрэгжилт 62,6 хувьд хүрсэн. Энэ хэрээрээ буцаагаад усны нөөцийг хамгаалах, усны нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүжилт нэмэгдэж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Өсөн нэмэгдэж байгаа Өмнөговийн, өмнөд говийн бүсийн усны эрэлтийг бууруулж, ус хангамжийг нэмэгдүүлэхийн тулд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт усны хэмнэлттэй ашиглалт шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, усыг эргүүлэн ашиглах, хур тунадасны ус, уурхайн шүүрлийн ус болон

ахуйн цэвэршүүлсэн усыг дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ийм бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Цаашдаа энэ ус ашиглалтын хэмжээ болон хэрэглээ бол жил бүр өссөн дүнтэй байх ийм урьдчилсан прогноз гарч байгаа. 2030 он гэхэд усны хэрэглээ одоогийн түвшнээс 2,3 дахин, 2040 он гэхэд 3 дахин нэмэгдэх ийм тооцоолол байна. Ийм учраас бид ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэ усны чиглэлийн төслүүдийг эрчимжүүлэхэд онцгой анхаарч байгааг та бүхэнд танилцуулж байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Танилцуулгыг 10 минутдаа багтааж хийсэнд баярлалаа. Тодруулж асуух асуулттай гишүүд саналаа өгнө үү? Батлут гишүүнээр, Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ үйлдвэрийн ус ашиглалтын талаар ер нь хамгийн их ашиглаж байгаа нь хөдөө аж ахуйн чиглэлээр ашиглаж байна, дараа нь энэ уул уурхайн чиглэлээр. Тэгэхээр энэ зарим ус бохирдож байна гээд ярьж байна. Усны хамгаалалтын асуудал үндэсний аюулгүй байдалтай холбоотой. Ер нь хамгаалалтад байх ёстой. Гэтэл энэ сүүлийн үед хамгаалалтын албыг нь хассан сураг байх юм. Тийм үнэн үү, худлаа юу? Нэг мэдээлэл.

2 дахь нь энэ сүүлийн энэ 2 жилд усны үнэ бараг 3, 4 дахин нэмэгдчихлээ. Ахуйн ус ч гэсэн цэвэр, бохиороор ашиглаж байгаа ус ч гэсэн маш ихээр нэмэгдсэн. Ард түмний бүхэмдлын нэг юу нь энэ болж байгаа юм. Энэтэй холбоотой усны үнийн тарифын тайлбарыг нэг хэлж өгөөч, хэр байх юм бэ? Жишээлбэл ундны усанд айл өрх ямар, албан байгууллагад хэдэн төгрөгөөр авдаг юм энэ талын асуудлыг асууя. Дараа нь тодруулъя.

С.Ганбаатар: Асуултад хариулъя. ТНБД хариулах юм байна, 5 номерын микрофоныг нээж өгье.

Ж.Баттулга: Бейсен гишүүний асуултад хариулъя. Усны хамгаалалтын бүсүүдийг бол Усны тухай хуульд заасны дагуу онцгой хамгаалалтын бүсийг 50 метрээр, энгийн хамгаалалтын бүсийг 200 метрээс доошгүйгээр тогтоож байгаа. Усны эрүүл ахуйн бүсийг 100 метр тогтоож байгаа. Тэгээд хамгааллын дэглэмийг аймаг, нийслэлийн байгаль орчны газрууд хэрэгжүүлээд явдаг. Тэгэхээр энэ хамгаалалтын дэглэм буурсан юм уу, буулгасан, татан буулгасан тухай ямар нэгэн шийдвэр байхгүй гэдгийг гишүүнд хэлье.

Усны төлбөртэй холбоотой асуудлуудыг энэ усны төлбөрийг ЗГ-ын тогтоолоор баталж байгаа. Хамгийн сүүлийнхийг 2022 онд тогтоосон. Манай салбарт салбарын мэргэжлийн байгууллагуудын болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 20 50-д усны үнэ цэнийг нэмэгдүүлж, усны төлбөрийг шатлан нэмэгдүүлэх гэсэн ийм бодлогыг хэрэгжүүлдэг. Бидний зүгээс жишээлбэл ус бохирдуулсны төлбөр килограммаар тооцдог, 1кг ус бохирдуулсны төлбөр 50 төгрөг байгаа. Тэгэхээр энэ 50 төгрөг байгааг бид бага хэмжээтэй байна гэж үзэж байгаа. Яагаад гэхээр энэ ус бохирдуулсны төлбөр 1кг тутамд 50 төгрөг байна гэдэг маань бохирдуулагч ААН-үүд өөрсдөө усны шинэ технологи нэвтрүүлэх, энэ хаягдал ус цэвэрлэх байгууламжтай болох гэх мэтчилэн энэ дэвшилтэт ажлууд дээр ерөөсөө анхаарал тавихгүй, бохирдуулсан төлбөрөө төлөөд явдаг энэ бас муу зуршлыг бий болгож байна. Тийм учраас энэ усыг

хэмнэдэг, гамнадаг, дахин ашигладаг байхын тулд энэ төлбөрийг шатлан өсгөх ёстой гэж үзэж байгаа.

Ус ашиглагч, ус хэрэглэгч гэж 2 янз байгаа Усны тухай хуулийн дагуу. Тэгэхээр хэрэглэгч бол бүх төрлийн усны төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа. Бид зөвхөн ус ашиглагчид л төлбөр тавьж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх. Батбаяр дарга нэмнэ саналтай.

С.Ганбаатар: Батбаяр дарга нэмж 6 дугаар микрофоныг нээж өгье.

3.Батбаяр: Эрхэм гишүүний асуултад хариулахад Монгол Улсад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу 4 янзын усны төлбөр байгаа. Тэгэхээр гишүүн сая 2-оос 3 дахин нэмэгдсэн гэдэг үг дээр энэ 4-ийн аль нь вэ гэдгээ бодох ёстой. 4 гэдэг маань ус ашигласны төлбөр буюу Байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу ус ашигласны төлбөр ноогдож байгаа. Ус бохирдуулсны төлбөрийн тухай 2012 оны Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу ус бохирдуулсны төлбөр манай Усны газар дээр хаяг хаягдал усны дүгнэлтээр гарч байгаа. 3 дахь нь одоогийн байдлаар хэрэгжиж эхлээгүй байгаа 12 оны хуульд Усны тухай хуульд орчихсон байж байгаа ус хомсдуулсны төлбөр. 4 дэх нь Хот суурины усан хангамж, ариутгах татуурга, ашиглалтын тухай хуулийн дагуу явж байгаа Усны үйлчилгээний зохицуулах зөвлөлөөс тогтоодог үйлчилгээний төлбөр гэж. Тэгэхээр гишүүний асууж байгаа зүйл дээр энэ саяын хэлдэг дээр үйлчилгээний төлбөр ярих шиг боллоо. Сая ТНБД-ын хэлсэн ёсоор ус ашигласны төлбөр болоод ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг 20 50-д бодлогын хөтөлбөртөө заасны дагуу шатлан нэмэгдүүлэх, ашиглагч нь төлдөг.../минут дуусав/

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Миний асуух асуулт Байгаль орчны сайд баймаар байх юм. Байгаль орчны сайд яагаад 2 Байнгын хороо хамтарч хуралдаж байгаа хуралд байдаггүй билээ? Байнгын хорооны даргаа, 2 даргаа? ЗГ энэ хамтарсан ЗГ байгуулагдахдаа 14 мега төслийн хамгийн гоё ард түмэнд таалагдсан төсөл нь энэ говийн гадаргын ус татах төсөл шүү дээ. Хэрлэн говь, Хэрлэнтооно, Орхон-Онги төслийг хэрэгжүүлнэ гээд говийн гишүүд бүгдээрээ баярлаад л, говийн ард түмэн баярлаад л, 20 хэдэн жил дуншсан усны төслийг одоо хэрэгжүүлнэ гээд л гарсан. Одоо хүртэл бодитой мэдээлэл байхгүй. Би өнөөдөр бодитой мэдээлэл асуух гэсэн юм. Энд Төрийн нарийн байна, Усны газрын дарга байна. Тэгэхдээ энэ асуултад баталгаатай хариулж чадах уу? Хэрлэнтооно төсөл явах уу, одоо яг ямар шатдаа яваа юм бэ? Орхон-Онги төсөл явах уу, яг ямар шатдаа яваа юм бэ? ЗГ дээр Эдийн засгийн хөгжлийн сайд Л.Гантөмөрөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан гэсэн. Та бүхэн орсон байх. Хэрвээ орсон бол энэ ажлын хэсэг яг юу хийж байгаа юм бэ?

Би сая тойргоор яваад ирсэн. Говийн ард түмэн усаа нэхэж байна. Тэгэхээр одоо яг худлаа PR-даад байхгүйгээр, яг энэ усны төсөл явж байгаа юм уу, явахгүй байгаа юм уу? Яг гэрээ хэлэлцээр ямар шатандаа байгаа юм бэ? ЗГ хамтарч байгуулагдсанаас хойш юу хийсэн бэ яг энэ 2 төсөл дээр? Байхгүй бол би Эрүүл мэндийн сайдыг орж ирэхийг биш ээ, Байгаль орчны сайдыг орж ирэхийг шаардаж байна. Хэрвээ хариулж чадахгүй бол.

С.Ганбаатар: Асуултад хариулъя. Гишүүд маш чухал шаардлага тавьж байгаа юм шүү. Яг энэ янзаараа Байнгын хорооны дарга нар ЗГ-ын сайд нарт бид хариуцлага тооцохоос өөр аргагүй байдалд бид орж байгаа шүү. Яагаад гэвэл биднийг гэхээсээ илүү энэ ард түмнийг, сонгогчдыг үл хүндэлж байна гэсэн үг. Ингээд та нар маш тодорхой хариулт өгнө шүү. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. 5 номерын микрофоныг нээж өгье.

Ж.Баттулга: Байнгын хорооны гишүүдээс уучлал хүсье. Одонтуяа сайд энэ Байнгын хорооны хуралд онцгой ач холбогдол өгч байгаа. Биднийг сайн бэлдэж оролцоорой гэдэг ийм үүрэг даалгавар өгсөн. Өөрөө Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлыг ахалж байгааб Тэр утгаараа яг одоо зэрэгцээд энэ Агаарын чанарын стандарт шинэчлэх ажлын хэсгийг хуралдуулж байгаа. Ингээд дундаас нь дуусгаад ороод ирэх байх гэж бодож байна.

Мөнхбаясгалан гишүүний асуусан асуулттай холбогдуулаад мэдээлэл өгье. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, тэр дундаа ЗГ-аас хэрэгжүүлэх 14 мега төслийн дунд Хэрлэнтооно, Орхон-Онги 2 төсөл хоёулаа орсон байгаа. Хэрлэнтооно төслийн хувьд Оюу толгойгоос санхүүжилттэйгээр 10 тэрбум орчим төгрөгийн санхүүжилттэйгээр Эрдэнэс Оюу толгой компани хариуцаад, тендер шалгаруулалтыг явуулсан. Зураг, төслийн ажил дээр гүйцэтгэгч шалгарчихсан явж байгаа, гэрээ хийгдчихсэн энэ ажил явж байгаа.

Та бас сая хэллээ. Энэ ЗГ дээр энэ 14 мега төслийг эрчимжүүлэх ажлын хэсгийг Тэргүүн шадар сайдаар ахлуулаад ажиллуулж байгаа. Тэр дундаа энэ усны төслүүдийг хэрэгжүүлэх төслийг бол нарийн бичгийн дарга нь Усны газрын даргаар томилгоожуулаад ажил нь явж байна. Энэ хугацаанд бидний Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төвлөрч байгаа гол ажлууд бол энэ. Энэ 2 төсөл хоёулаа хилийн устай холбоотой төслүүд. Тийм учраас энэ ОХУ-тай, БНХАУ-тай хилийн усны талаарх ажлын хэсгийн хурлуудаа энэ хугацаанд зохион байгуулсан. Аль, аль талд нь мэдэгдээд, ахиц дэвшлүүд гарч байгаа. Ялангуяа энэ ОХУ-д Байгаль орчин, уур амьсгалын сайд өөрөө айлчилсан. Оросын холбооны улсын Байгалийн нөөцийн сайд мөн өөрөө Монгол Улсад айлчилсан.

Энэ үеэр яригдаж байгаа гол асуудал энэ усны төслүүдийг урагшлуулах явдал байгаа. Энэ дээр хүрсэн нэг зөвшилцлийн, том ойлголцлын нэг алхам бол 2 улсын өнгөрсөн хугацаанд хийгдсэн байгаль орчны нөлөөллийн, бүс нутгийн экологийн нөлөөллийн энэ үнэлгээний тайлангуудыг бүгдийг нь нэгтгээд, 2 талаасаа 7, 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулаад явж байгаа. Энэ ажлын хэсэг мэргэжлийн түвшинд бүрдсэн ажлын хэсгийнхэн хоорондоо тоо баримтаа нэгтгээд, тооцоо судалгаагаа эцэслэсний үндсэн дээр энэ нэгдсэн шийдлийг гаргая гэдэг ойлголцолд хүрсэн. Монголын талын ажлын хэсгийг судлаачдын ажлын хэсгийг Дэмбэрэл академич ахлаад явж байна. Батбаяр дарга нэмээд хэлэх үү.

С.Ганбаатар: 6 дугаар номерын микрофоныг нээж өгье. Усны газрын дарга Батбаяр.

З.Батбаяр: Эрхэм гишүүний асуултад нэмж хариулахад хилийн усны хэлэлцээрүүд дээр бид 10 сард яг 2 долоо хоног дараалаад Хятадын талтай, Оросын талтай хилийн усны хэлэлцээр маань бүрэн эрхт, тэгээд дараа нь ажлын хэсэг гэж ийм 2 үе шаттай эхлээд ажлын хэсгийн хуралдаан болоод дараа нь бүрэн

эрхтийн хуралдаан болох ёстой. Ажлын хэсгийн хуралдаанууд дээр хэлсэн нэлээн олон асуудлууд яригдсан. Эрхэм гишүүнд бичгээр болоод нөгөө протоколыг үзүүлэхэд хүргүүлэхэд бэлэн байна, хүргүүлнэ. Эндээс мэдээж тодорхой асуудлууд яригдсан. Энэ ажлын хэсэг хуралдсаны дараа бүрэн эрхт төлөөлөгчдийн хуралдаан болох ёстой. Одоогийн төлөвлөж яг өнөөдрийн байдлаар ярьж байгаагаар Хятадын талтай энэ 1 сарын 20-оор энэ бүрэн эрхт төлөөлөгчдийн хуралдааныг хийх гэсэн ийм улс төрийн гэдэг юм уу ийм ажиллагаатай явж байна. Түрүүний юун дээр хэлдэг дээр 26 оны 1 сар гэхэд Хэрлэн Тооно төслийн ТЭЗҮ бүрэн.../минут дуусав/

С.Ганбаатар: Мөнхбаясгалан гишүүн тодруулж нэмж асууя.

Л.Мөнхбаясгалан: ЗГ байгуулагдсаны дараа усны өмнийн говийн усны ажлын хэсэг байгуулагдсан. Төрийн нарийн ахалж байгаа билүү, сайдын зөвлөх ахалж байгаа юу. Энэ ажлын хэсэг яг юу хийсэн бэ гэдгийг, хилийн усны хэлэлцээрүүд ямар шатад явагдаад, одоо дараагийнх нь хүлээгдэж байгаа ажил юу вэ гэдгийг надад Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу мэдээллийг 48 цагийн дотор хүргээч.

Дээрээс нь яг энэ Хэрлэнтооно, Орхон-Онги төсөл явах уу? Надаас ерөөсөө тийм л асуулт асууж байна говийнхон. Тэгэхгүй тэр Эрдэнэс Тавантолгойн баяжуулах үйлдвэр, дээрээс нь хармагтай орох юм бол загийн ус лав байхгүй боллоо. Бид тэндээс төлбөр аваад яах юм бэ усгүй болчихсон хойно. Тийм учраас яг энэ төсөл явах уу, явагдахгүй юу гэдгийг хариулж өгөөч. Хэрвээ хариулж чадахгүй гэвэл сайдыгаа дуудаж авчраад энд хариулт өгөөч.

С.Ганбаатар: Гишүүний асуултад хариулъя. Сайдыгаа 1 дүгээрт дууд. 2 дугаарт саяын асуултад нь маш тодорхой хариул даа.

Э.Баттулга: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлууд учраас яамнаас хэрэгжүүлнэ. Энэ төслүүд хэрэгжинэ гэдэг ийм мэдээллийг гишүүнд өгье. Таны тавьсан шаардлагын дагуу бид 48 цагийн дотор энэ холбогдох мэдээллүүдийг албан ёсоор хүргүүлье.

С.Ганбаатар: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Баярлалаа. Устай холбогдолтой асуудал нэлээн өргөн хүрээний асуудал энийг бас ярих, ярилцах шаардлагатай. Тэгэхдээ дэлхий нийтийн хувьд энэ чиглэлийн асуудал дээр нэлээн нухацтай хандаад тогтвортой, урт хугацааны сайн бодлогууд хэрэгжүүлээд ингээд явж байгаа. Манайхан үндсэндээ цэвэр усаа бүх зүйлдээ ашигласаар, ингээд нөөцтэй холбогдолтой асуудлууд нь ингээд яригддаг.

Нөгөө талдаа өнөөдрийн орчин үеийн 21 дүгээр зуунд амьдарч байгаа зарим сумд маань бас ундны усаараа бүрэн дүүрэн хангагдаж чадахгүй байгаа ийм нөхцөл байдалтай ингээд тэнгэр, газар шиг ийм нөхцөл байдлууд байгаа. Сая бид бүхэн усны ажлын хэсгийн хүрээнд Мянганы сорилтын сангийн хэрэгжүүлж байгаа төслүүдтэй очиж танилцсан. Үүнтэй холбогдолтой тодорхой бид хэдэн асуултыг та бүхнээс асууя. Миний гол асуудал энэ хаягдал усыг дахин боловсруулахтай холбогдолтой энэ чиглэл рүү би асуултаа асууя. Үүний хүрээнд хамгийн нэн тэргүүнд энэ Төв цэвэрлэх байгууламжийн 19 хувийг бүрдүүлээд байгаа энэ

үйлдвэрлэлийн энэ бас бохир усыг заавал ч үгүй урьдчилсан цэвэрлэх байгууламжийг тухайн үйлдвэрүүд маань байгуулж байж энд очиж байгаа энэ бохирдлын хэмжээг бууруулах шаардлагууд тулгараад байгаа. Үүнтэй холбогдолтойгоор өнөөдөр Хөдөө аж ахуйн байнгын хороо, байгаль орчны байнгын юу Аж үйлдвэржилтийн байнгын хороо хамтран хэлэлцүүлэг хийж байгаатай холбогдолтойгоор ААН-үүд урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгуулсан тохиолдолд бид төрөөс ямар дэмжлэгүүдийг үзүүлэх вэ гэдэг зүйлүүдийг нэлээн тодорхой болгох хэрэгтэй байгаа юм.

Нөгөө талаасаа бид нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүрээнд ААН-үүдээ ингээд шахаад байдаг. Гэхдээ цэвэрлэх байгууламж байгуулсан ч адилхан, байгуулаагүй ч адилхан ийм байгаа энэ цаг үед өндөр өртөгтэй ийм байгууламжуудыг хөрөнгө оруулалтуудыг татаж хийнэ гэдэг ААН-үүд маань нэлээн хүндрэлтэй байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр бид тодорхой байр сууриудыг гаргах хэрэгтэй. Өнөөдрийн танилцуулгатай холбогдолтойгоор энэ чиглэлийн тодорхой төрийн дэмжлэг зүйлүүд ямар байна ийм мэдээллүүд та бүхэнд байна уу гэдэг эхний асуулт байгаа юм.

2-т нь усыг дахин ашиглахтай холбогдолтой асуудал олон зүйлээрээ ач холбогдолтой байгаа. Ингээд дэлгэрүүлээд яах вэ ярих зүйлүүд байна. Гэхдээ энэ дахин боловсруулсан усыг ашиглахтай холбогдолтой хууль, эрх зүйн орчин дутагдалтай байгаа юм билээ. Үүнтэй холбогдолтой хуулийн төслийг боловсруулж байна уу, хэзээ үндсэндээ оруулж ирэх вэ? Дахин боловсруулсан ус ашиглах үнэ тарифын хувьд ялгаатай ийм зүйлүүд байна уу? Энийг яаж шийдэх вэ? Хэрвээ хуулийн төсөл нь болоогүй, батлагдах нь тодорхойгүй байгаа бол техникийн зохицуулалтаар шийдэх ямар боломжууд байна вэ? Үүнтэй холбогдолтой ямар журмууд мөрдөгдөж байна вэ гэдэг асуултыг асууя.

С.Ганбаатар: 5 номерт хариулт өгье.

Э.Баттулга: Гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуудлуудыг хөндөж хөндлөө. Баярлалаа. Бид энэ урьдчилан цэвэрлэх байгууламж барих ААН-үүдийг захиргааны аргаар болон санхүүгийн дэмжлэгээр энэ урьдчилан цэвэрлэх байгууламжтай болох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэж харж байгаа. Эхнийх нь түрүүн дурдсан тэр ус бохирдуулсны төлбөрийг үе шаттай нэмэгдүүлэх замаар усны төлбөрөө төлөөд явдаг биш, өөрсдөө цэвэрлэдэг тэрнээсээ эдийн засгийн өгөөж хүртдэг байдал руу нь чиглүүлнэ.

Хоёрдугаарх нь энэ юу байгаа Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд заасны дагуу өөрийн хөрөнгөөр урьдчилан цэвэрлэх байгууламж барьсан тохиолдолд 3 жил ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлж байгаа. Тийм, ийм хөнгөлөлтийн механизм хуульд суусан байгаа. Ус дахин боловсруулахтай холбоотой дахин хаягдал ус дахин ашиглахтай холбоотой асуудлыг хөндлөө. Монгол Улс 2021-ээс 26 онд хэрэгжиж байгаа энэ Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд хаягдал ус дахин боловсруулах маш том дэвшилд хүрч байгаа. Энэ шинэ төв цэвэрлэх байгууламжийн дэргэд ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад ороод, тэгээд Төв цэвэрлэх байгууламжаас байгальд нийлүүлж байгаа цэвэрлэсэн уснаас авч дахин боловсруулаад дулааны 3, 4 дүгээр цахилгаан станцын усны хэрэглээг бүрэн хангахаар байгаа юм.

Энэтэй холбогдуулаад яаж байна вэ гэхээр бид Монгол Улсын Засгийн газар 3 чиглэлийн үүрэг хүлээсэн. Манай яам 3 чиглэлийн үүрэг хүлээсэн. Эхнийх нь энэ төвлөрсөн хаягдал ус нийлүүлж байгаа төвлөрсөн шугамд нийлүүлж байгаа хаягдал усны стандартыг шинэчлэх ийм шаардлагыг тавьсан. Энэ стандартыг бид олон улсын жишигт нийцүүлээд өнгөрсөн оны 11 сард шинэчилж батлуулсан байгаа.

2 дугаарт энэ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах ийм шаардлагыг санхүүжүүлэгч буюу Мянганы зорилтын сангаас тавьж байсан. Тэгэхээр бид Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд 2024 оны 6 сард оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2 янзын асуудлыг тусгасан. Эхнийх нь энэ ус бохирдуулсны төлбөрийн орлогын 50 хувийг Төв цэвэрлэх байгууламжийн сэргээн засах, техник технологийн шинэчлэлийн ажилд зарцуулна гэдэг ийм хуулийн заалт орсон. Нөгөөдөх нь усны эх, үлдсэн 50 хувийг нь усны эх үүсвэрийг бүрдүүлэхэд зарцуулна гээд тов тодорхой заагаад өгчихсөн байгаа.

3 дугаарт Төв цэвэрлэх байгууламжийн гаргалгаа дээрээс эхлээд шувуунаас эхлээд Төв аймгийн Алтанбулаг сум хүртэлх Туул голын ёроолын хурдсыг цэвэрлэх ийм 3 үүргийг хүлээсэн байгаа. Энэ жилдээ туршилтын ажлыг явуулсан, ирэх жилээс энэ ажлыг бүрэн явуулна гээд. Манай талаас хүлээсэн энэ 3 үүргээ биелүүлчихсэн байгаа. Түрүүний хэлсэн яг энэ хаягдал устай холбоотой.../минут дуусав/

С.Ганбаатар: Нэмж тодруулж хариулъя 5 номерын микрофон, 6 номер дээр хариулах гэж байна уу, хаана юм бэ, 5 дээр үү? 5 номерын микрофонд дэлгэрүүлж хариулъя.

Э.Баттулга: Энэ хаягдал ус дахин боловсруулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг бид өөрсдийнхөө яамны төлөвлөгөөнд тусгагдсан. Тэгэхдээ хуулиараа энэ Барилга, орон сууцжуулалтын яам болон Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашигт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүрэн эрхэд хамаардаг. Зохицуулах зөвлөл рүү энэ талаар хамтарч энэ асуудлуудыг хийе, техникийн зохицуулалт, стандартуудаа шинэчилье гэдэг хүсэлтийг явуулчихсан байгаа. Энэ ондоо хэрэгжих ажлууд юм гэж хариулт өгье. Баярлалаа.

С.Ганбаатар: Ганхүлэг гишүүн тодруулж асуулт асууна.

М.Ганхүлэг: ААН-үүдтэйгээ та хэд маань уулзаж ярилцаж байна уу? Ялангуяа хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрүүд дийлэнх нь байгаа. Нийт төв цэвэрлэхийн 19 хувийг бүрдүүлээд байгаа. Тэгээд маш их өндөр бохирдолтой байгаа учраас дахин боловсруулах, дараа нь ашиглах төв цэвэрлэхийн ачааллыг нэмэгдүүлэх гээд ингээд олон талын сөрөг үр дүн гараад байгаа юм. Тэгэхээр энэ ААН-үүд дээр яах вэ 3 жилийн татвараас чөлөөлөх гээд одоо байгаа арга хэмжээнүүд нь би дутуу байна гэж үзээд байгаа юм. Энэ байгаа боломжоороо бид бүхэн нэлээн олон жил алдаж байна. Яг ААН-үүд маань урьдчилан цэвэрлэх байгууламжаа барихад хүндрэлтэй байгаа. Тэгэхээр өөр нэмэгдүүлэх арга хэмжээ авахгүйгээр одоо ингээд байгаа нь ингээд болж байна гээд ингээд үзэж байна уу, яаж сайжруулах вэ гэдэг талаас нь би асуугаад байгаа юм. Үнэ тарифтай холбогдолтой асуулт асуусан. Түүн дээр ялгавартай үнэ байна уу? Үүнийг яаж сайжруулах вэ?

С.Ганбаатар: 6 номерт Батбаяр дарга хариулъя. Ганхуяг гишүүний асуултад.

3.Батбаяр: Эрхэм гишүүний асуултад ус 2 янзын төлбөр төлж байгаа. Түрүүн хэлснээр ус ашигласны болоод ус бохирдуулсны. Ус бохирдуулсны төлбөр маань 2 хүчин зүйлээс шалтгаалж байгаа. Нэгдүгээрх нь бохирдуулаад гаргаад байгальд юм уу эсвэл шугамд нийлүүлж байгаа усны хэмжээ. 2 дахь буюу хамгийн чухал нь тэр усны найрлагаас нь хамаарч байгаа, тэгээд стандарттайгаа зэрэгцүүлээд явж байгаа. Хэрвээ ААНБ маань өөрөө ямар нэгэн байдлаар усыг урьдчилан цэвэрлэхгүй бол улам л их хэмжээний төлбөр төлөөд байна гэсэн үг. Хэрвээ урьдчилан цэвэрлэх байгууламж бариад, усаа цэвэршүүлчих юм бол 1 дүгээрт ус бохирдуулсны төлбөрийнх нь хэмжээ нь багасна. 2 дугаарт нэгэнт цэвэршүүлээд юм уу, үгүйдээ цэвэршүүлээд гаргачихсан усаа стандартын шаардлага хангасан усаа тэгж хаяж ус нөгөө бохир усны төлбөр төлөхийн оронд өөрөө дахиад ашиглачих юм. Тэгвэл өөрийнх нь ус ашигласны төлбөрийнх нь хэмжээ нь буураад явчихна.

Өөрөөр хэлбэл манай энэ ус ашигласны төлбөр болоод ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ нь хэдий чинээ.../минут дуусав/

С.Ганбаатар: Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Энийгээ яах вэ сайжруулах санал дээрээ дахиад хэдүүлээ ярилцах боломж олдвол сайн байна, илүү л дэмжиж, богино хугацаанд л энэ үйлдвэрүүдийг барих нь зөв гэж бодоод байгаа юм.

Энэ 2, миний асуугаад байгаа үнэ болохоор энгийн ус худалдаж авах үнэ гэдэг нэг үнэ байна шүү дээ, дахин боловсруулаад буюу түүн дээр чинь нэлээн ажиллагаа ороод, тодорхой хэмжээнд тэр усыг боловсруулсны дараа тэр ДЦС-ууд байх юм уу, өөр тэр газрууд нь авахад ялгавартай үнэ гэж байна уу? Тэр нь ямар байдлаар гарах вэ? Энэ чиглэлийн зохицуулалт бусад орнуудад байна. Энийгээ бид гаргаж ирж байж нөгөө энэ салбар луу хүмүүс орж ашиг олох энэ боломжууд нь үүсэх гээд байна л даа.

С.Ганбаатар: 5 номерт ТНБД хариулъя.

Э.Баттулга: Ганхүлэг гишүүний дэвшүүлж байгаа санааг бид дахиад дотроо ярья. Энэ ажил хэрэг болгох талд нь анхааръя. Ер нь одоо хаягдал усыг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр нь усны төлбөрөөс чөлөөлж байгаа. Энэ бол маш том хөнгөлөлтийн зохицуулалт гэж бид харж байгаа.

2 дугаарт нь энэ хаягдал усыг цэвэрлээд, эргүүлээд үйлдвэр, үйлчилгээнд ашигласан бол дахин ашигласан хэмжээгээр нь дахиад усны төлбөрөөс чөлөөлчхөж байгаа. Ер нь яг энэ цэвэрлэсэн усыг ашиглах, тэгээд цэвэрлэх байгууламжтай болох гэсэн энэ шат шатанд нь татвар, санхүүгийн дэмжлэг үзүүлэх хуулийн зохицуулалт явж байгаа. Тийм, энэ болохоор Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар орж байгаа зохицуулалт байгаа.

С.Ганбаатар: Ганхүлэг гишүүний асуултад хариуллаа. Маш ажил хэрэгч чухал асуулт асуулаа. Батлут гишүүн хурал давхардаад явчихсан байгаа шүү, алгасаад Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Ус бол ашигт малтмалаас хамаагүй үнэ цэнтэй. Тэгээд далай тэнгисээс алслагдмал Монгол орны хувьд энэ их том асуудал. Яах вэ ганцхан хүн ам 3,5 сая цөөн тулдаа л байгаа юм. Тэгээд энэ ингээд тооцоолол харахаар Монгол Улсын 1 иргэн сард 2 тонн ус хэрэглэдэг л гэдэг ийм тооцоо та бүхний танилцуулгаас гарч байна. Тэгээд би юу хэлэх гээд байна гэхээр ингээд ялангуяа гүний усыг ашиглах боломжит нөөц гэдгийг ТНБД-ын ахалсан байна уу даа энэ зөвлөл тогтоож байгаа. Тэгээд гүний ус гэж юу вэ гэж. Энэ бол байгалийн аясаар нөхөн сэргээгдэх явц олон зуун сая жил. Энэ бүрэлдсэн усыг ямар хэмжээгээр тухайн сав газраас ашиглавал эргэж нөхөн сэргээж чадах вэ гэдгийг энэ шинжлэх ухааны нарийн тооцож ус ашиглах зөвшөөрөл өгч байгаа. Тэгээд энэ ус ашиглах зөвшөөрөл яг хуулийн дагуу, энэ шинжлэх ухааны дагуу явж байна уу, үгүй юу гэдэгт маш эргэлзээтэй асуудал байгаа. Би энд их сэтгэл зовниж явдаг юм.

Яагаад гэхээр би баримтгүй ярихгүй л дээ. Жишээлбэл Тамсагийн сав газарт нефть олборлож байгаа. Энэ олборлоход боломжит усны нөөцийг танай яам тогтоохдоо 150, 200 метр орчмоос тогтоодог байсан бол сүүлдээ энэ нь байхгүй болоод ингээд 4, 500 метрээс тогтоож байгаа шүү дээ. Тэгэхээр юу хэлэх гээд байна вэ гэхээр цаашдаа энэ хуулийг шинэчлэх хэрэгтэй байгаа Усны тухай хуулийг. 1 дүгээрт хуулиа шинэчилнэ. 2-т энэ гүний гадаргын ус бохирдохоос сэргийлэх ажлыг чинь бусад оронд тухайн нэгжийн Засаг дарга хариуцдаг байхгүй юу. Одоо манайд бол ингээд Усны сав газрын захиргаа энэ тэр гээд байгаа юм. Өндөр албан тушаалтай хүнд хариуцуулж, бохирдох юм бол өндөр хариуцлага тооцдог ийм тогтолцоонд шилжээд удаж байна. Бид энийг хэзээ хийх вэ?

Дараагийнх нь тариф нэмэгдүүлэх шаардлагатай. Яагаад гэхээр би бас л жишээ дээр ярья. Газрын тос олборлолтод Тамсагийн сав газраас 19, 24 дүгээр талбайгаас энэ жилийн дүнгээр 2 сая тонн ус ашигласан байна. Тэгвэл 500 мянган тонн нефть олборлосон. Ингэхээр 1 тонн нефтийг олборлоход 4 тонн ус ашиглаж байгаа байхгүй юу. Гэтэл усны үнэ маань өөрөө гэр хороолол, орон сууцын иргэд 2000 гаруй төгрөг байгаа. Тэгэхэд энэнээс хямд үнээр буюу 1 литр нэг литр гүний усаар нефть олборлоход 2 мянган төгрөг, 2072 төгрөгийн л тарифтай байгаа байхгүй юу. Тэгэхээр өөрөөр хэлбэл хүн амын ундандаа хэрэглэж байгаа уснаас үйлдвэрлэлд хэрэглэж байгаа усны үнэ чинь бага байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ тарифыг хэзээ нэмэх юм бэ? Юу гэж хэлэх гээд байна гэхээр 1 литр нефть 2 мянган төгрөг гээд бодоход энэнээс ус чинь 1 литр ус чинь мянга дахин бага үнэтэй өнөөдөр тариф тогтоочоод байгаа байхгүй юу. Тэгээд би энд их сэтгэл зовниод байгаа. Энийг бол эрс нэмэгдүүлэх шаардлагатай. Тэгээд гүний усны түвшин бол эрс доошилж байгаа.

С.Ганбаатар: Хариулт хэн хариулт өгөх вэ Бадамсүрэн гишүүний асуултад? ТНБД 5 дугаар микрофоныг нээж өгье.

Э.Баттулга: Бадамсүрэн гишүүний тавьж байгаа асуудлуудтай бид санал нэг байгаа. Тийм ер нь энэ тарифыг нэмэх ёстой. Нэмэхдээ бид яах вэ саяын гишүүний хэлж байгаа шиг шууд огцом нэмэхгүй байх. Бидний баримталж байгаа нөгөө Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод усны төлбөр, тарифыг шатлан нэмэгдүүлэх асуудлыг тусгаж өгсөн байдаг. Тэрний дагуу яг эрэлттэй хэсгүүд дээр нь шатлаад нэмэх ажлыг оруулъя. Хамгийн сүүлд ЗГ-аас 2022 онд нэмсэн, 22 оны тариф хэрэгжээд явж байгаа.

С.Ганбаатар: 6 номерын микрофоныг нээж өгье. Батбаяр дарга.

З.Батбаяр: Гишүүнд их баярлалаа. Асуултад Петрочайна Дачин Тамсаг 19, 21 дүгээр талбайтай байж байгаа. Тэгэхээр би таны хэлсэн дээр нэмээд хэлэх гэж байгаа юм Петрочайна Дачин Тамсаг 19 дүгээр талбай дээр 2024 онд гүйцэтгэлээр 1 аравны, гүйцэтгэлээр 1,1 сая юугаар, 21 дүгээр талбай дээр 832 мянгыг гэсэн. Өөрөөр хэлбэл яг таны хэлсэн 2 саяыг ашиглаж байна гэсэн үг. Энэний төлөө төлж байгаа мөнгө нь яах вэ хамаагүй гэж бодоход би танд тооцоо хэлэхэд Мэнэнгийн талын сав газар дээр бид гурван мянга 1м^3 усны газрын доорх усны үнийг 3700-гаар тогтоосон байгаа. Тантай бүрэн дүүрэн санал нийлж байгаа маш их баярлалаа гэж хэлэхээр байгаа зүйл нь усны үнэлэмжийг нэмэгдүүлэх гэдэг асуудал байгаа. Тэгэхээр бид усны үнэлэмжийг нэмэгдүүлэх 3, 4 янзын арга замууд байгаа. Энийг бүгдийг нь ашиглах санаатай байгаа. Хамгийн нэгдүгээрх нь усны экологи, эдийн засгийн үнэлгээг нэмэгдүүлэх. 2 дугаарт нь хувь хэмжээг нэмэгдүүлэх, байгалийн нөөц ашигласны төлбөрийн.../минут дуусав/

С.Ганбаатар: Ойлголоо. Аубакир гишүүн асуулт асууна.

Т.Аубакир: Баярлалаа. Сайд байсан би яах вэ энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой нэг их айхтар биш. Гэхдээ одоо ингээд чуулган завсарлачхаж байгаа. Сайд нараас бид яг зарим асуултыг авч, хариулт авах боломж бага. Гэхдээ нэгэнт манай Байнгын хорооны харьяаны асуудал учраас энэ тусгай хамгаалалттай газрын талаар хариулах хүн бий юу та хэд дотор? Хариулчих юм байна. Энэ манай Баян-Өлгий аймаг дээр үүсээд байгаа нэг асуудал байгаад байгаа юм. Ногооннуур сумын газар нутгийн ихэнх хувь нь тусгай хамгаалалттай газарт орчихсон. Үүнтэй холбоотой зарим иргэдийн мал бүхий иргэдийн өвөлжөө, хаваржаа руугаа очих, зорчих тоолонд төлбөр мөнгө нэхдэг. Тэгээд төлбөр мөнгө төлөхгүй болохоор Зөрчлийн хуулиар арга хэмжээ авна гэдэг гэх зэрэг нэг ийм ахуйн чанартай асуудлууд үүсээд байгаа юм.

Тийм учраас бид Одонтуяа сайдтай энэний өмнө санал солилцсон. Энэ тусгай яг манай аймгийн хувьд энэ тусгай хамгаалалттай газар нутгийн хил хязгаар энэ цэсийг дахиж нэг анхаарч харахгүй бол Ногооннуур сум жишээлбэл 60 орчим хувь нь тусгай хамгаалалттай газар орчихсон гэж байгаа юм. Гэтэл тэр сумд чинь тэгвэл мал нь хаанаа байх юм, бусад уул уурхай нь хаанаа байх юм. Өөрөө хилийн бүс нутаг, хадлангийн талбай, Ачит нуур, Ховд голын эргээр байдаг хадлангийн талбай зарим нь тусгай хамгаалалттай газар орчихсон. Өвс хадлан хадахад явдалтай. Тийм учраас энэ яг газар дээрээ яг юу болоод байгаа юм бэ? Энд тал дээр яг авсан мэдээлэл бий юу?

Тухайн үед тогтоогоод өгчихсөн тусгай хамгаалалттай газрын хил хязгаар чинь үндсэндээ амьдралтайгаа нийцэхгүй болчихоод байна л даа. Яах вэ энэ бидний авсан мэдээллээр 20 оноос өмнө тухайн аймгийн удирдлагууд байсан хүний өгсөн саналаар бид цэсийг нь зурсан юм гэж. Одонтуяа сайдын өгч байгаа мэдээллээр бол удахгүй Тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд орж ирэх юм байна л лээ. Энэ дээрээ хэдүүлээ эргээд энэ хилийн цэсээ дахиж харахгүй бол нийтийн эзэмшлийн байдаг ч юм уу тийм уурхайтай, жишээлбэл маш олон уул уурхай ашиглачхаж болох уул уурхай маань тусгай хамгаалалттай газар орчихсон байж байгаа. Гэтэл манай улс чинь өөрөө уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн эдийн засагтай ийм орон. Тийм учраас яг

Ногооннуур сум дээр болоод байгаа асуудлаар ер нь мэдээлэл авсан уу? Яг ийм ахуйн чанартай зөрчлүүд яг гараад байгаа нь үнэн юм уу?

2 дугаарт та бүхэн маань яамны бүрэлдэхүүн маань Тусгай хамгаалалттай газрын тухай хууль орж ирэхэд энэ хилийн цэсийн асуудлыг дахиж асуудлыг дахиж харахгүй бол тухайн үедээ бөөнд авчраад л хилийн цэс зурчихсан. Тухайн үеийн аймгийн удирдлагууд өгсөн саналаар гэж байгаа юм. Аймаг, орон нутгийн удирдлагуудын саналаар гэхээсээ илүү тухайн орон нутагт амьдарч байгаа иргэдээс санал авах нь өөрөө хууль дээрээ байж байгаа. Тийм учраас энэ асуудлуудыг дахиж эргэж харахгүй бол яг өнөөдрийн байдлаар Ногооннуур суман дээр нэлээн хэл амтай зүйл болчихсон байж байгаа. Тэр Ховд гол, Ачит нуур, Дэвэлийн арлын тусгай хамгаалалттай газрын захиргааг Ногооннуур сум дээр нь байгуулаад өгөөч гээд байхад л Бөхмөрөн сум дээр авааччихсан. Үүнтэй ч бас холбоотой ийм маргаанууд бий болчихсон.

С.Ганбаатар: Их тодорхой хариулъя, 5 номерын микрофон ТНБД.

Э.Баттулга: Аубакир гишүүний асуултад би тодорхой хариулъя. ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалыг нь батлуулаад, удахгүй өргөн барихаар байгаа. Энэ дээр яг энэ тусгай хамгаалалттай газар нутгуудын хилийн цэсийн асуудал яригдаж байгаа. Орон нутгийн иргэдийн амьжиргаатай холбоотой, түүнтэй нь холбогдуулаад ер нь олон улсын жишгийн дагуу бид байгалийн нөөцийн ашиглалтыг тодорхой хэмжээнд зөвшөөрөхүйц ийм 5 дахь ангиллын оруулж ирье гэсэн ийм асуудал ярьж байгаа юм. Одоогоор 4 байгаа шүү дээ. Дархан цаазат газар, цогцолборт, дурсгалт болон байгалийн нөөц газар гээд. Тэгээд дотоод бүсчлэлтэй, дотоод бүсчлэлд нь нөгөө энэ, энэ үйл ажиллагааг зөвшөөрдөг, энэ энийг хязгаарлагдмал байдлаар зөвшөөрнө гээд энэ зохицуулалтуудыг нь боловсронгуй болгож өгөх юм бол одоо энэ иргэд болон хамгаалалтын захиргааны хооронд гардаг зөрчил арилах юм гэж харж байна.

Гишүүн энэ Ачит нуур, Дэвэлийн арал бол энэ тусгай хамгаалалттай газарт явагдаж байгаа энэ иргэд, хамгаалалтын захиргааны хоорондох энэ хадлан хадаж байгаа асуудалтай холбоотой асуудлыг хөндөж байх шиг байна. Манай энэ хамгаалалтын захиргаа бол Увс аймгийн Ховд, Бөхмөрөн сумд, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Ногооннуур сумуудыг хамарсан 4 сумыг хамарсан хамгаалалтын захиргаа байдаг. Сүүлийн үед энэ Ногооннуур сумын иргэдээс өвс хадаж байгаа мөн зэгс хадаж байгаа гэдэг асуудал ярьж байгаа. Энэтэй нь холбогдуулаад яах вэ хадаж болно, зэгс бол хадлуулахгүй, өвс хадаж болно. Гэхдээ энийг тусгай хамгаалалттай газарт хадлан хадахад журмын дагуу орон нутагтай гэрээ байгуулах ёстой. Ийм гэрээ байхгүй. Дээр нь орон нутгийн иргэд биш, ахуйн хэрэглээнд биш, машинаар зөөгөөд ингээд худалдаа арилжаа хийх зорилгоор, ашиг олох зорилгоор ченжүүд ажиллаад байна гэдэг мэдээллийг манай хамгаалалтын захиргаа өгч байгаа. Тэгээд 18 иргэний цахилгаан хадуурыг нь хурааж аваад, автомашин хэрэгсэлд нь торгууль тавиад, 650 мянган төгрөгийн торгууль тавьчихсан явж байгаа. Ер нь цаашдаа энийг саяын хэлдэг хуулийн зохицуулалтаар хийх ёстой.

2 дугаарт энэ зудын эрсдэлийн зургаар энэ юу гарах ёстой л доо. Өвөлжилт хүндэрсэн нөхцөлд энэ гэрээ байгуулаад оруулах боломж байгаа. Тэгтэл өвөлжилт хүндэрсэн нөхцөл байдал тогтоогдож өгөхгүй нэг ийм явдалтай асуудал бий. Тийм. Тэгэхээр энийг бид одоогийн мөрдөгдөж байгаа хууль журмын дагуу бол торгохоос

аргагүй. Зэгс хадаж болохгүй. Яагаад гэхээр зэгс хаврын улиралд нүүдлийн шувуу ирэхэд бүгэх боломж, өсөж төлжих, үр төл өндөглөх энэ бүгэх нөхцөлийг бүрдүүлдэг учраас энийг бол хамгаалалтын захиргаа хамгийн түрүүнд хамгаалаад явж байгаа.

С.Ганбаатар: Асуултад хариуллаа. Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Үг хэлэх гишүүд байна уу? Саналаа өгье, нэрсээ өгье. Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн асуулт, үг хэлнэ.

Б.Бейсен: Ус ашиглалтын асуудал дээр энэ ундны ус дээр ч гэсэн гадаад энэ Хятад, Оросоос их хэмжээний ус орж ирж байгаа. Дотооддоо энэ усаа үйлдвэрлэлийн асуудал дээр яавал гадагшаа урсаж байгаа валютын урсгал маань дотооддоо орж ирэх боломжтой. Тэгэхээр энэ дээр бас анхаарч ажиллах шаардлагатай.

Нөгөө талаар усны тарифын асуудал дээр зарим аймгууд чинь дур мэдэн юугаа нэмчихдэг. Тэгэхээр энд нэг хуульд нь өөрчлөлт оруулдаг юм уу улсын хэмжээнд жигд юутай болгоод тусгахгүй бол заримдаа болохгүй байгаа асуудлууд байгаа. Саяын ТХГН дээр бэлчээр, хадлан усжуулалтын асуудал байж байгаа л даа. Саяын тэр Ногооннуур сумын асуудал дээр би өнгөрсөн 4 жилд энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүний хувьд шалгалтаар бид очсон. Газрын кадастрын зургийг та нар хараарай. Аймгийн газрын зургаас ондоо кадастрын зураг зураад хаячихсан. Дэвэлийн арал гэдэг чинь Ховд голын 2 салаа дунд байдаг арал байхгүй юу. Гэтэл хаана байсан тэр Ховд багийн төвийг оролцуулаад, дээд талд нь байгаа тэр Улаан-Уул гээд байгаа байж байгаа Ямаатын уул дээр байгаа хар тугалганы үйлдвэрийг оролцуулаад ингээд Увсын газар нутаг руу оруулаад зураад хаячихаад захиргааг нь тийш өгчихсэн.

Дэвэлийн арал чинь тэнд ямар ч холбоогүй байхгүй юу. 2 Ховд голын салаа дунд байгаа юу байгаа. Тэгээд тэнд ус ашиглалтын юм гээд юу гарч байгаа, бэлчээр ашиглалт, Зөрчлийн хуулиар торгож байгаа асуудал байж байгаа. Ачит нуурын сав газраас Баян-Өлгий, тэгээд Ховд, наад талын сумууд, Баянхонгор хүртэл өвөлжингөө өвс хадаад ингээд л өвс борлуулдаг. Зудын үед Баянхонгор, Говь-Алтай хүртэл зөөсөн шүү дээ. Гэтэл энийг Зөрчлийн хуулиар мал бэлчиж байгаа газрыг нь ингээд Зөрчлийн хуулиар торгож байгаа асуудал гарч байгаа.

Тэгээд зэгс хадахыг хориглох нь зөв л дөө. Тэр чинь зэрлэг гахай байна, саяын нүүдлийн шувууд байж байна. Гэтэл энэ асуудал дээр та нар газар дээр нь очоод үзээрэй. Ногооннуур бүхэлдээ битүү цасан бүрхүүлтэй байдал хүндэрсэн, Ачит нуурын сав газрын наад талын нуурын наад талынх чинь Ногооннуур сумын харьяа байдаг байхгүй юу. Гэтэл энэ дээр маргаан үүсчхээд бараг хүн амины хэрэг гарахын даваан дээр ийм юм гараад, хэл ам гарч байгаа байхгүй юу. Энэ дээр ингээд бид бас яая, тэгээд Байгаль орчны яам, Тусгай хамгаалалттай газрынхан тэгээд манай Байнгын хорооноос юу томилоод явуулъя. Та нар газар дээр нь очоод үзээрэй. Энийг шийдэхгүй бол болохгүй нь ерөөсөө. 1 аймгийн газар нутаг дээр нөгөө аймгийнхан ирээд ингээд Зөрчлийн хуулиар торгоод байвал ард иргэдийн байдал хүнд, бид нарт бас дарамт ирээд байна. Манай аймгаас сонгогдсон 5 гишүүний хувьд бид нарт хэцүү байна. Энийг та бүгд маань анхаарч үзээд, яг тодорхой шийд гаргахгүй бол энэ үнэхээр болохгүй асуудал хүсээд байгаа асуудал. Энэ дээр анхаарч ажиллаарай.

Нөгөө талаар тэр говийн усны асуудал байж байна л даа. Одоо ингээд ураны асуудал гэхээр чинь өдөрт нь 150 вагон хүхэр шахна гэж ярьж байна. Тэгээд энэ газрын усны асуудал нэлээн хүндрэх юм шиг байна. Нөгөө талаар сая нэг нефтийн асуудал байж байна. Нүүрс уурхай ашигласантай холбоотой усны нөөц багасчихлаа гээд ярьж байна. Гэтэл энэ дээр тодорхой хэмжээний юу гээд Байгаль орчны маань Усны газартайгаа нийлж байгаад энэ тодорхой бодлогоор асуудлыг шийдэхгүй болохгүй юм шиг байна.

С.Ганбаатар: Бейсен гишүүн үг хэллээ. Ганхүлэг гишүүн үг хэлнэ.

М.Ганхүлэг: Би асуусан асуултаа тодотгоод саналаа хэлье. Үндсэндээ бид бүхэн эдийн засгийн өсөлт уул уурхай дээр суурилсан энэ Монгол Улсын хөгжлийн энэ концепцыг харж явахаасаа гадна шавхагддаг ус, агаар, энэ бэлчээр, хөрс гээд эдгээр нөөцүүдээ үндсэндээ хайрлан хамгаалах энэ чиглэлийн бодлогуудыг тодорхой болгох, дахин ашиглах, арвич хямгатайгаар хэрэглэх энэ тэр гээд энэ зохицуулалтуудыг л төр маш тодорхойгоор шийдлийг нь гаргаж өгч явж байж, урт хугацаандаа энэ маш өндөр төлбөрөөр нөхөн сэргээлгүйгээр бид бүхэн авч үлдэх энэ зохицуулалт бий болно гэдгийг хүн болгон мэдэж байгаа. Үүнтэй холбогдолтой тодорхой ажил, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаагийн нэг нь энэ хаягдал усыг дахин боловсруулахтай холбогдолтой асуудал байгаа юм байна лээ. Тэгээд энэ талаар явж байгаа сайн төсөл, арга хэмжээнүүд байна.

Өнөөдөр дэлхий нийтийн хувьд бол хотын төвийн энэ ногоон байгууламжаа гүнийхээ усаараа, цэвэр усаараа усалдаг, энэ станцууд, томоохон үйлдвэрүүд шууд ундны цэвэр усаа ашигладаг, уул уурхайн нөхөн сэргээлтдээ бид бүхэн мөн энэ шавхагддаг нөөцөө ашигладаг ийм улс үндэстнүүд үндсэндээ байхгүй болж эхэлж байна. Монгол Улсын хувьд тодорхой энэ ашигласан усаа дахин боловсруулах чиглэл дээр энэ хууль, эрх зүйн орчныг нь илүү сайжруулаад өгөх, илүү давуу байдалтай үнэ тарифын энэ дэмжлэгүүдийг үзүүлэх чиглэл дээр та бүхэн маань манлайлал үзүүлээд, энэ олон бусад яамнуудын оролцох асуудал юм. Ер нь төслийн агуулга нь тэнд яваа байх, энд яваа байх гэдэг байдлаар хандалгүйгээр энийг татаж аваад энэ 2 дахь усыг ашиглах чиглэлийн энэ хууль, эрх зүйн орчныг сайжруулах энэ зүйл дээр анхаарах нь зайлшгүй шаардлагатай байна гэдгийг би дахин, дахин хэлье.

Үнэ тарифыг нь тодорхой болгох шаардлагатай байна. Энэ хуулийг хэрэгжиж батлагдах хүртэлх хугацаанд техникийн зохицуулалтуудыг нь нарийвчлаад гаргахаас авхуулаад ингээд тодорхой зохицуулалтуудыг нь хийх тал дээр анхаарах зайлшгүй хэрэгтэй байна гэдгийг би хэлье.

Мөн дээрээс нь энэ удаагийн хурал бол 2 Байнгын хороо хамтран хэрэгжүүлж байгаа гэдэг утгаараа өндөр ач холбогдолтой гэж би харж байна. Тэр утгаараа урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгуулах шаардлагыг үндсэндээ нэлээн өндөр түвшинд авч үзээд, ААН-үүдээ энэ чиглэлийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулж байгаа энэ ААН-үүдээ дэмжих энэ асуудлыг нэлээн нарийвчлаад ингээд үзэхгүй бол яг энэ асуудлыг би Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр хариуцаж байсан. Одоогийн байгаа энэ дэмжлэг, энэ байгаа зүйлээр үндсэндээ нэлээн хугацаа алдана. ААН-үүд өөрсдөө цалин хөлсөө яах вэ, энэ байгаа орлогоо үндсэндээ юундаа зарцуулах вэ гээд ингээд явж байхад дахиад дээрээс нь

цэвэрлэх байгууламж зайлшгүй барь гэдэг энэ шахалт нь үндсэндээ тодорхой хэмжээнд нэг л болж өгөхгүй байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг Байнгын хороодынхоо түвшинд нэлээн сайн ярьж байгаад төрөөс тодорхой хэмжээнд энэ асуудал дээр нь шийдлийг нь гаргах тал дээр нь анхаарал хандуулаад, ингэж богино хугацаанд 1-ээс 2 жилийн дотор энэ шинэ төв цэвэрлэх байгууламж байгуулагдахтай хамтатгаад энэ асуудлыг нэг цэгцлэх зайлшгүй шаардлагатай байна. Ингээд яриад өнгөрмөөргүй байна гэдэг ийм тодорхой саналуудыг дэвшүүлээд байгаа юм. Тэгээд энийг ажил хэрэг болгохын төлөө та бүхэн маань гол анхаарлаа хандуулж ажиллаарай гэдгийг хэлье.

С.Ганбаатар: Ганхуяг гишүүн санал, үг хэллээ. Өнөөдөр үйлдвэрлэлийн ус ашиглалтын өнөөгийн байдлын талаарх мэдээллийг 2 Байнгын хорооны гишүүд, Монголын ард түмэнтэйгээ хамтдаа сонслоо. Хэд хэдэн оронд сүүлийн 3 жилд байгаль дэлхийн эрх гэдэг тийм зүйлийг Үндсэн хуульдаа оруулсан хууль байгаа. Испани оруулчихлаа, одоо Англи ярьж эхэлж байна. Тэгэхээр манайд өөрийгөө өмгөөлөх чадваргүй бидний нэрлэдэг чандмань эрдэнийг өм цөм дээрэлхэж ашиглаж мөнгө хийж байгаа тохиолдол хөдөө аж ахуй ч, уул уурхай ч байдаг. Технологи оруулж ир, хэмнээч л гэдэг. Хэрэглээ дээр ч ийм байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр Байгаль орчны яам ерөнхий чиг үүргийн яам байсан, тэрийг нь буулгасан. Бид чинь ерөөсөө байгалиа л дээрэлхэж сурсан ард түмэн болчихоод байна шүү дээ.

Тэгэхээр энэ Усны газрын чиг үүргийг ерөнхий чиг үүргийн байх ёстой гэж би итгэж, үнэмшдэг. Цахилгаан эрчим хүч, тэгээд л хөдөө аж ахуй, уул уурхай, хүнд үйлдвэр, хөнгөн үйлдвэр, жижиг, дунд бүгд усны тухай ярьдаг. Ингээд маш чухал зүйлээр маш чухал мэдээлэл өглөө. Байгаль орчны яамны энэ хүмүүс маань байгалийнхаа төлөө чин сэтгэлээсээ зүтгэдэг. Тэгээд ямар ч байсан гишүүд бид та нартай хамтарч ажиллана, ажлын хэсэг байгуулна. Ойрын үед энэ дээр тодорхой Байнгын хорооны шийдвэрүүд гарч, заавал хэрэгжинэ гэж бодож байна. Ингээд өнөөдөр гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

17.02 цаг

Өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Байгаль орчны нөхдөдөө баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА